



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРГЭН ШИНЖЛЭГЧЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ дээдлэх ЁС

- Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол
- Нээлттэй болон хаалттай компанид хяналтаа хадгалах компанийн эрх зүйн механизм
- Шилжих хөдөлгөөн ба Монгол Улс
- Монголд тангаргатны шүүх хэрэгтэй юу (АНУ, ОХУ-тай харьцуулсан аналитик тойм)
- Иргэний хэргийн шүүхийн зардал
- Ард нийтийн санал асуулга ба Монгол Улсын Үндсэн хууль
- Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах асуудал, тулгарч буй бэрхшээл, цаашид анхаарах зарим асуудал
- Хууль зүйн клиник сургалтын технологийн тулгамдсан асуудал
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг анхан шатны шүүхээс хэрэглэж буй практик
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.11. дүгээр зүйл болон Иргэний хуулийн холбогдох заалтуудын хэрэглээ
- Хараат бус, бие даасан байдлыг хамгаалах хариуцлагын тогтолцоо
- Захирааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын эрх зүйн зохицуулалтын талаар
- Улс төрийн намуудын байгуулсан гэрээ ба эрх зүйн зохицуулалт, хяналт

СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

<i>Ц.Шямдорж</i>	- Хууль зүй, дотоод хэргийн сайд
<i>Ц.Зориг</i>	- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
<i>Д.Дорлигжав</i>	- Улсын Ерөнхий прокурор
<i>Д.Одбаяр</i>	- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга
<i>Д.Лүндээжанцан</i>	- Улсын Их Хурлын гишүүн
<i>Ц.Мөнх-Оргил</i>	- Улсын Их Хурлын гишүүн
<i>С.Батдэлгэр</i>	- Улсын Дээд шүүхийн шүүгч
<i>Ц.Шаравдорж</i>	- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга
<i>П.Цагаан</i>	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх
<i>Б.Долгор</i>	- Монгол Улсын Ерөнхий сайдын хуулийн зөвлөх
<i>Ж.Бямбадорж</i>	- Хүний эрхийн үндэсний комиссын дарга
<i>Г.Баясгалан</i>	- ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
<i>Б.Пүрэвням</i>	- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
<i>Ч.Отгонбаяр</i>	- Монголын Нотариатчдын Танхимийн Ерөнхийлөгч
<i>Д.Батжаргал</i>	- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
<i>Ж.Амарсанаа</i>	- Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал
<i>С.Нарангэрэл</i>	- МУИС-ийн ХЗС-ийн захирал
<i>Д.Сандаг-Очир</i>	- Цагдаагийн ерөнхий газрын дарга
<i>Д.Зүмбэрэлхам</i>	- Төрийн албаны зөвлөлийн дарга
<i>Д.Сугар</i>	- Төрийн өмчийн хорооны дарга

СЭТГҮҮЛИЙН ШИНЖЭЭЧ ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ

<i>С.Жанцан</i>	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор
<i>Ч.Энхбаатар</i>	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор
<i>Ш.Чоймаа</i>	- Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор
<i>Б.Амарсанаа</i>	- Хууль зүйн доктор
<i>Б.Гүнбилэг</i>	- Хууль зүйн доктор
<i>Б.Тэмцүлэн</i>	- Хууль зүйн доктор
<i>Г.Банзрагч</i>	- Хууль зүйн доктор
<i>Д.Баярсайхан</i>	- Хууль зүйн доктор
<i>Т.Мэндсайхан</i>	- Хууль зүйн доктор

ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ЗӨВЛӨЛ

<i>Хүндэт зөвлөх:</i>	Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Б.Чимнд
-----------------------	---

Ерөнхий эрхлэгч: Д.Батжаргал
Эрхлэгч: Хууль зүйн доктор Б.Гүнбилэг
Хариуцлагатай
нарийн бичгийн дарга: С.Алтантуяа
Эрхлэн гаргагч:
Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай-7
Утас: 315736, 99083007 Факс: 315736
Вэб сайт: www.legalinstitute.mn
И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn
Улсын бүртгэлийн дугаар: 279

Мэндчилгээ

Хууль зүйн салбартай ажил, амьдралаа холбосон үе үеийн ахмадууд, тус салбарын нийт хамт олон Та бүхэндээ Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувьсааа Монголын хуульчдын өдрийн баярын мэнд дэвшүүлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.



Энэ онд Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, Ардын хувьсгалын 90 жил, Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 100 жил, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хил хамгаалах байгууллагын 90 жилийн ой давхар тохиож байгаа бөгөөд тус салбар нь түүхэн хөгжлийнхөө явцад төр улсын тогтвортой байдал, ард түмнийхээ амгалан амьдралын баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, эрх зүйг шинэтгэх, хэрэгжилтийг нь хангахын төлөө үе үеийн хуульчдын шаргуу хөдөлмөрийн үрээр хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж байгааг онцлон тэмдэглэе.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байх Үндсэн хуулийн зарчмаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, хүн амд үзүүлэх эрх зүйн үйлчилгээг зохион байгуулах, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд Хууль зүй, дотоод хэргийн яам харъяа агентлаг байгууллага, шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагын ажилтан, албан хаагчдын гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байна.

Нийт хамт олондоо Монгол Улсын эрх зүйн бодлогыг тодорхойлон боловсруулах, хэрэгжилтийг нь хангах, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх өндөр хариуцлага, нэр хүндтэй ажил үйлсдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ЕРӨНХИЙ ЭРХЛЭТЧИЙН ЗУРВАС

Эрхэм уншигч таны амар амгаланг айлдан мэндчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхаглагдсан хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн орчин үеийн төр, эрх зүйн хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцүүлэн хууль хяналтын байгууллагуудыг шинэчлэн хөгжүүлэх, шударга ёс, хүний эрхийн баталгаа болгон төлөвшүүлэх, хөгжингүй улс орнуудын жишигт хүргэх нь хуулийн байгууллагын ажилтнууд, хуульч бидний хэтийн зорилго эрмэлзэл байх бөгөөд энэхүү эрхэм үүргээ хэрэгжүүлж чадна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлэхэд таатай байна.

Ялангуяа төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийг өнгөрсөн, одоо, ирээдүйн хэлхээ холбоонд нь ерөнхий болон тусгай онолын хүрээнд тандан судалж, түүний уламжлал, шинэчлэлийн диалектикийг тодруулан, өнөөгийн хүрсэн түвшинг үндэсний түүхэн уламжлал, хүн төрөлхтний төр, эрх зүйн сэтгэлгээний ололт, түгээмэл үнэт зүйлстэй хошуулан судлах асуудал чухлаар тавигдаж байна. Манай сэтгүүлийн ерөнхий зөвлөлийг өргөтгөн шинэчлэх санаачлагыг гаргасан Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын өмнө сэтгэлгээний шинэтгэлийг хийх зорилт дэвшүүлсэн нь мөн дээрх асуудалтай санаа нэг юм.

Хууль, эрх зүйн салбар дахь судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтны үргэлжилсэн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, багш, оюутны эрдэм шинжилгээний ажлыг нийтлэх, тэдний бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлэх, эрх зүйн шинжлэх ухааны болон хууль зүйн бодлогын тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, сургалтын чанар, түвшинг дээшлүүлэх, хууль зүйн судалгааг хүртээмжтэй байдлаар хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн бие даасан байдлыг хангаж, сэтгүүлийн үйл ажиллагаа, цар хүрээ, агуулгыг улам сайжруулах зорилгоор өргөн бүрэлдэхүүнтэй “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн Ерөнхий зөвлөл, Шинжээч эрдэмтдийн зөвлөлийг бүрдүүлсэн нь хууль сахиулах байгууллагуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн хамтын ажиллагааг нягтруулан уялдуулах, эрдэмтэд, шинжээч, судлаачид, хуульчдын дунд шинжлэх ухаанч маргаан, мэтгэлцээнийг өрнүүлэх оюуны индэр болгохыг эрмэлзэж байгаагийн илэрхийлэл юм.

2011 онд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100 жилийн ой, Хууль зүйн алба байгуулагдсаны 100 жилийн ой тохиож буй энэ үед Монголын хууль, эрх зүйн хувьд шинэчлэлийн онцгой үйл явдлууд дүүрэн өрнөж байгаа билээ.

Монгол Улсын хууль, эрх зүйг улам боловсронгуй болгож шинжлэх ухааны хувьд гүнзгийрүүлэн өөрийн гэсэн онцлог бүхий орчин үеийн, уян

хатан, шударга ёс, үнэний бие даасан тогтолцоо бүрдүүлэх үйлсэд “Хууль дээдлэх ёс” сэтгүүл хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Сэтгүүлийн анхны дугаараас хойш бидний ажлыг дэмжиж, хамтран ажиллаж байгаа эрдэмтэн судлаачид, хуульчид, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, багш, оюутан, тэр дундаа уншигч Танд гүнээ талархаж буйгаа илэрхийлье.

Энэ дугаартаа бид та бүхэндээ уламжлалт ёсоор эрх зүйн онолын шинэ сэдвүүд, сүүлийн үеийн судалгаа, мэдээ, мэдээллийг санал болгож байна.

Мэргэн уншигч та болгооно уу.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ
Д.БАТЖАРГАЛ

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Цуврал 33

2011 он, Зургадугаар сар

№2

АГУУЛГА

ХҮҮДАС

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт хууль зүйн шинжлэх ухааны үүднээс онол, арга зүйн дүн шинжилгээ хийх нь 5

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,
хууль зүйн доктор Х.Сэлэнгэ

Нийтийн эрх зүйн мөн чанар, онцлог 19

Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, докторант
Ч.Хосбаяр

Тагнуул хийх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын асуудал 25

Үндэсний тагнуулын академийн дэд захирал,
профессор М.Цогтсэл

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөлөл 36

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш,
докторант Д.Хуяг

Судалгааны тайлан

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа 43

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах зорилгоор хийсэн судалгаа 74

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Үзэл бодол, эргэцүүлэл

Субъектив эрх ба хууль ёсны ашиг сонирхол	121
ХЗҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир	

Шүүхээс хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах нь хэнд хэрэгтэй вэ?	126
Баян-Өлгий аймгийн прокурор, магистр Т.Батсүх	

Эзэмшил, өмчлөлийн харьцуулалт	135
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант Ц.Давхарбаяр	

Хууль зүйн албаны 100 жилийн ойд	142
---	------------

Мэдээ, мэдээлэл	145
------------------------	------------

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

CONTENTS

PAGE

Article

- Theoretical and Methodical Analysis of
Section 15.6 of Law on Political Party of
Mongolia** 5

Selenge.Kh. Ph.D, Lecturer of School of Law, National
University of Mongolia

- Characteristic Feature and the Nature of the
Common Law** 19

Khosbayar.Ch, Ph.D candidate, Judge of Court of
Sukhbaatar District

- Legal Regulations on Crime of Espionage** 25

Tsogtoo.M. Professor, Vice-Principal of
National Intelligence Academy

- Representation in Civil Proceedings** 36

Khuyag.D. Ph.D candidate, Lecturer of
School of Law, National University of Mongolia

Research Report

- Research Conducted During the Drafting
Process of Revised Law on Traffic Safety** 43

Research Report by National Legal Institute

- Research on Draft Amendment to the
Citizenship Law** 74


Research Report by National Legal Institute

Notes

- Subjective Right and Legitimate Interest** 121

Tamir.D, Researcher of Civil and Economic
Law Sector, National Legal Institute

- To Whom Is It Crucial a Court For the
Investigation or Inquiry Stage** 126



Batsukh.T, Prosecutor of Bayan-Ulgii Aimag

Comparison of Possession and Ownership 135

Daykharbayar.Ts, Ph.D candidate,

Lecturer of School of Law,

National University of Mongolia

The 100th Anniversary of the Justice Sector 142

News and Events 145

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХҮҮЛИЙН 15 ДУГААР ЗҮЙЛИЙН
15.6 ДАХЬ ХЭСЭГТ ХҮҮЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮҮДНЭЭС
ОНОЛ, АРГА ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ**

Орчин үед аливаа нийгэм, улс төрийн оршин тогтох үндсийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал хэмээн үздэг. Германы сонгодог философич Ф.Гегелийн хэлсэнчлэн: “бодит бүхэн зохистой, зохистой бүхэн бодитой”, “гадаад ахуй бол эрх чөлөөний гадаад ахуй” билээ. Өөрөөр хэлбэл, бодит гэдэг нь үзэл санааны гадаад ертөнц дэх илрэл юм. Мөн “төрийн оршин тогтнол бол ертөнц дэх бурханы зорчилт бөгөөд түүний үндэслэл нь өөрийгөө хүсэл зориг болгон хэрэгжүүлж буй оюун санааны хүч”¹ учраас “хэрвээ тухайн төр ард түмний оюун санаанд нийцэхгүй бол “муу” төр бөгөөд хэзээ нэгэн цагт нурж унах нь гарцаагүй бөгөөд жинхэнэ төр нь хүний эрх, эрх чөлөөний биелэл байдаг тул зохистой бөгөөд бодитой байдаг” юм.



МҮИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн доктор Х.Сэлэнгэ

Монгол Улс 1990 оноос хойш хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн зохистой (ухаалаг) төрийг бий болгохыг эрмэлзэж, 1992 онд хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Үндсэн хууль баталж, түүнийг хамгаалан хэрэгжүүлэхийн тулд Үндсэн Хуулийн цэцийг байгуулсан билээ.

Германы сонгодог философич Ф.Гегель “хууль тогтоох явцад хууль агуулгаасаа гажих тохиолдол байдаг тул хууль бүхнийг эрх зүй гэж үзэж болохгүй”² хэмээн үзсэнээр хууль тогтоох байгууллага нь улс төрийн шинжийг агуулж байдаг тул эрх зүйн хийдэлтэй, зарим тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарласан эрх зүйн бус хэм хэмжээг тогтоох явдал цөөнгүй байдаг. Тэрхүү агуулгаасаа гажсан, эрх зүйн бус хэм хэмжээг илрүүлэх үүрэг нь хуульчдийнх, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн хэм хэмжээг хүчингүй болгож, Үндсэн хуулийг хамгаалах нь Үндсэн Хуулийн цэцийн үүрэг мөн.

Монгол Улсын Их Хурал нь Үндсэн Хуулийн 1-д: “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 10.2-д: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 10.3-д: “Монгол Улсыннэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалтуудыг зөрчин, Үндсэн хуулийн 19.2-д: “Онц байдал болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн

¹ Гегель Ф. (1990) *Философия права* Соч. Т-VII. С. 268.

² Тихомиров Ю. В. (1997) *Основы философии права* М. С. 455.

хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэсэн заалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлан 19.1-д заасан: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн үүргээ умартан, хүний халдашгүй дархан эрхтэй байх, үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн “Улс төрийн намын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “нам... өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... гишүүнчлэл, ... нэр... г дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн хэм хэмжээг тогтоосон байна.

МУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн талаар улс төрийн намууд, хуульчид янз бүрийн байр суурьтай байна. Гэхдээ хууль нэг мөр ойлгогдон хэрэгжиж байх ёстой. Иймд МУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “нам... өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... гишүүнчлэл, ... нэр... г дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь Үндсэн хуультай нийцэж байна уу?, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байна уу? гэдэгт хууль зүйн шинжлэх ухааны үүднээс онол, арга зүйн дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна.

А. МУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгийг хууль зүйн шинжлэх ухааны эрх зүйн онолын үүднээс шинжлэн үзвэл:

“Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлэгдэл, далбааг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн заалтын:

Хориглосон диспозицийн хэрэгжих нөхцөл заасан хэсэг нь “нам” энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд:

Объект нь өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлэгдэл, далбаа, объект болох “гишүүнчлэл” гэдэг үгийг хэл шинжлэл, хуульд заасны дагуу утгыг нь авч үзвэл: “Гишүүнчлэл” гэдэг үг нь монгол хэлний толь бичигт байхгүй, монгол хэл шинжлэлийн үг бүтээх тогтсон загварыг зөрчсөн, зохиомол нэр үг байна. “Гишүүн” гэсэн нэр үгэнд “чил” гэсэн дагавар залгаж “гишүүнчилэх” гэсэн үйл үг болоод, дараа нь “л” үсэг залгаж “гишүүнчлэл” гэсэн нэр үг

бий болгожээ. Иймд монгол хэлний толь бичигт нэр үгэнд залгасан “чил”, “л” дагаваруудтай үгнүүдтэй харьцуулан үгийн утгыг гаргаж байна. “Чил” гэсэн дагавар бол тухайн зүйлийг онцлох шинжтэй болгох, эрхлэх гэсэн үйл үгийн утгыг илэрхийллэг байна.³ Жишээ нь: Ардчилал гэсэн үгний үг бүтээх загварыг харахад “ард” буюу олонхи гэсэн утга бүхий үгэнд “чил” дагавар залгаж “ард болгох” гэсэн үйл үг бүтээгээд, “лал” дагавар залгаж олонхи болгох буюу олонхийн байх, олонхийг оролцуулах гэсэн утга бүхий үг бий болжээ. Мөн “боолчлол” гэдэг үгний үг бүтээх загварыг харахад “боол” гэсэн нэр үгэнд “чил” дагаварыг залгаж, боолчиллох буюу “боол болгох” гэсэн үйл үг бий болсон байх ба түүнд нь “л” үсэг залгаж “боолчлол” буюу боол болгох үндсэн утга санааг илүү тодруулсан байна. Иймд “гишүүнчлэл” гэсэн үг нь “гишүүн” (салаа мөчир) буюу намын гишүүн (намд элссэн хүн) гэсэн нэр үгэнд “чил” дагавар залгаж “гишүүнчлэх” буюу гишүүн болгох гэсэн үйл үгийг бүтээгээд “л” үсэг залгаж, “гишүүнчлэл” буюу тухайн намын гишүүн байх гэсэн харьяалалыг заасан утга бүхий үгийг бүтээсэн гэж үзэж болохоор байна. Энэхүү үзэл санаа МУ-ын Нэгдсөн Монгол Улсын иргэний эрх-ээр баталгаажиж байна. 3.1-д: “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй”. 3.4-д: “Хуульд заасны дагуу төрийн зарим албан хаагчийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлж болно” гэж заасан байна. Улс төрийн намын тухай хуульд зааснаар намын гишүүн нь төрийн албан хаагч бол намын гишүүн байхаас түдгэлзүүлэхээр заажээ. Иймд гишүүнчлэл гэдгийг намын гишүүн байх эрх гэж үзэх нь байна.

Объект болох “намын нэр” гэдэг нь МУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 6.1-д зааснаар оноосон нэр бөгөөд 4.1-д: “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу *нийгмийн ашиг сонирхол болон хувийн цээл бодол, улс төрийн цил ажиллагаа явуулах зорилгын цүднээс сийн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн*”, МУ-ын Иргэний хуулийн 27.1-д: “Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна” гэж зааснаар үзэл бодлоороо нэгдсэн иргэдийн нэгдлийн нэр буюу зохион байгуулалтын хэлбэр тул намын нэрийг үзэл санааны илрэл гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Жишээ нь, либерал үзэл санааны үүднээс эвлэлдэн нэгдсэн Монголын Либерал Нам, ардчилалын онол, үзэл санаагаар эвлэлдэн нэгдсэн Монголын Ардчилсан Нам гэх мэтээр намын нэрэнд үзэл

³ (1998) *Монгол хэлний үгсийн язгуурын толь* Хөх хот. 2822.

санаа нь илэрхийлэгдэж байна. Мэдээж либерал үзлийг баримталдаг Монголын Либерал Нам Либертари ч юм уу, эсвэл Уламжлалын нэгдсэн намын нэрийг хэрэглэхгүй нь тодорхой юм. ОХУ-ын Пивонд дуртай хүмүүсийн нам ("Партия любителей пива") бол пивонд дуртай гэдгээрээ (винонд дуртай гэдгээрээ бус, пивонд дуртай байж, винонд дуртай хүмүүсийн нам гэж нэрлэгдэхгүй нь ойлгомжтой) нэгдэж, уг нэрийг авчээ.

Намын нэр өмч мөн үү? Аль нэг субъектэд үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрөх буюу хориглох, өмчлүүлэхийг зөвшөөрөх буюу хориглох эрх зүйн үндэслэл байна уу?

Өмчлөх эрхийн онолын үүднээс авч үзвэл эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн түүхэнд эрх зүйн харилцааны объект болох өмчийг хүний оюуны болон материаллаг үйл ажиллагаа, хөдөлмөрийн үр дүнд бий болсон гэсэн үзэл санаа хөгжиж ирсэн. Энэ тухай өмчлөх эрхийн сэтгэлгээний хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан сэтгэгч Ф.Бастия "...өөрт заяасан авъяас чадвараар байгалийн эд баялагтай уйгагүй харьцсанаар хэрэгцээгээ хангана. Энэ явц бол өмч хөрөнгийн эх үүсвэр мөн"¹ гэжээ. Энэ үндсэнд өмчлөх эрхийн хөдөлмөрийн онол одоог хүртэл хөгжиж байна.

Академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг"-т: "1. өргөн утгаараа үйлдвэрлэлийн хэрэгсэл ба хэрэглээний зүйл олж авахаар тодорхойлогдох үйлдвэрлэл, хуваарилалт, солилцоо, хэрэглээний явцад хүмүүсийн хоорондын объектив түүхэн өөрчлөгдөх харилцааны тогтолцооны эдийн засгийн ухагдахуун, 2. тодорхой этгээд болох хувь хүн буюу хамт олонд тодорхой нөхцөл ба тодорхой хэлбэрээр эд хөрөнгө хамаарахыг илэрхийлсэн хууль зүйн ухагдахуун" гэж үзсэн байна.² Монголын нэртэй хуульчид болох хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд, хууль зүйн шинжлэх ухааны доктор Н.Жанцан, Академич Ю.Амарсанаа, хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан нарын туурвисан МУ-ын Үндсэн хуулийн тайлбар бүтээлд: "Өмч гэдэг нэр томъёо өргөн утгаараа материал баялгийг өөрийн болгох, үйлдвэрлэх, хуваарилахад зориулагдсан хүмүүсийн хоорондын харилцаа бөгөөд түүнээс өмчийн эрх үүсэн гардаг...Өмч гэдэг нэр томъёог явцуу утгаар ойлгоход хөрөнгө гэж нэрлэдэг"³ гэснээс үзвэл өмч гэдэг нь үндсэндээ эдийн засгийн агуулгатай байна.

Намын нэр оюуны өмч мөн үү? Орчин үед оюуны өмчид нэг талаас оюуны бүтээл зохиогчидийн бүтээл, түүний эрхийн асуудлыг, нөгөө талаас аж үйлдвэрийн оюуны өмчийн эрхийг хамгаалах патентын эрхийн асуудал орж байдаг бөгөөд энэ нь үндэсний болон олон улсын

¹ Агар-Эрдэнэ Г. (2009) *Хувийн өмчийн онол* Уб, 59.

² Нарангэрэл С. (2007) *Эрх зүйн эх толь бичиг* Уб, 364.

³ (2000) *МУ-ын Үндсэн хуулийн тайлбар* Уб, 42.

эрх зүйн хүрээнд тогтсон ойлголт юм. Энэ тухай Э.Мягмардоржийн "Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд" бүтээлд: "Орчин үед оюуны өмч хоёр салбартай гэдэгтэй хэн ч маргадаггүй. Нэг талаас оюуны бүтээл зохиогчид бүтээл ашиглах онцгой эрхтэй байдаг. Энэ эрх нь бүхэлдээ өмчийн эрхтэй адил эд хөрөнгийн эрхэд хамаардаг. Нөгөө талаас эзэмшигчдээс үл салгаж болох зохиогч байх эрх, зохиогчийн нэр хэрэглэх эрх зэрэг эд хөрөнгийн бус амины цогц эрхтэй байдаг. Эдгээр эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины эрхийн хооронд хязгааргүй зааг байхгүй, харин ч харилцан хамааралтай, нягт холбоотой нэгдмэл байдлыг бий болгодог. Ийм учраас оюуны өмч гэдэгт оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон, түүнтэй адил төстэй иргэний гүйлгээнд оролцогчдын бараа, үйлчилгээг ялгахад хэрэглэх объект дахь онцгой эрхийн нийлбэрийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, оюуны өмч гэдэг нь үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологи, урлаг, утга зохиол зэрэг салбарт шинэ зүйл бүтээгчийн эрх юм"⁷ гэжээ.

Монгол Улс 1979 онд гишүүнээр элссэн Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагыг байгуулах тухай олон улсын конвенцид оюуны өмч гэсэн ойлголтод багтах объектын тухай заахдаа:

1. Шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээл;
2. Уран бүтээлчдийн тоглолт, дуу авианы бичлэг, шугамаар нэвтрүүлэх;
3. Хүний хэрэгцээний бүх салбар дахь шинэ бүтээл;
4. Шинжлэх ухааны нээлт;
5. Бүтээгдэхүүний загвар;
6. Барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, худалдааны нэр, илэрхийлэл;
7. Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах болон үйлдвэрлэл, шинжлэх ухаан, уран зохиол, уран сайхны салбарт оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон бусад зүйлд хамаарах эрхийг агуулна гэж оюуны өмчийн агуулгыг олон улсын түвшинд тодорхойлжээ.

Дээрхээс үзвэл намын нэр оюуны өмч биш бөгөөд аливаа нам, намын нэрийг өмчлөх ойлголт байж болохгүй нь. Өөрөөр хэлбэл, нам өөрчлөгдсөн, нэрээ өөрчилсөн тохиолдолд нэрээ өөрчилсөн нам болон бусад нам нэрийг өмчлөх эрхгүй байна. Учир нь намын нэр өмч биш, харин үзэл санаагаараа нэгдсэн хүмүүсийн үзэл санааны илэрхийлэл, оноосон нэр юм.

Иймд гишүүнчлэл, намын оноосон нэрийг өмч хэмээн үзэх үндэслэл байхгүй байна. Өөрөөр хэлбэл, намын гишүүдийн татвар, хандиваас бүрдсэн өмч хөрөнгийг өмч гэж үзэж болох боловч намын гишүүнчлэл (намын гишүүн байх эрх), намын үзэл санааны илэрхийлэл болсон оноосон нэрийг өмч гэж үзэх эдийн засаг, хууль зүйн үндэслэл

⁷ Мягмардорж Э. (2003) Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд УБ, 5.

байхгүй байна. Гишүүнчлэл, оноосон нэр нь өмч биш тул эдгээрийг өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрөх буюу хориглох гэсэн хууль зүйн ойлголт ч бас байхгүй.

Субъект нь дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус (өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн) намын гишүүн, бусад иргэн, хуулийн этгээд.

Субъект болох оорчлон байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн гэдэг нь үзэл санааны хувьд зөрчил, ялгаатай тухайн намын гишүүн байгаа субъект, өөрөөр хэлбэл намын шийдвэртэй санал нийлээгүй боловч тухайн намын гишүүнээс татгалзаагүй субъект байна.

Бусад иргэн гэдэг нь өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн намын гишүүн бус, 18 насанд хүрсэн, эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээх эрх зүйн чадвартай (улс төрийн эрх, эрх чөлөөний эрхтэй) эрх зүйн этгээд, МУ-ын иргэн байна.

Хуулийн этгээд гэдгийг авч үзвэл: эрх зүйн харилцааны субъект, өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхлээ тусгайлан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг хариуцах чадвартай, нэхэмжлэгч хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэж хууль зүйн шинжлэх ухаан үздэг. Хуулийн этгээд нь тодорхой материалаг болоод материалаг бус зорилгын үүднээс нэгдсэн зохион байгуулалтын нэгдэл байна. МУ-ын Иргэний хууль (26.1) болон Улс төрийн намын тухай хуульд (9.6) зааснаар нийтийн болон хувийн эрх зүйн субъект болох хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь эрх бүхий байгууллагад бүртгүүлсэнээр үүсдэг. МУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 8.1-д: "Намыг зохион байгуулах Их хурал (цаашид үүсгэн байгуулах хурал гэх)-аар үүсгэн байгуулна", 8.4.1-д: "намыг үүсгэн байгуулах-хурлаар... намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбааны загварыг батлах". 8.4.4-д: "нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах". 8.5-д: "Намыг үүсгэн байгуулах хурлаас нам үүсгэн байгуулсан тухай шийдвэр гарсан өдрийг тухайн нам үүсэн байгуулагдсан өдөрт тооцох". 9.1-д: "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14.1-д заасны дагуу тухайн нам үүсгэн байгуулагдсан өдрөөсөө хойш ажлын 10 хоногт багтаан бүртгэх байгууллагаас баталсан маягтын дагуу бүртгүүлэх өргөдлөө Улсын дээд шүүхэд гаргана". 9.3.7-д: "намын 801 -ээс доошгүй гишүүний бүртгэл" гэсэн заалтуудаас үзэхэд: "801-ээс доошгүй иргэд үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэж, үүсгэн байгуулах хурлаараа нам байгуулах шийдвэрээ баталсан бол үүсгэн

8 Нарангэрэл С. (2007) *Эрх зүйн эх толь бичиг* УБ, 546.

Иргэний хууль-25.1.

байгуулагдсан нам гэж тооцогдон хуулийн этгээд буюу улс төрийн зорилгын үүднээс үзэл бодлоороо эвлэлдэн нэгдсэн иргэдийн зохион байгуулалтын нэгдэл” гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Хориглосон диспозиц нь өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн намын өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлгэдэл, далбааг дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

Б. МҮ-ын Үндсэн хуулийг онол, хэм хэмжээний үүднээс авч үзвэл:

1. Намын гишүүнчлэлийг намын өмч, хөрөнгөтэй адилтган объект болгон үзсэн заалт нь МҮ-ын Үндсэн хуулийн заалттай нийцэж байна уу?, хүний халдашгүй эрх, эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн байна уу?, нам өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд намын шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүний “гишүүнчлэлийг буюу гишүүн байх эрх”-ийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь МҮ-ын Үндсэн хуулийн 14.2: “хүнийг...үзэл бодол...р нь ялгаварлан гадуурхаж үл болно”, 16.10: “эвлэлдэн нэгдэх эрхтэй”, 16.13: “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй” гэсэн заалтуудтай зөрчилдөж байна уу?

МҮ-ын Үндсэн хуулийн үүднээс авч үзвэл: МҮ-ын Үндсэн хуулийн II бүлгийн 16 дугаар зүйлийн 10-т “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж хүний үзэл бодлоороо сайн дурын үндсэнд намд эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулж өгсөн байна. Мөн 16.13-д: “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй” гэж хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулжээ.

Үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс авч үзвэл: хүний эрхийн нэг салшгүй эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүндээ итгэл үнэмшилтэй байж, үзэл бодлоороо тайван замаар, сайн дурын үндсэн дээр, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх юм. Энэхүү эрх нь хүний чөлөөт хүсэл зоригийн үндсэн шинж болох эрх чөлөөний илэрхийлэл тул хүний үндсэн эрх, эрх зүйн үнэт зүйл хэмээн үзэж, төрөөс хамгаалагдаж байдаг билээ. Иймд аливаа ардчилсан ёсны зарчмыг тууштай баримталсан улс орны Үндсэн хуулиудад үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн байгууллагад сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй хэмээн заасан байдаг. Хүний халдашгүй эрх, эрх чөлөөний үүднээс эвлэлдэн нэгдсэн намын гишүүдийн эрхийг аль нэг намд албадан харъяалуулж, эвлэлдэн нэгдэх эрхийг хориглосон

заалт байж болохгүй. Иймд аливаа намд үзэл бодлоороо нэгдэж, сайн дурын үндсэнд гишүүнээр элсэн орно гэдэг нь эвлэлдэн нэгдэх эрхийн илэрхийлэл. Намд сайн дурын үндсэнд эвлэлдэн нэгдэж гишүүн болсон бол, мөн үзэл бодлоороо нийлээгүй бол сайн дурын үндсэнд гишүүнээс гарах эрхтэй гэсэн үг. Өөрөөр хэлбэл, гишүүнчлэл нь намын гишүүдийн намын харъяалалыг зааж байгаа тул намын гишүүдийн намд байх эрх буюу гишүүнчлэл (намын харъяалал)-ийг өмч хөрөнгөтэй адилтган авч үзэж болохгүй. Гэтэл энэхүү эрхийг үзэл бодлоороо нэгдээгүй тохиолдолд албадан аль нэг намд гишүүнчлэлийг өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрөх, эс бөгөөс аль нэг субъектэд өмчлүүлэх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох гэсэн ойлголт хууль зүйн хүрээнд байж болохгүй бөгөөд энэ нь хүний эрх, эрх чөлөөтэй зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, гишүүнчлэл буюу гишүүн байх эсэх нь хувь хүний өөрийнх нь эрхийн асуудал. Энэ эрхийг өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэх ойлголт байх нь хүний эрх, эрх чөлөөнд халдсан хэрэг. Намын гишүүн байх гэдэг хувь хүний эвлэлдэн нэгдэх эрх юм.

Нам өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд уг шийдвэртэй санал нэгдээгүй, өөрөөр хэлбэл, үзэл санааны ялгаатай байгаа гишүүд тухайн намд нэгдэхгүй байх эрхтэй бөгөөд албадан гишүүн болгож, нэг намд гишүүнчлэлийг өмчлүүлэх, үргэлжлүүлэн хэрэглүүлэх хууль зүйн үндэслэл байхгүй байна. Харин үзэл бодлын үүднээс эвлэлдэн нэгдсэн нам нь өөрчлөгдсөн болон нэрээ өөрчилсөн (үзэл санаа нь өөрчлөгдсөн тул өөрчлөн байгуулагдсан, нэрээ өөрчилсөн) тохиолдолд санал нийлээгүй гишүүд тухайн намаас гарч, дахин эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх эрхтэй юм.

Иймд *нэгдүгээрт*: намын гишүүнчлэлийг буюу гишүүн байх эрхийг намын өмч, хөрөнгийн адил объект болгон үзсэн заалт нь МУ-ын Үндсэн хуулийн 1.2-д: “Ардчилсан ёс, ...эрх чөлөө... төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим”, 16.10- д “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээссайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй, 16.13-д: “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”, 19.1-д: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн... баталгааг бүрдүүлэх...үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтуудтай зөрчилдөжээ.

Хоёрдугаарт: нам өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд уг шийдвэртэй санал нэгдээгүй, тухайн намын гишүүнээс татгалзаагүй тус намын гишүүний гишүүнчлэлийг буюу гишүүн байх эрхийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь МУ-ын Үндсэн хуулийн 14.2-д заасан: “Хүнийг...үзэл бодол...р нь ялгаварлан гадуурхаж үл болно”, 16.10- д заасан: “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээссайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй” зөрчилдөж байна. Санал нийлээгүй намын гишүүний

гишүүнчлэлийг буюу гишүүн байх эрхийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно гэснээр намын гишүүн байж болохгүй гэсэн заалт болж байна. Ийнхүү хувь хүний сайн дурын үндсэнд эвлэлдэн нэгдэх эрх буюу гишүүнчлэлийг (гишүүн байх эрхийг) хуульчлан, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж, гишүүнчлэлийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь хүний эрх чөлөөнд халдсан хэрэг болж байна.

Гуравдугаарт: бусад иргэн тус намын гишүүн бус, намд элсээгүй байгаа тул гишүүн байх эрхийг үргэлжлүүлэн хэрэглэх гэдэг ойлголт байхгүй. Мөн гишүүнчлэл нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийн илрэл, намын гишүүн байх эрх, гишүүний харьяалалын асуудал тул үүсгэн байгуулагдсан нам буюу хуулийн этгээдийн хувьд гишүүнчлэлийг үргэлжлүүлэн хэрэглэх гэсэн ойлголт байхгүй.

Олон улсын эрх зүй. Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн гэрээ, конвенцийн үүднээс авч үзвэл: МУ 1961 онд НҮБ-д элсэж, НҮБ-аас 1966 онд баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-д 1974 онд нэгдэн орсоноор НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1948 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаг”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт” -ийг сахин биелүүлэх үүрэг хүлээсэн учир МУ-ын ҮХ-ийн 10-р зүйлийн 2-д: “МУ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3-д: “МУ-ын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан билээ. Гэвч МУ-ын “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 6-д: “нам... өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний...гишүүнчлэл,.....нэр... г дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн нь 1948 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаг”-ийн 2 дугаар зүйлд: “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямарч ялгаваргүйгээр, ...улс төрийн болон бусад үзэл бодол,бусад ялгааг эс харгалзан адилхан эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүний харьяалдаг улс орон буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй буюу олон улсын статус ямарч байлаа гэсэн,...ямарч байдлаар хязгаарлагдмал байсан, хүнийг ялгаварлаж үл болно”, “Хүн халдашгүй дархан эрх, эрх чөлөөтэй”, 20 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалт, 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ийн 19 дүгээр зүйлийн 1-д: “Хүн бүр өөрийн санал бодлыг чөлөөтэй баримтлах эрхтэй”, 22 дугаар зүйлийн 1-д: “Хүн бүр үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах болон өөрийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд тийм байгууллагад элсэх эрхийг оролцуулан бусадтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн

заалтуудыг зөрчсөн байна. 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ийн 22 дугаар зүйлийн 2-д: “Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд улсын буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт байж болохгүй” гэж заасан бөгөөд нам нь өөрчлөн байгуулагдсан болон нам нэрээ өөрчилсөн тохиолдолд санал нэгдээгүй гишүүдийн эрхийг хязгаарлах, өмч хэмээн үзэх эрх зүйн ямар нэгэн үндэслэлгүй.

Хууль зүйн фактын үүднээс авч үзвэл: МАХН нь өөрчлөгдөн шинэчлэгдэж, нэрээ МАН гэж өөрчилсөн бөгөөд тус намын үзэл баримтлалын өөрчлөлт, нэр өөрчилсөнтэй санал нэгдээгүй гишүүд МАН-д ч байгаагаас гадна зарим нь МАН-аас салж, хуучин МАХН-аа үзэл бодлоороо нэгдэж байна. Энэ тохиолдолд МАХН-д нэгдсэн гишүүдийг албадан МАН-амын гишүүн гэж үзэх юм уу, гишүүнчлэлийг МАХН, МАН-амд аль алинд өмчлүүлж болохгүй, хүний халдашгүй эрх, эрх чөлөөнд халдсан заалт байх бөгөөд гишүүнчлэлийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж байна.

Дээрхи нотолгоонд үндэстэн, аливаа нам нь намын гишүүнчлэлийг өмчлөх эрхгүй бөгөөд хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах хууль зүйн үндэслэлгүй.

2. Өөрчлөн байгуулагдаж, нэрээ өөрчилсөн намын нэрийг өөрчлөгдөн, нэрээ өөрчилсөн намд өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрч, бусад субъектэд үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь МУ-ын Үндсэн хуулийн заалттай нийцэж байна уу?

МУ-ын Үндсэн хуулийн үүднээс авч үзвэл: МУ-ын Үндсэн хуулийн II бүлгийн 16 дугаар зүйлийн 10-т заасан “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж үзсэнийг авч үзвэл нам нь үзэл бодлын үүднээс сайн дураар эвлэлдэн нэгдсэн иргэдийн нэгдэл буюу хүний үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх эрхийн илэрхийлэл нь нам байна. Намд иргэд үзэл санаагаараа эвлэлдэн нэгддэг тул намын нэр нь тухайн намын үзэл санааны илэрхийлэл гэдгийг дээр тодорхой дурдсан.

Мөн МУ-ын Иргэний хуулийн 27.1-д: “Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна” гэснээрээ намын нэр нь үзэл санаагаараа нэгдсэн нэгдлийн зохион байгуулалтын хэлбэр болохыг баталж байна.

Олон улсын эрх зүй, Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн гэрээ, конвенцийн үүднээс авч үзвэл: 1948 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаг”-ийн 2 дугаар зүйлд: “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямарч ялгаваргүйгээр, ...улс төрийн болон бусад үзэл бодол, ...бусад ялгааг эс харгалзан адилхан эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүний харьяалдаг улс орон буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй буюу олон улсын статус ямарч байлаа гэсэн, ...ямарч байдлаар хязгаарлагдмал байсан, хүнийг ялгаварлаж үл болно”, 20 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”, 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ийн 19 дүгээр зүйлийн 1-д: “Хүн бүр өөрийн санал бодлыг чөлөөтэй баримтлах эрхтэй”, 22 дугаар зүйлийн 1-д: “Хүн бүр үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах болон өөрийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд тийм байгууллагад элсэх эрхийг оролцуулан бусадтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалтуудыг авч үзвэл хүн аливаа намд эвлэлдэн нэгдэх эрхтэй байгаа бөгөөд МУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-д: “МУ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3-д: “МУ-ын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байхад МУ-ын “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 6-д: “нам.... өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний...нэр...г дээрхи шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь дээрхи хэм хэмжээтэй зөрчилджээ.

Мөн 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт” -ийн 22-р зүйлийн 2-д: “Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд улсын буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт байж болохгүй” гэжээ.

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн үзэл баримтлалын үүднээс тухайн заалтыг авч үзвэл: Монгол Улсын “Улс төрийн намын тухай” хуулийн 1.1-д: “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам (цаашид “нам” гэх) байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, тараах, улсын бүртгэлд бүртгэх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино”, мөн хуулийн 4.1-д: “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол

болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн" гэж иргэдийн улс төрийн эвлэлдэн нэгдэх эрхийн үндсийг тодорхойлсон.

Орчин цөийн улс төрийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл: 2010 оны "Улс төрийн шинжлэх ухаан" (ред. Ё.Довчин) бүтээлд: "нам гэдэг бол нийтлэг ашиг сонирхол, үзэл баримтлалтай хүмүүсийг нэгтгэж, үйл ажиллагаа нь төр, засгийн эрхийг авах буюу түүний хэрэгжилтэд оролцоход чиглэсэн сайн дурын улс төрийн байгууллага юм" (329 дэх тал) гэж үзэл санаа, зорилгоор сайн дурын үндсэнд нэгдсэн иргэдийн нэгдэл буюу иргэдийн улс төрийн эрх чөлөөний илрэл болохыг тодорхойлжээ.

Иймд нам гэдэг нь хүний үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх эрхийн илрэл мөн.

Дээрхээс үндэслэн нэгдүгээрт: нам өөрчлөн байгуулагдаж, нэрээ өөрчилсөн (намын нэрийг хэрэглэхээ больсон) тохиолдолд болон ямар нэгэн нөхцөлд намын нэрийг өмч хэмээн үзэж, аль нэгэн нам субъектэд өмчлүүлэхийг зөвшөөрөх, хориглох хууль зүйн үндэслэл байхгүй юм. Мэдээж намын өөрчлөгдсөн нэрийг тухайн намаас татгалзаагүй, санал нийлээгүй тус намын гишүүн үргэлжүүдэн хэрэглэх гэдэг ойлголт байхгүй. **Хоёрдугаарт:** өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн намаас татгалзаж, тус намын гишүүн байхаа больсон бусад 801-ээс дээш иргэн үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэнд хуучин намаа үүсгэн байгуулж, хуучин нэрээрээ нэрлэгдэхээр хурлаараа баталсан хуулийн этгээдийг намын нэрийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох нь МУ-ын Үндсэн хуулийн 16.10-д заасан "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээссайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй" гэсэн заалтыг зөрчжээ.

Хууль зүйн практикийн үүднээс авч үзвэл: Би 2005 онд Үндсэн хуулийн Цэцэд хандсан өргөдөлдөө "нам өөрчлөн байгуулагдсан, нэгдсэн, нэрээ өөрчилсөн (намын нэрийг хэрэглэхээ больсон) тохиолдолд өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон" Улс төрийн намын тухай хуулийн 6.3 дахь заалтыг МУ-ын Үндсэн хуулийн 16.10-д заасан "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээссайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна гэж үзсэнийг УХ-ийн Цэц хэлэлцэн хүчингүй болгуулахаар болсон (МУ-ын Үндсэн хуулийн Цэцийн 2005 оны 9 дүгээр сарын 29-ний 2/06 тоот дүгнэлт) билээ. Энэхүү дүгнэлтийг УИХ хэлэлцэн "Улс төрийн намын тухай" хуулийн 6.3-г хүчингүй болгосон. (УИХ-ын протоколд тодорхой байгаа)

Улс төрийн намын тухай хуулийн 6.3 дахь заалт нь нэрээ өөрчилсөн

намын нэрийг хэрэглэхийг 24 жилээр хориглосон бол 15.6 нь намын нэрийг хэрэглэхийг бүрмөсөн, үүрд хориглосонгоороо илүүтэй хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байна. Хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь 1966 оны "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт"-ийн 22 дугаар зүйлийн 2-д: "Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд улсын буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг" хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт байж болохгүй", МУ-ын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-д заасан "Онц байдал болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно" гэсэн хязгаарлалтаас өөр хязгаарлалт байж болохгүй.

Харьцуулсан эрх зүй судлалын үнднээс авч үзвэл: Гадаад орнуудын улс төрийн намын тухай хуульд намын нэрийг аль нэгэн субъектэд өмчлүүлэх, үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрсөн болон өмчлүүлэх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглосон заалт байхгүй байна. Харин намын бүтэн болон товчилсон нэр нь бусад намын нэрээс ялгаатай байх, төрийн болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээдийн болон хүний нэртэй адилхан байхыг хориглодог байна. Тухайлбал, МАН буюу Монгол Ардын Нам, Монголын Ардчилсан Нам гэсэн товчилсон нэр нь ижил байж төөрөгдөлд оруулахыг хориглодог байна. Мөн намаас гарсан (өөрчлөгдсөн бүс) бүс нутгийн нэгдэл, холбоог гарсан намынхаа нэрийг ашиглах эрхгүй (ХБНГУ) гэж үзэхээс гадна улс орны тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөөний эсрэг чиглэсэн зорилготой намын нэрийг (фашист намын нэр) ашиглахыг хориглодог (ОХУ) байна. (ХБНГУ, ОХУ-ын Улс төрийн намын тухай хуулиудын холбогдох заалтыг хавсаргав.)

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6.1-д: "Нам оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд "нам" гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ", 6.2-д: "Намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж болон бусад намын нэртэй адил байхыг, түүнчлэн намыг хүний нэрээр нэрлэхийг хориглоно", МУ-ын Иргэний хуулийн 27.1-д: "Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна", 27.3-д: "Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй", 27.4-д заасан: "Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно" гэсэн заалтууд нь бусад улс орны хуулийн заалтуудтай ижил байна.

Хууль зүйн фактын үнднээс авч үзвэл: Монголын Социал Демократ Нам байгуулагадаа Ардчилсан Намтай нэгдсэн боловч, энэ

шийдвэртэй санал нийлээгүй бусад гишүүд дахин нэгдэж Монголын Социал Демократ Намыг байгуулан, үзэл санааны илрэл болох Монголын Социал Демократ Нам нэрээ хэрэглэж байна. Мөн МАХН нь өөрчлөгдөн шинэчлэгдэж, нэрээ МАН гэж өөрчилсөн бөгөөд тус намын үзэл баримтлалын өөрчлөлт, нэр өөрчилсөнтэй санал нэгдээгүй олон мянган гишүүд МАН-аас салж, хуучин МАХН-аа үзэл бодлоороо нэгдэж байна. Энэ тохиолдолд МАХН-д нэгдсэн гишүүдийг албадан тухайн намд эвлэлдэн нэгдэж болохгүй, үзэл санааны илэрхийлэл болсон намын нэрийг хэрэглэж болохгүй, энэ бол зөвхөн МАН-амын өмч гэж үзэх эрх зүйн үндэслэл байхгүй байна.

Дээрхи нотлогоонд үндэслэн, аливаа намын нэр нь тухайн намын үзэл санааны илэрхийлэл болохоос өмч биш юм. Иймд өөрийн үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдэж, намынхаа нэрийг бусад хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй биш байгаа тохиолдолд дахин хэрэглэх эрхтэй. Учир нь намын нэр нь үзэл санааны илэрхийлэл бөгөөд үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдсэн намын гишүүдийн оюун санааны эрх чөлөөний илрэл учраас төр намын асуудалд хөндлөнгөөс оролцож, энэүү эрхэнд халдаж, хязгаарлалт хийж байгаа нь эвлэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг хааж байна.

МУ-ын Улс төрийн намын тухай хуулийг судлан үзэхэд үзэл баримтлалын хувьд:

1. Хүний үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх эрхийг хангах;
2. Улс төрийн намын төлөвшилийг хангах;
3. Олон ургалч үзэл, олон намын системийг бий болгоход чиглэгдсэн мэт харагдаж байна.

Гэхдээ нарийн судлаад үзвэл, МУ-ын Улс төрийн намын тухай хууль нь эрх барьж буй намуудын эрх ашгийг хамгаалж, МУ-ын Үндсэн хуулийн үзэл баримтлалаас зайлсхийсэн хууль болох нь түүний заалтуудаас харагдаж байна. МУ-ын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал” бүтээлийн нэгдүгээр дэвтэрт: “МУ-ын Үндсэн хуулийг боловсруулахдаа зорьж баримталсан гол санааг...хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөхийг зорьсон,...ганц намд бүхэлдээ захирагдмал улс төрийн нэг ишт төвлөрсөн тогтолцоог үгүйсгэж, улс төрийн олон ишт тогтолцоог бэхжүүлсэн төрийг нийгмийн улс төрийн харилцааны үндэс болгох” гэж тодорхойлсон байхад МУ-ын “Улс төрийн намын тухай” хууль нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж, улс төрийн намуудын төлөвшлийг хуулиар албадан зохицуулахад чиглэгдэж байна.

НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН МӨН ЧАНАР, ОНЦЛОГ

Оршил

Нийтийн эрх зүй буюу АНУ-ын эрх зүйн тогтолцоо нь Английн эрх зүйгээс гаралтай, гол онцлог нь зарим шүүхийн шийдвэр тус улсын хууль тогтоомжийн үндсэн эрх сурвалж болж мөн дараа дараагийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэл болох боломжтой байдаг. Англи-Америкийн нийтийн эрх зүйн тогтолцооны (Common law) нөлөө, ач холбогдлыг зөвхөн англи уламжлалын эрх зүйн системтэй цөөн орны хүрээнд ойлгож дүгнэх нь учир дутагдалтай бөгөөд дэлхийн эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь нь улам өсөн нэмэгдэж эх газрын эрх зүй тогтолцоотой орнууд ч нийтийн эрх зүйн зарим элементийг авч хэрэглэх, олон улсын эрх зүйд нийтийн эрх зүйн тулгуур зарчмуудыг нэвтрүүлэх хандлагатай болоод байгааг¹ анхаарах нь зүй. Нийтийн эрх зүйд Case law буюу тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд шүүхийн баримталсан гүн ухаанч хандлага, эрх зүйн зарчим болон бодлого, шийдвэрийн гаргалгаа нь нийгэмд зан суртахууны хэм хэмжээ буюу хууль болон тогтдог нь илүү амьд, уян хатан, амьдралд нийцтэй, хүний мөн чанарт ойр байж тухайн харилцааг илүү бодитой зохицуулж чадаж байгаагаараа зохиомол хууль буюу кодчилсон хуулиас (substantive law) илт давуу нь харагдаж амьд эрх зүй гэгдсээр байна. Хэдийгээр шүүгчийн хууль бүтээх үйл ажиллагааг АНУ-ын хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын төлөөлөгчид шүүмжилж тухайн улс орон, нийгэмд мөрдөх эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг нийгмийн гишүүд, ард түмний төлөөлөл болох Конгресс бүтээх ёстой атал цөөн тооны шүүгчид тогтоож байгаа нь олонхи засаглаж, олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэх ардчиллын үндсэн зарчимд харшилж буй гэдэг боловч судлаач миний хувьд АНУ-д шүүх Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавьж шүүгчид эрх зүйн хэм хэмжээ тогтоодог нь шүүх засаглалд давуу байдлыг олгож шүүхэд байдаггүй олон эрх хэмжээгээр шүүхийг илт давамгайлахыг байнга оролдож байдаг эрх мэдлийн бусад салаа мөчиртэй нэг түвшинд аваачсанаар засаглалын харьцангуй тэнцвэртэй байдлыг бий болгодог гэж үздэг.

Нэгэнт нийтийн эрх зүйн олон давуу талыг дэлхийд хүлээн зөвшөөрч буй энэ үед бид эх газрын эрх зүйн уламжлалд дулдуйдан



Сүхбаатар дүүргийн
шүүхийн шүүгч,
докторант Ч.Хосбаяр

¹ Lawrence R. Helfer, Anne-Marie Slaughter (1997) *Toward a Theory of Effective Supranatural Adjudication*, 107 Yale L.J. P.273, 276, 280, 282.

Англи-Америкийн эрх зүйн гаралтай бүгдийг өөрөөсөө түлхэж үл ойшоон суухын оронд бусад улсын жишгээр судалгаа, шинжилгээг хийж өөрт тустай зүйлийг олж тогтоон өөрийн оронд өрнөж буй эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтөд тусгавал зохистой. Эрх зүйн янз бүрийн тогтолцоо тус тусын замаар боловсорч хөгжихийн хажуугаар нэгнийхээ давуу дэвшилтэт шинж чанаруудыг эзэлдэн авах болсноор ойртон нягтарч эцэстээ төгс боловсронгуй нэг л эрх зүйн тогтолцоонд улс орнууд шилжиж болзошгүй энэ эрин үед бид ч бас алсын хараатай бодлого явуулах нь зүйтэй билээ. Нийтийн эрх зүйн анхдагч Англи улсыг бодоход АНУ нь нийгмийн зонхилох харилцааг кодчилон хуульчилж Конгрессоор батлуулсан улмаар шүүхийн прецедентээс илүү хүчин чадалтайд тооцох болсноороо өөрийн эрх зүйн системд эх газрын эрх зүйн элементүүдийг түлхүү хэрэглэж буй нийтийн эрх зүйт орны төлөөлөл бөгөөд эрх зүйн хийдэлгүй, хосолмол төгс системийг бусдаас түрүүлж бий болгох нь тус улсын улс төрч, хуульчид, эрдэмтэн, судлаачдын зорилт болсныг дурьдах нь зүйтэй.

Нийтийн эрх зүй ба эх газрын эрх зүйн ялгаа

АНУ-ын эрх зүйн тольд хуулийг нийтээр дагаж мөрдөхөөр эрх бүхий этгээдээс тогтоож, албадлагаар баталгаажсан дүрэм, журмын цогц гэж тодорхойлжээ.² Хууль тодорхой байхын хажуугаар уян хатан мөн хүртээмжтэй байхыг нийгэм шаарддаг. Өөрөөр хэлбэл, аливаа этгээд аль нэг зан үйл хууль зүйн ямар үр дагавар авчрахыг хуулиас урьдчилан тодорхой мэдэх буюу ямар үйлийг зөвшөөрч ямыг хориглосныг таних боломжтой байхыг тодорхой (predictability), харин янз бүрийн нөхцөл, тохиолдолд таарч зохицох чадварыг уян хатан (flexibility), хуулийг хэн боловч олж мэдэх, ойлгох, судлах бусдаар тайлбарлуулах боломжийг хүртээмжит байдал (accessibility) гэж үздэг. Энэ гурван шаардлага нь хуулийн нийгмийн шалтгуур бөгөөд хуулийн амьдрах чадварыг тодорхойлдог.

Эх газрын эрх зүйн тогтолцоо нь хуулийн заалт тодорхой байхыг илүү чухалчилж хууль тогтоох тусдаа байгууллагаас хуулийг хэлэлцэж батлан тухайн төрлийн харилцааны бүхий л тохиолдолд хэрэглэхээр хатуу зааж нийтэд зарлан тунхаглаж хуулийг засах, өөрчлөх эрхийг зөвхөн өөртөө үлдээдгээс хууль нь уян хатан бус, хөшингө болж амьдралын тодорхой нөхцөл байдалтай тохирч зохицохгүй байх нь элбэг тохиолддог. Энэ системийн хуульчдын хувьд хууль тогтоох байгууллагаас гаргасан хэм хэмжээ хууль тогтоомжийн анхдагч болон үндсэн эх сурвалж бөгөөд шүүхийн шийдвэр бол энэ ерөнхий хэм хэмжээг тухайн хэрэг маргаанд хэрэглэсэн жишээ төдийхөн бөгөөд шийдвэрт хуулийн үзэл санаа, зорилго, агуулга тусгагддаггүйгээс

² (1990) *Black's Law Dictionary* 6th ed., West Group, P.884.

тодорхой тохиолдлуудад хэрхэн хувиргаж хэрэглэх талаар тайлбар гаргах шаардлагатай болдог. Хуулийн тайлбар нь хуулийн товч, ерөнхий заалтаас дэлгэрэнгүй, ойлгоход илүү ойр дөхөм боловч аль нэг хэрэг маргааныг уг хуулийг хэрэглэн шийдвэрлэх явцдаа тайлбарласан шүүхийн шийдвэрийн төгс байдалд дүйхгүй билээ. Хуулийг зөвхөн хууль тогтоох байгууллагаас баталсан эрх зүйн хэм хэмжээ гэж өмнө үздэг байсан Герман, Франц зэрэг эх газрын эрх зүйт орон болоод Европын олон улсын эрх зүйн салбарт эрх зүйн хэм хэмжээг шүүхийн шийдвэрээр тайлбарлахын ач холбогдлыг үнэлэх болж шүүгчийн хууль бүтээх үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх хандлага бий болж байна.³

Нийтийн эрх зүйн тогтолцоот улсын хууль тогтоомж бидний хувьд тохиолдлоор гаргасан олон дүрэм, журам, шүүхийн шийдвэрийн эмх цэгц муутай цуглуулга мэт санагддаг. Эцэслэн тогтоосон хуулийн чанд тодорхой заалт байхгүй ч зарим тохиолдолд харилцан нэгнийгээ үгүйсгэсэн мэт Конгрессийн шийдвэр, Дээд шүүхийн тогтоолууд судалгаа хийхээр очсон эх газрын эрх зүйчийг бүр будлиулж орхидог байхад харин америкийн хуульчид энэ талаар огтхон ч санаа зовохгүйгээр үл барам тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тодорхой хуулийн заалт үгүйг ч эс харгалзан өөрийн гардаж буй хэрэгт тохирох эрх зүйн зарчим, хэм хэмжээний гаргалгааг агуулсан шүүхийн аль нэгэн шийдвэрийг олчихсон л байдаг. 1950-иад оноос хойш АНУ-ын хууль тогтоомжид төрөлжсөн код хуулиуд нийтийн эрх зүйн уламжлалыг шахах хандлагатай болсон ч шүүх өөрийн шийдвэртээ Конгрессоос баталсан хуулийн заалтыг агуулгаас нь хальж тайлбарлах, өөрчлөх эрхтэй байх⁴ бөгөөд зарим тохиолдолд уг заалтыг хүчин төгөлдөр бусад тооцож өөрийн зарчмыг тогтоох нь ч бий. Үүнийг Конгресс үл таашаах боловч эцсийн шийдвэр гаргах эрх шүүхэд байх тул шүүхэд шахалт үзүүлж чаддаггүй.

Нийтийн эрх зүй уян хатан байж хэрэг, маргааны онцлог бүрт тохирсон шийдвэр гаргаж чаддаг нь нэгэнт бүгд мэдэх давуу тал бөгөөд харин хууль урьдчилан тодорхой байх шаардлагын тухайд судлаачдын дунд маргаантай. Шүүх хэрэв тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үедээ тохирох хуулийг бий болгож буй юм бол *retroactivity* буюу хэрэг, маргаан үүссэний дараа хуулийг тогтоож улмаар өмнөх үйлдэл, эс үйлдэлд буцаан хэрэглэж байгаагаараа хуулийг буцаан хэрэглэх журмыг зөрчиж байна гэсэн шүүмжлэл эх газрын эрх зүйчдээс гардаг. Нийтийн эрх зүйчид үүнд манайд ижил

³ Konrad Zweigert, Hein Kotz (1998) *Introduction to Comparative Law* Tony Weir trans., 3d rev. ed., Oxford Univ. press 1998, P.268-269.

John Henry Merryman. (1981) *On the Convergence and Divergence of the Civil Law and the Common Law*. 17 Stan. J. Int'l. P.357.

⁴ Tubbs J.V. (2002) *The Common Law Mind: Medieval and Early Modern Conceptions* Johns Hopkins Univ. Press, P.173

бүрэлдэхүүнтэй хэргүүд нэг л янзаар шийдэгддэг жишигтэй, иймээс хууль урьдаас олон нийтэд илт байдаг, хүн бүр өөрийнх нь зан үйл ямар хууль зүйн үр дагавар авчрахыг шүүхийн өмнөх шийдвэрүүдээс төвөггүй төсөөлөх боломжтой гэж тайлбарладаг.

Үүнээс гадна нийтийн болоод эх газрын эрх зүйчдийн тодорхой үйл баримтад дүгнэлт хийх, хууль зүйн гаргалгаа хийх арга зам хоорондоо ялгаатай байдаг. Эх газрын эрх зүйчид сэтгэлгээндээ дедатив аргыг буюу хуулийн ерөнхий заалтад анализ хийж зарчмаа тодорхойлоод түүнийг тодорхой тохиолдолд буулгаж тухайн хэрэг маргаанд яаж хэрэглэхээ тогтоодог байхад нийтийн эрх зүйчид эхлээд тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэсэн жишээг судалж шүүхийн баримталсан зарчим, үндэслэлийг олж тогтоон түүнд тулгуурлаж ерөнхий зүй тогтлыг бий болгож улмаар уг зүй тогтлыг өөрт буй хэрэг маргаанд хэрэглэх боломжийг харьцуулан судалдаг. Энэ аргыг нийтийн эрх зүйчид индуктив, дедатив болон аналитик хосолсон сэтгэлгээний зарчим гэх бөгөөд эртний сэтгэгч Сократаас уламжлагдан хөгжиж ирсэн логикийн хамгийн дэвшингүй арга гэж тайлбарладаг.⁴ Тодорхой хэрэг маргаан дээр ажиллаж буй нийтийн эрх зүйчид тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулийг Конгрессоос баталж гаргасан байсан ч үзэх гэж яарахгүй эхлээд ижил төрлийн хэрэг, маргааныг шүүх яаж шийдвэрлэснийг судалдаг онцлогтой. Товчхондоо нийтийн эрх зүй нь хэрэг, маргааны талаар шүүхээс гаргасан тодорхой шийдлийг хууль гэж үздэг бөгөөд хуулийн онолын болон албан ёсны тайлбарыг мөн л шүүх дараа дараагийн шийдвэртээ тусгаж эрх зүйн онол, практикийг зэрэг хөгжүүлдэг байхад эх газрын эрх зүйд хуулийг хууль тогтоох байгууллага гаргаж харин тайлбар болон хөгжил боловсруулалтыг эрх зүй судлаачид, эрдэмтэд голчлон гүйцэтгэж түүнийг шүүх тусдаа тайлбар болгон хожим гаргана. Хэдийгээр хэрэг, маргааны шийдлийн үндэслэлийг боловсруулах арга, процесс хоёр системийн хуульчдын хувьд ийм ялгаатай байх боловч эцсийн үр дүн нь ихэнх тохиолдолд давхцаж байдаг.

Нийтийн болон эх газрын эрх зүйчдийн сэтгэлгээнд бүр хууль зүйн боловсрол анхлан эзэмших үеэс ялгаа гарч эхэлдэг. Хуулийн мэргэжлээр суралцагчдад эрх зүйн онолын үндэслэгээг ойлгуулах явдал эх газрын эрх зүйн сургалтын гол зорилго бөгөөд онолын хичээлийн агуулгыг цээжлүүлэх, тогтоолгох замаар хуульчийн мэргэжлийг эзэмшүүлдэг байхад нийтийн эрх зүйн сургалт суралцагчийг сэтгэлгээний аргуудад сургах, дүгнэлт хийх, хууль зүйн үндэслэлийг зөв тогтоох чадвартай болгоход оршдог. Сургалтын дараа хууль зүйн зөв шийдвэр гаргаж сурсан байх нь хуульчийн эзэмших гол чадвар гэж эх газрын эрх зүйчид үздэг байхад нөгөө систем нь зөв сэтгэж сурсан байхыг голчлон

⁴ (1981) Webster's Third New International Dictionary Merriam-Webster, P.589.

анхаарч үр дүн ямар байх нь төдий л сонин биш.

АНУ дахь эрх зүйн философи ба Марксист-Ленинист онол

АНУ-ын улс төр, нийгэм, эрх зүйн суурь ойлголт зах зээлийн эдийн засаг, олон нийтийн хяналттай төр болон хууль дээдлэх зарчимд тулгуурлах бөгөөд нийгмийн харилцааг шударга ёсонд нийцүүлэн зохицуулж улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хүн нэг бүрийн эрхийг хамгаалах үүргийг хууль хүлээдэг. Харин Марксист онолоор социалист хууль бол хүнийг өмнөх нийгмийн дадал заншлаас нь салгаж коммунизмын нийгэмд бэлтгэж шинээр хүмүүжүүлэн өөрчлөх үүрэгтэй.⁴ Коммунист улс төрийн онолоор хууль хүнийг нийтийн эрх ашгийг хувийнхаас илүүд үзэж нийгмийн сайн сайхны төлөө өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хойш тавьдаг хэмжээнд өөрчлөх ёстой. Үүнийг нийгмийн хөгжлийн эрхэм зорилго болгож тавьснаар хууль бол улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх албадлага болж хувирдаг. Хуулийг улс төр, шашны нөлөөнөөс ангид байлгаж хуульд бүгд захирагдах нь эрдчилсэн нийгмийн тулгуур ойлголт шударга ёсны үнэлэмж атал Лалын шашны экстремист хэлбэрийг дагадаг зарим улс орон шашны сургааль, зан үйлийг хуультай нэгтгэсэн байдгийн нэгэн адил коммунист хөгжлийн онол нь хууль, улс төр хоёрыг салгаж үздэггүй, хуулийг шинэ нийгэм бүтээх тухай коммунист улс төрийн зорилгод хүрэх албадлагын хэрэгсэл гэж үздэг. Тиймээс хуулийг төрөлх шинж болон эрх зүйн үндсэн зарчмуудад харшаар өөрчилж улс төрд үйлчлэх зэвсэг болгодог.

АНУ-ын нийтийн эрх зүй нь хувь хүн бүрийн эрх ашгийг хамгаалахыг урьтал болгох бөгөөд нийтийн эрх ашиг нь хувь хүн бүрийн эрх ашгийг хамгаалснаар бүрдэх бөгөөд "Эрх чөлөөний тунхаг"-т заасан хувь хүний тодорхой эрхүүдийг бодгаль бүрт эдлүүлэх нь энэ зорилгод хүрэх ганц боломж гэж тодорхойлдог. Ингэж нийтийн эрх зүй нь хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүний жам ёсны эрхэд тулгуурлан томъёолж хуулиар хамгаалдаг болно. Хүний эрхийг баталгаажуулах, хамгаалах, өргөжүүлэн хөгжүүлэх үүргийг төрд оноожээ. Хувь хүн төрд захирагдахыг зөвшөөрөхийн хажуугаар төрөөс хуульд захирагдахыг шаарддаг. Ийм тохиролцоонд бий болсон төрийг америкчууд "тодорхой хэсэг хүмүүсийн засаглал бус хуулийн засаглал"⁵ гэж нэрлэжээ. Ямар ч төр хяналтгүй бол авлигад идэгдэж, эрх мэдлээ зузаатгаж эхэлдэг нь жам тул түүнийг засаглалын салаа мөчирт хувааж харилцан нэгнийгээ хянахаар төрийн байгууллыг АНУ-д анх тогтоосон⁶ бөгөөд хараат бус шүүх, тангарагтны систем,

⁴ Glendon, Gordon & Osakwe (1982) *Supra* note 3, at P.278-279.

⁵ Hayek F.A (1994) *Planning and Rule of Law*. in *The Road to Serfdom* University of Chicago Press, P.6.

⁶ *The Federalist* No. 51 (James Madison).

шүүхийн хяналт зэрэг институт нь төрийг хянах арга хэрэгслүүдийн нэг хэсэг яах аргагүй мөн.”

Дүгнэлт

Манай улсын хувьд эх газрын эрх зүйн тогтолцоотой гэдэг боловч Ром-Германы сонгодог хэлбэрээс гарсан “коммунист эрх зүйн онолд суурилсан орос хувилбар” болсон эрх зүйн тогтолцоо анхнаасаа тогтсон бөгөөд хэдийгээр хуулиуд өөрчлөгдөж эрх зүйн шинэтгэл явагдсаар бийгаа боловч мөн чанарын хувьд хэвээр хадгалагдсаар байна. Эрх зүйн шинэтгэлийг зөвхөн хуулиудаа өөрчлөх байдлаар хийх нь хүссэн үр дүнд хүргэхгүй. Шинэтгэлийг мөн эрх зүйн ерөнхий хандлага, онолын хүрээнд явуулах, эргэж харах шаардлагатай бөгөөд хуульчдын ухамсар, сэтгэлгээний өөрчлөлт ч чухал ач холбогдолтой юм. Эрүү, иргэний процессын хуулиудад шинэчлэл шаардагдаж буй энэ үед Англи-Америкийн сонгодог нийтийн эрх зүй, сэтгэлгээнээс бидэнд дутагдаж буй, эдгээр процессын хуулиудыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн шаардлагад нийцүүлэн амжилттай шинэчилж чадах тэр зүйлийг олж харж болохыг үгүйсгэх аргагүй юм. Манай улсын эрүү, иргэний процессын хуулиудад тусгалаа олж шүүн таслах ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх болсон мэтгэлцээн (adversary system) нь нийтийн эрх зүйн суурь зарчмуудын нэг бөгөөд өнөөдрийн байдлаар монголын шүүхийг эх газрын эрх зүйт бусад улс орны шүүхүүдээс ялгаж тодорхойлох гол онцлог болоод байна. Энэ зарчмыг хэрэгжүүлснээр шүүн таслах ажиллагаанд талууд хуулийн өмнө эрх тэгш байх, шүүх хараат бус хөндлөнгийн байх зэрэг процессын бусад зарчим бодитой хэрэгжих боломжтой болсноос гадна шүүхийн шийдвэр үндэслэл бүхий, хууль ёсны байх шаардлагыг ч илүү хангах болсон байна. Цаашид нийтийн эрх зүйн үндсэн зарчмуудад тулгуурласан мэтгэлцээний болон нотолгооны стандартыг бий болгож хэрэгжүүлэх нь мэтгэлцээнийг бодит утгаар нь бий болгох чухал ач холбогдолтой.

¹ The Federalist No. 78, 79, 83 (Alexander Hamilton).

ТАГНУУЛ ХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

Гадаад орнууд тэдгээрийн тусгай албад бусад орны эсрэг явуулдаг нууц бодлого, төлөвлөгөө, явуулга, арга хэмжээнүүдийн дотор тагнуулын үйл ажиллагаа, ялангуяа тагнуул хийх гэмт хэрэг чухал байр суурь эзэлдэг. Дэлхий эсрэг тэсрэг системд хуваагдаж, ихэнх орны тусгай албад улс үндэснийхээ ашиг сонирхол гэхээсээ илүү хамаарагдаж буй системээ хамгаалах, байр суурийг нь бэхжүүлэхэд хүч, анхаарлаа



Үндэсний тагнуулын академийн дэд захирал, профессор М.Цогтоо

чиглүүлж байсан хүйтэн дайны үе нэгэнт өнгөрлөө. Өнөөгийн энэхүү шинэ нөхцөлд гадаадын тусгай албад улс үндэснийхээ аюулгүй байдал, ашиг сонирхлыг хамгаалах нэгэн зорилгод захирагдах болсон нь дэлхий дахинд тусгай албадын өрсөлдөөнийг шинэ шатанд гаргаж, тагнуул хийх гэмт үйл ажиллагаа идэвхжихэд хүргэв. Даяаршил, интернет, мэдээллийн шинэ технологи, мэдээллийн чөлөөт орчин зэргийн улмаас тагнуул хийх гэмт хэрэг үйлдэх арга ажиллагаанд орсон зарим өөрчлөлт нь тухайн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харж, боловсронгуй болгохыг шаардаж байна. Энэ асуудлыг тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний элементүүдтэй холбон авч үзье.

Тагнуул хийх гэмт хэрэг нь үндэсний аюулгүй байдал (ҮАБ), түүний бүрэлдэхүүн хэсэг болох оршин тогтнохуйн аюулгүй байдалд хор хохирол учруулахад чиглэдэг. "Монгол Улсын ҮАБ гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ."¹ Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлалд тодорхойлсноор оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндсийг юуны өмнө Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал бүрдүүлдэг.² Бүрэн эрхт байдал гэж аливаа улс орны бие даасан байдлын баталгаа, гадаад, дотоод бодлогын аливаа асуудлыг гадаадын ямар ч орноос хараат бусаар бие дааж шийдвэрлэх, төрийн хууль тогтоомж, улсынхаа нутаг дэвсгэрт дангаараа ноёрхох чадварыг хэлж болох юм.³ Тусгаар тогтнол гэдэг бол Монгол Улс өөр аль ч улсаас улс төр, эдийн засаг, нийгэмшил, үзэл буюу оюун санааны хувьд хараат биш байгааг хэлнэ.⁴ Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь түүх, соёл, зан заншил, эдийн

¹ (2010-6) Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлал-1.1.1 Төрийн мэдээлэл 2010 оны №6(657)

² Мөн тэнд. 3.1.

³ Чимид Б (2008) *Үндсэн хуулийн мэдлэг* УБ, 52.

⁴ Мөн тэнд. 55.

засаг, эрх зүйн орон зайгаа хадгалах баталгааг багтаасан нийгмийн хөгжлийн геополитикийн таатай нөхцөл юм. Оршин тогтнохуйн аюулгүй байдлын дээрх үндсүүдийг улс орны гадаад аюулгүй байдлын гол илэрхийлэл гэж хэлж болно. Тийм ч учраас манай улсын эрүүгийн эрх зүйн салбарын нэрт эрдэмтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцан зэрэг судлаач¹ болон Оросын эрдэмтэд² тагнуул хийх гэмт хэргийг гадаад аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэж нэрлэсэн байна. Гадаад аюулгүй байдал нь тухайн улс орон гадаад улс, гадаадын байгууллага, тэдгээрийн элдэв халдлага, түрэмгийлэл, тагнах, хорлон бусниулах үйл ажиллагаанаас хамгаалагдсан байдал юм.

Энэ гэмт хэргийн нийгмийн хор аюул нь түүнийг үйлдсэнээр Монгол Улсын УАБ-д хор хохирол учирч болох төрийн нууц мэдээ, баримт сэлт гадаад улс, түүний тагнуулын байгууллагын мэдэлд шилжиж, тэгснээрээ УАБ-д аюул учрахад хүрдэгт оршино. Өөрөөр хэлбэл, төрийн нууц мэдээ, баримт сэлт дээрх эдгээдүүдийн гарт орсноор тэд манай иргэнийг эх орноосоо урван тэрслэхэд хүргэх, Монгол Улсын эсрэг хорлон сүйтгэх, хорлон саатуулах ажиллагаа явуулах, төр, нийгмийн зүтгэлтнийг эрхшээл, нөлөөндөө оруулж, гэмт зорилгодоо ашиглах, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохнон байгуулах, зэвсэгт үймээн дэгдээх гэх мэт янз бүрийн гэмт хэрэг үйлдэх бололцоотой болдог.

Ийм жишээ, баримт гадаадын тусгай албадын тагнуулын үйл ажиллагааны түүхэнд цөөнгүй тохиолдож байсны нэгийг дурдъя. 1960-1980-аад оны үед ЗХУ нь АНУ зэрэг барууны орны цэрэг, аж үйлдвэрийн хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүн, ялангуяа тооцоолон бодох техник, технологийг худалдах болон тагнуулын зэрэг хууль бус аргаар олж авахыг эрмэлзэж байжээ. Энэ байдлыг АНУ-ын тусгай албад гадарлаж байсан аж. Үнэхээр ч ЗХУ Барууны орнуудын нууц технологийг тагнан олж авсны үр дүнд шинэ зэвсэг боловсруулах судалгааны ажилд зарцуулах асар их хөрөнгө хэмнэж, ихээхэн цаг хугацаа хожжээ.

ЗХУ-ын тагнуулын алба шинээр баригдаж байсан, Сибирийн хий дамжуулах хоолойн нүсэр байгууламжийн компьютерийн удирдлагын системийг Канадын бизнесмений халхавчаар ажиллагч тагнуулчийнхаа тусламжтайгаар олж авах гэж байгааг ЗХУ-ын Гадаад тагнуулын газрын урвагч офицер, өөрийн түршүүл В.Ветровоос олж мэдсэн Франц, АНУ-ын тагнуулын албад дээрх автомат удирдлагын системийг зориуд алдаа гаргаж, хий дамжуулах хоолойд дэлбэрэлт болгохоор хийлгэсэн байна. Хорлон сүйтгэх ажиллагаа төлөвлөсөн³ Жанцан С. Төгс-Очир С (2007) *Монгол Улсын үндэсний болон хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргээтэй явуулах эрүүгийн эрх зүйн тэмцэл* Уб. 23.

¹ Комиссаров В.С., Лопашенко Н.А., Найумов А.В., Пономарев Г. (2007) *Уголовное право России. Особенная часть* Москва, С.524

ёсоор 1982 оны 6 дугаар сард болж, Башкирын хий дамжуулах хоолой бүхэлдээ болон түүний ойролцоо явж байсан суудлын хоёр галт тэрэг түймэрт автаж, манай дэлхий дээр хэзээ ч болоогүй цөмийн биш хамгийн хүчтэй дэлбэрэлтийн улмаас ЗХУ-д хэмжээлшгүй их хохирол учирсны дотор 400 гаруй хүн амь үрэгдсэн байна. Урвагч В.Ветровын балгаар ЗХУ-ын Гадаад тагнуулын албаны “Т” буюу Шинжлэх ухаан технологийн газрын, дэлхийн янз бүрийн улс оронд ажиллаж байсан 200 гаруй тагнуулчид болон тэдгээртэй нууцаар хамтран ажиллаж байсан олон туршуул илэрч, тухайн газрын үйл ажиллагаа саармагжихад хүрсэн ажээ. Мөн АНУ-ын Ерөнхийлөгч байсан Р.Рейганы шийдвэрээр ЗХУ-д нийлүүлэх техник, технологи, ялангуяа хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хатуу хяналт тавих болсны гадна тус улсыг цэрэг, зэвсэглэлээр хөөцөлдүүлж, эдийн засгийн нь сулруулан туйлдуулахад чиглэсэн “Оддын дайны хөтөлбөр” гэх мэт цогц арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн байна. Жишээлбэл, америкчууд хэрэггүй гэж үзсэнийг нь мэдээгүйн улмаас оросууд “Буран” сансрын хөлөг бүтээх бүтэлгүй оролдлого хийж, асар их хүч, хөрөнгө, зардал гаргасны гадна “Стелс” технологиор байлдааны үл үзэгдэгч онгоц бүтээх төсөл зэрэг нь дээрх арга хэмжээний нэг хэсэг байжээ. Үүний зэрэгцээ АНУ-ын Холбооны нөөцийн алба ЗХУ алтны их нөөцтэй байгааг харгалзан алтны дэлхийн зах зээлийн үнийг тухайн үед зориуд унагаж байсны гадна, Аляскад ЗХУ нефтийн асар их нөөц илрүүлснийг тооцоолоод 1986 онд нефтийн дэлхийн зах зээлийн үнийг унгахад хүргэж байжээ. Эдгээрээс үзвэл тагнуул хийх гэмт хэргийн гол хор аюул нь нууц мэдээ, мэдээлэл, мэдээ баримт дээр дурдсан этгээдүүдийн мэдэлд очдогт биш, харин тэдгээрийг ашиглан тухайн улс орны аюулгүй байдлын эсрэг гэмт үйл ажиллагаа явуулах бололцоотой болдогт л байдаг ажээ.

Тийнхүү энэ гэмт хэргийн объектыг өргөн утгаар авч үзвэл Монгол Улсын гадаад аюулгүй байдал буюу Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм. Гадаад аюулгүй байдлын дээрх бүрэлдэхүүн хэсгүүд нь хоорондоо салшгүй нягт холбоотой бөгөөд үйлдэгдсэн тухайн хэргийн нөхцөл байдлаас хамаарч чухам юунд нь илүү хохирол учирсныг хэргийн нотлох баримтад тулгуурлан тогтоох нь зүйтэй.

Тагнуул хийх гэмт хэргийн халдлагын зүйлд төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл багтана. Төрийн нууцын тухай хуульд тодорхойлсноор Төрийн нууц гэж “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал

Владимир Абаинов. Досье Фарзвелла. Газета “Совершенно секретно” №8 (256). 2010

Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник, технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, биет зүйлийг хэлнэ.”⁹ Мөн УАБ-ыг хангах үүднээс зарим барилга байгууламж (цаашид объект гэх), төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулж болно гэжээ. Төрийн нууцад хамаарах зүйлсийн жагсаалтыг 1995 онд батлагдсан Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар тогтоосон байна. Уг хуулиар төрийн нууцад Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээний нийтлэг 20; батлан хамгаалах хүрээний 20; эдийн засаг, шинжлэх ухаан технологийн хүрээний 8; тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээний 16; бусад 8 асуудлыг тус тус хамааруулсан байна. Энэ жагсаалтад тусгаагүй зүйлийг төрийн нууцад тооцож болохгүй.

Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар энэ гэмт хэргийн объектив тал нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, бусад зүйлийг хулгайлах, цуглуулах, гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлж өгөх үйлдлүүдийн аль нэгээр илрэх аж. Энэ гэмт хэрэг дээрх үйлдлүүдийн аль нэг нь хийгдсэнээр төгсгөд учир хэлбэрийн бүрэлдэхүүнтэй юм.

Төрийн нууц мэдээ, баримт, бусад зүйлсийг хулгайлах гэдэг нь тэдгээрийг өөрийн эзэмшилд хууль бусаар авах идэвхтэй үйлдэл болно. Дээр дурдсан зүйлсийг цуглуулах гэдэг нь хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Жанцангийн тодорхойлсноор “Бусдын яриаг чагнах, тагнах, соронзон хальсанд бичих, хуулбарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээс хайчилбар хийх лавлагаа авах, нууц объект, ажиллагаа, бичиг баримтын зураг авах, зураглал, бүдүүвч хийх, дүрс болон соронзон бичлэг хийх, нууц мэдэж болох эсхүл хадгалдаг, албан ажлын хувьд нууцтай холбогддог хүмүүстэй тагнах ярилцлага хийх зэрэг янз бүрийн арга хэлбэртэй идэвхтэй үйл ажиллагаа”¹⁰ байх ажээ. Нууц мэдээ хулгайлах, цуглуулах гэмт үйлдлийн тухайд Оросын цөөнгүй судлаач дээрх эрдэмтэнтэй адил тайлбар хийжээ.¹¹

Харин бид энэ талаар арай өөр бодолтой байна. “Цуглуулах” гэдэг үг нь “... аргал цуглууулах, марк цуглуулах, түүхий эд цуглуулах” гэх мэт илээр явагддаг үйлдлийг илэрхийлдэг тул¹¹ “тагнах, чагнах, нууц объект, ажиллагаа, бичиг баримтын зураг авах, тагнах ярилцлага хийх” гэх мэт нууц үйлдлийг түүнд хамааруулж болмооргүй байна.

⁹ Төрийн нууцын тухай хууль-3.1.

¹⁰ Жанцан С. Төгс-Очир С (2007) *Монгол Улсын Үндэсний болон хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргэстэй явуулах эрүүгийн эрх зүйн тэмцэл* УБ. 23.

¹¹ Здравомыслов Б.В., Караул В.Ф., Кладков А.В (1999) *Уголовное право. Особенная часть* Москва, С. 366-367.

¹² Цэвэл Я (1966) *Монгол хэлний товч тайлбар толь* УБ. 797.

Иймд "цуглуулах" үйлдэлд зөвхөн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, ил ном, материал гэх мэт ил эх сурвалжаас мэдээ авахыг хамааруулж ойлгох нь зүйтэй. Харин нууц үйлдлүүд нь хулгайлахтай нэгэн адил мэдээ олох нууц аргуудын нэг билээ. "Нууц мэдээ олох" гэдэг нь тагнуулын мэргэжлийн үг, хэллэгт нууц аргаар (багагүй хүч, хөдөлмөр, арга, ухаан, заль, мэх хэрэглэж, М.Ц) мэдээг хууль бусаар өөрийн болгох агуулгатай юм.¹² Энэ нь бас "олох" хэмээх үгийн "эрсний эцэст тохиолдох, илрүүлж авах"¹³ хэмээх үндсэн утгатай дүйж байна.

Тагнуулч, туршуул нууц мэдээг шилжүүлж өгөхдөө тагнуулын холбоо барих янз бүрийн арга, хэрэгсэл, заль мэх ашигладаг. Тэдгээрт далд бичлэг, шифр, код, бичил цэг ашигласан захидал, илгээмж болон цахилгаан мэдээ, факс, интернетийн сүлжээ, түүнчлэн телефон, гар утас, радио холбоо, нуувч, бичилсэн уулзалт, хормын уулзалт гэх зэрэг багтана. Гадаадын хүчирхэг тусгай албад тагнуулын тусгай техник хэрэгсэл, түүний дотор тагнуулын холбоо барьж, мэдээ дамжуулах тусгай техник хэрэгсэлээ байнга боловсронгуй болгож байдаг бөгөөд түүний хамгийн сүүлчийн ил болсон баримт нь Москвад суугаа Их Британий ЭСЯ-ны ажилтан тагнуулчид 1-2 секундэд 20 хүртэлх метрийн зайнаас туршуултайгаа холбоо барих шинэ үеийн тагнуулын радио хэрэгсэл ашиглаж байгаад 2004 онд илэрсэн явдал юм.¹⁴

Объектив талд, дээр дурдсан гурван үйлдлээс гадна "хадгалах" үйлдлийг хамааруулах нь зүйтэй. Тагнуулч, туршуулууд олсон, цуглуулсан нууц мэдээгээ шууд дамжуулах боломж тэр бүр гардаггүй тул хадгалах тохиолдол байхын гадна олсон мэдээгээ холбоочин тагнуулч, туршуулуудаа түр хадгалуулан тэднээр төв рүүгээ илгээлгэх тохиолдол ч гарч байдаг. Ялангуяа суурин тагнуулчид ихэвчлэн холбоочин тагнуулч, туршуултай байх нь цөөнгүй.¹⁵ Эдгээр байдлыг харгалзан тухайн гэмт хэргийн диспозицид "хадгалах" гэдэг үг нэмэх нь зүйтэй. Нууц мэдээ хадгалах гэж тагнуулч, туршуул өөрөө олсон цуглуулсан, эсвэл бусдын өгсөн нууц мэдээг тагнуулын байгууллагад дамжуулахын тулд өөрийнхөө мэдэлд гүр байлгахыг хэлнэ хэмээн тодорхойлж болох юм. "Хадгалах" үйлдлийг тагнуул хийх гэмт хэргийн диспозицид тусгаагүй нь төрийн нууц мэдээг гадаадын тусгай албанд дамжуулах зорилгоор хадгалсан этгээд эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх сөрөг үр дагавартай.

Сөрөх тагнуулын ажлын практикаас үзэхэд гадаадын зарим орны тагнуулчид манай орны нутаг дэвсгэр дээрээс гуравдагч орны эсрэг тагнуул хийх тохиолдол гарахыг үгүйсгэж болохгүй. Энэ үйлдэл нь манай улсын аюулгүй байдалд шууд аюул, занал учруулахгүй байж болох ч тус улс нутаг дэвсгэрээ бусад улсын эсрэг гэмт зорилгод

¹² Валерий Землянов (2002) *Своя контрразведка* Минск, Харвест, С.29.

¹³ Цэвэл Я (1966) *Монгол хэлний товч тайлбар толь* УБ, 797.

¹⁴ Газета "Новости разведки и контрразведки". 2005. № 210-211

¹⁵ Аллен Даллес (2000) *Искусство шпионажа* Москва, С.67-69.

ашиглуулснаас улс төрийн болон бусад сөрөг үр дагаварт хүрч болохыг харгалзан “Бусад улсын эсрэг тагнуул хийх” гэсэн шинэ зүйлийг Эрүүгийн хуульд нэмж оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Тагнуул хийх, тагнуул хийх хэлбэрээр эх орноосоо урвах гэмт хэрэг нь төрийн нууц мэдээг хууль бус эргэлтэд оруулж буй, нийгэмд ихээхэн хор аюултай гэмт үйлдлүүд бөгөөд тэдгээрийг үйлдсэн этгээдэд хүнд ял оногдуулдаг. Тиймээс эдгээр гэмт хэргийн халдлагын зүйл болох мэдээний тухай зөв тодорхойлолт өгөх нь чухал. “Эх орноосоо урвах” гэмт хэргийн диспозицид “...төрийн нууцыг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн ...”, “тагнуул хийх” гэмт хэргийн диспозицид “... төрийн нууц, түүнд хамаарах мэдээ, баримт, бусад зүйлийг хулгайлсан, ...” гэх мэтээр халдлагын зүйлийг янз бүрээр нэрлэжээ.

Дээр дурдсанаас үзэхэд төрийн нууц мэдээг янз бүрээр, түүний дотор зөвхөн Эрүүгийн хуульд 2 өөрөөр тодорхойлсон байна. Мэдээллийн ажлын нэг чухал өвөрмөц төрөл болох тагнуулын үйл ажиллагааг зохицуулсан манай улсын гол хууль болох Тагнуулын байгууллагын тухай хуульд “Тагнуулын мэдээ гэж тусгай алба үндсэн үүрэг, зорилтынхоо дагуу нууц арга, хэрэгслээ ашиглан олж буй мэдээ, баримт сэлт”¹⁶ хэмээн тодорхойлоод “мэдээ баримт сэлт олох”, “гаргуулан авах”, “мэдээлэл боловруулж, ...байгууллага, албан тушаалтанд танилцуулах” гэх мэт нэр томъёог хэрэглэсэн бол¹⁷. Гүйцэтгэх ажлын тухай хуульд “мэдээ, мэдээлэл, баримт бичиг олох”, “удирдлагыг мэдээлэлээр хангах”, “мэдээ баримтыг гаргуулж авах”, “өөрт байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн”, “мэдээллийн систем” гэх мэт үг хэллэг хэрэглэсний дотор “мэдээ, мэдээлэл, баримт бичиг” гэдэг нэр томъёо зонхилж байна.¹⁸

Манай орны бичгийн болон ярианы хэлэнд “мэдээ”, “мэдээлэл” гэдэг үгс л өргөн хэрэглэгдэж байгаа ч тэдгээрийн утгын нэрийн зааг, ялгааны талаар нэгдсэн ойлголт алга. Жишээлбэл, Монголын нэвтэрхий тольд “Мэдээ гэж шинэ зүйлийг... мэдээлэх зорилгоор баримттай, товч бичдэг бичлэгийн төрөл зүйлийн нэр”, “Мэдээлэл гэж ам, бичгээр юмуу өөр аргаар ...бие биедээ дамжуулдаг мэдээний нэр”¹⁹ гэж тус тус тодорхойлсон байна. Энэ 2 тодорхойлолтыг эргэцүүлбэл мэдээлэл нь баримттай, товч бичдэг бичлэгийн төрөл зүйлийн нэгнийх нь нэр буюу мэдээний нэр төрлийн нэг болж байна. Манай хэл судлалын нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, А.Лүвсандэндэв нар монгол хэлний мэдээ, мэдээлэл гэдэг үгстэй ойролцоо утгатай, орос хэлний “информация” гэдэг үгийг “мэдээлэл, мэдээ”, “данные” гэдэг үгийг “мэдээ баримт”, “сведение” гэдэг үгийг “мэдээ, сураг, мэдээ

¹⁶ Тагнуулын байгууллагын тухай хууль-3.6.1.

¹⁷ Мөн тэнд. 3.6.1.

¹⁸ Гүйцэтгэх ажлын тухай хууль-2.1, 9.1.4.

¹⁹ Чадраа Б (Ред) (2000) *Монголын нэвтэрхий толь* УБ, 102.

тайлан, мэдэгдэх", "сообщение" гэдэг үгийг "сонгох, мэдэгдэх, мэдээ, мэдээлэл" гэж тус тус орчуулсан байна.⁴⁰ Нэрт эрдэмтэн, Академич С.Нарангэрэл, МУ-ын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид зэрэг хуульч "информация" гэдэг үгийг "мэдээтэл", "данные" гэдэг үгийг "баримт сэлт, мэдээлэл", "сведения" гэдэг үгийг "мэдээ", "сообщение" гэдэг үгийг "мэдээ, мэдээлэл" гэж тус тус тайлбарлах буюу орчуулжээ.⁴¹

Оросын мэргэжилтнүүдийн тайлбарласнаар "данные" хэмээх үгийн агуулга нь факт буюу үйл баримтаас үндэслэлтэй. Жишээлбэл, статистикийн мэдээ баримт, аж ахуйн нэгжийн мэдээ (сведения) гэх мэт.⁴² "Информация" гэдэг үг нь янз бүрийн мэдээ баримт (данные)-аас сонгон боловсруулж задлан шинжилж гарган авсан, тэдгээрийн нийлбэр потцыг илэрхийлдэг байна.⁴³ К.Шеноны мэдээллийн онолын сонгодог тодорхойлолтоор "информация" нь авагдахаасаа өмнөх үеийн тодорхой бус байдлыг бүрэн буюу аль нэг хэмжээгээр багасгаж байдаг мэдээ баримт (данные), мэдээнүүд (сведения)-ийн нийлбэр цогцос ажээ.⁴⁴ Энэ бүхэнд тулгуурлаад бид "информация" гэдэг үгийг "мэдээлэл", "данные" гэдэг үгийг "мэдээ баримт", "сведения", "сообщение" хэмээх үсгийг "мэдээ" гэж тус тус орчуулан дээр дурдсан утгаар хэрэглэж хэвшихийг санал болгож байна. "Мэдээ" гэдэг үг нь мэдэгдэх зүйл, ямар нэг зүйлийн тухай мэдлэг болох зүйл хэмээх нийтлэг утгатай.⁴⁵ Иймд мэдээ, мэдээлэл, мэдээ баримт гэдэг үсгийн оронд гэрхүү нийтлэг утгаар нь "мэдээ" гэдэг үгийг хэрэглэх нь цөөнгүй байдаг байна. Мэдээ нь хүнээс гадна ном, баримт бичиг, диск гэх мэт янз бүрийн зүйл агуулагдаж байдаг. Тэдгээрийг "мэдээлэл зөөгч" гэж нэрлэж буйг "мэдээ агуулагч" гэх нь арай оновчтой байж болох юм. Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт багтах тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль нэрлэсэн "баримт бичиг", "бичиг зүйлс" зэрэг нь мэдээлэл агуулагч юм. Дээрх болон холбогдох бусад хуульд нүүц мэдээнээс гадна түүнийг агуулагчийг бүгдийг нэрлэвэл хүнээс эхлээд олон зүйлийг тоочиход хүрэх тул тэдгээрийн оронд "төрийн нууц мэдээ" гэдэг үгийг хэрэглэх нь оновчтой байж болох юм.

Бас "Эх орноосоо урвах" гэмт хэргийн диспозиц дахь "төрийн нууц", "Тагнуул хийх" гэмт хэргийн диспозиц дахь "төрийн нууц, түүнд хамаарах мэдээ" гэсэн үсгийн оронд "төрийн нууц" хэмээх нэр томъёог хэрэглэх нь илүү тохиромжтой, ойлгомжтой байхсан.

⁴⁰ Давиднэрсэн Ц. Лувсандэндэв А (1983) Орос-монгол толь УБ, 197, 202, 631, 663.

⁴¹ Нарангэрэл С (2008) Эрг. зүүн эх. толь бичиг УБ, 285.

⁴² Даримжаа Д. Дашдондог Д. Чимид Б (1978) Улсын нэр томъёоны комиссын мэдээ (Хууль зүйн нэр томъёо) УБ, 81, 43, 214, 229.

⁴³ Доронин И (2007) Бизнес-разведка. 4-ое издание. Москва, С. 20.

⁴⁴ Мен тэнд. 20.

⁴⁵ Мен тэнд. 20.

⁴⁶ Цэвэл Я (1966) Монгол хэлний товч тайлбар толь УБ, 354.

Тагнуул хийх гэмт хэргийн халдлагын зүйл нь төрийн нууц мэдээ тул уг гэмт хэргийг зөв зүйлчлэх, тухайн гэмт хэрэгтэй амжилттай тэмцэхэд гадаадын тусгай албад болон байгууллагад задарснаар Монгол Улсын YAB-д хохирол учирч болох мэдээнүүдийг зөвхөн төрийн нууцад хамааруулах, түүнчлэн төрийн нууц мэдээний зэрэглэлийг тогтоохдоо YAB-ыг хангахад түүний аль хэр чухал болох, задарснаас учирч болох хор хохирлын хэмжээ зэргийг харгалзах нь чухал. Иймд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиудыг дээрх шаардлагуудын үүднээс эргэн харахаас гадна төрийн нууцад хамаарах тодорхой мэдээ нэгэнт задарсан бол түүнийг төрийн нууцын жагсаалтаас хасаж байх заалт оруулах нь зүйтэй.

Хүйтэн дайны үе нэгэнт өнгөрч улс орнууд нийгэм, улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, урлаг, соёл, шинжлэх ухаан гээд бараг бүх салбарт хамтран ажиллаж байна. Түүний зэрэгцээ интернет гэх мэт мэдээллийн шинэ тенологи бий болж, дэлхий ертөнц улам бүр даяаршиж байна. Ийнхүү дэлхийн аль ч өнцөг буланд болж буй үл явдлыг шууд олж мэдэх, аливаа асуудлын талаар асар их мэдээлэл цуглуулан шинжилж, ашиглах өргөн боломжийг бий болгов. Эдгээр нөхцөл байдал нь тусгай албадын үйл ажиллагаанд ч багагүй нөлөөлж, өмнө нь нууц арга, хэрэгслийн тусламжтайгаар шийдвэрлэдэг байсан цөөнгүй зорилтыг өнөө үед илээр тагнах арга замаар шийдвэрлэх бололцоотой болоод байна. Нэлээд орны тусгай албад энэ бололцоог үр дүнтэй ашиглаж байгаагийн дотор АНУ-ын Тагнуулын төв газар (ТТГ) "Ил эх сурвалжийн төв"-ийг байгуулан түүнд 44 тэрбум долларын төсөв хуваарилжээ. Тэр үед ТТГ-ын захирал асан Ж.Негрелонтегийн хэлснээр уг төвийг байгуулах болсон гол шалтгаан нь АНУ-ын YAB-д нөлөөлөх аюулын талаарх мэдээллийг ил эх сурвалжуудаас цуглуулах боломж бий болсонд орших ажээ.³⁶ Тийнхүү тагнуулын ихээхэн мэдээг ил эх сурвалжаас олж ашигладгийг харгалзан зарим улс Эрүүгийн хуульдаа тухайн улсын эсрэг ашиглах зорилгоор ил мэдээг цуглуулсан, дамжуулсан, эсвэл тийм үйлдлийн улмаас улс орны аюулгүй байдалд хүнд хор хохирол учирсан бол тагнуул хийх гэмт хэрэгт тооцохоор заасан байна. Жишээлбэл, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд " ...төрийн нууцад хамаарахгүй мэдээг гадаад улс болон түүний төлөөний хүмүүст дамжуулсны улмаас ХБНГУ-ын гадаад аюулгүй байдалд хүнд хохирол учруулсан бол эх орноосоо урвасан хэргээр (энэ хуулийн 94 дүгээр зүйл) хариуцлага хүлээлгэнэ"³⁷ гэжээ. ОХУ-ын Эрүүгийн хуульд " ... Гадаадын иргэн, харьяалалгүй хүн ОХУ-ын гадаад аюулгүй байдалд хор хохирол учруулахын тулд гадаадын тагнуулын байгууллагын даалгавраар бусад мэдээг цуглуулсан буюу

³⁶ Цогтбаатар Д (2009) *Ил тагнуулын үйл ажиллагаа, түүнтэй тэмцэх нь* : ТЕГ-ын

"Мэдээлэл"сэтгүүлийн тусгай дугаарын хавсралт. 10.

³⁷ ХБНГУ-ын 1998 оны Эрүүгийн хууль-97А.

гадаад улс, гадаадын байгууллага буюу тэдгээрийн төлөөлөгчдөд дамжуулсан бол... шийтгэх "-ээр заасан байна."²⁸ Эдгээр байдлыг харгалзан манай улсын Эрүүгийн хуульд мөн холбогдох өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Эрүүгийн хуульд зааснаар энэ гэмт хэргийн субъектив тал нь гэмт этгээд төрийн нууц мэдээ баримт, бусад зүйлийг хулгайлах, цуглуулах, шилжүүлэх үйлдлүүдээ тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор хийсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ гэмт хэргийг санаатай үйлддэг. Оросын судлаачдынхаар энэ гэмт хэрэг шууд санаатай үйлдэгддэг байна. Гэхдээ бидний үзэж байгаагаар цөөн бүс тохиолдолд энэ гэмт хэрэг бусад орны аюулгүй байдалд хор хохирол учруулах зорилгоор шууд санаатай үлддэгддэг хэдий ч нэлээд тохиолдолд, ялангуяа хүйтэн дайны үе өнгөрсөн өнөөгийн нөхцөлд гадаадын тусгай албад тагнагдагч оронд хохирол учруулахаасаа өөрийн орны ашиг сонирхлыг хамгаалах, эх орныхоо эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшилд туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилгоор тагнуул хийх хандлага илүүтэй ажиглагдах болоод байна. Өөрөөр хэлбэл, Францын Гадаад аюулгүй байдлын газрын дарга асан Пьер Марисигийн хэлснээр "Улс орнуудын хоорондын тэмцэл цэрэг-улс төрийнхээс эдийн засаг, технологийн түвшинд шилжиж байгаа".²⁹ Ингэхлээр тагнуулч, туршуулууд тагнагдагч орны нууц мэдээг олох, цуглуулах, хадгалах, дамжуулахдаа тэр оронд хор хохирол учрах боломжтойг урьдчилан мэддэг боловч хор уршиг заавал учрахыг хүсдэггүй ч түүнийг учрахад хүргэдэг байна. Иймээс энэ гэмт хэрэг бас шууд бүс санаатай үйлдэгддэгийн гадна түүнийг үйлдэгч этгээд бүр тагнагдагч орны аюулгүй байдалд хор хохирол учруулах зорилготой байдаг гэж үзэх нь ташаа юм.

Барууны орнуудын холбогдох хуулиудын тагнуул хийх гэмт хэргийн диспозицид гэмт этгээдийн зорилгыг заагаагүй нь үүнтэй холбоотой байж болох юм. Жишээлбэл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн "Нууц тагнуулын үйл ажиллагаа" (Манай Улсын Эрүүгийн хуулиар бол "Тагнуул хийх" гэмт хэрэг М.Ц) гэдэг зүйлийн диспозицид "Гадаад улсын тусгай албаны талд эд зүйл болон мэдээллийг дамжуулахад чиглэсэн, ХБНГУ-ын эсрэг тагнуулын үйл ажиллагаа эрхэлсэн бол..."³⁰

хэмээн тодорхойлохдоо субъектын зорилгыг заагаагүй бол АНУ-ын хуулиудын "Гэмт хэрэг ба эрүүгийн процесс" хэмээх 18 дугаар бүлгийн 1.37 дугаар зүйлд тагнуул хийх гэмт хэргийг тодорхойлохдоо "Улсын батлан хамгаалахтай холбоотой мэдээллийг цуглуулах, дамжуулах, алдах, эсвэл энэ үйлдэл нь АНУ-д хохирол учруулсан бол"³¹, "Гадаад

²⁸ ОХУ-ын Эрүүгийн хууль-276.

²⁹ Шекотова Л (1994-2) *Какие могут быть секреты между друзьями* // Техника-молодежи.

³⁰ ХБНГУ-ын 1998 оны Эрүүгийн хууль-99.а.

³¹ АНУ-ын хуулиудын 18 дугаар бүлгийн Нэгийн 37 дугаар хэсгийн 793 дугаар зүйл.

улсад туслах зорилгоор батлан хамгаалахтай холбоотой мэдээллийг цуглуулах, тараах, эсвэл энэ үйлдэл нь АНУ-д хохирол учруулсан бол ³² гэж тодорхойлохдоо сүүлчийн зүйл дэх “Гадаад улсад туслах зорилго”-ыг хүндрүүлэх шалтгаан болгожээ.

Тагнуул хийх гэмт хэрэг ихэнх тохиолдолд “Эх орноосоо урвах” гэмт хэрэгтэй холбоотой байдаг. Эрүүгийн хуульд заасанчлан Эх орноосоо урвах гэмт хэргийг Монгол Улсын тусгаар тогтнол, ҮАБ, тэр тусмаа батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор үйлддэг гэж үзэх нь өрөөсгөл юм. Гадаад орнуудад илэрсэн, эх орноосоо урвах хэлбэрээр тагнуул хийгчдийн цөөнгүй нь үйлдлийнхээ нийгмийн хор аюулыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд хор уршиг учрах нь зайлшгүй буюу учрах боломжтойг урьдчилан мэддэг боловч хор уршиг учрах эсэхэд хайш яйш ханддаг байна. Өөрөөр хэлбэл, түүнд үйлдлийнх нь улмаас эх оронд нь хохирол учрах эсэх нь гол биш, харин мөнгө олох нь түүний зорилго байдаг байна. Үүний нэг нотолгоо нь ОХУ-ын Төрийн Думын Аюулгүй байдлын байнгын хорооны орлогч дарга Г.Гудков ОХУ-ын Гадаад тагнуулын албаны хэлтсийн дарга, АНУ-ын туршуул асан Щербаковын талаар өгсөн ярилцлагадаа “Энэ нь ямар ч үнэ цэнээр хамаагүй түргэн баяжихыг амьдралынхаа зорилго болгосны нэг тод жишээ мөн”³³ гэсэн үг болно. Гэтэл энэ бүхний үл харгалзан хуучин социалист гэгдэж байсан орнууд, түүний дотор манай улсын Эрүүгийн хуульд дээр дурдсан хоёр гэмт гэмт хэргийн диспозицид “Монгол Улсын тусгаар тогтнол, ҮАБ, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор” тагнуулын гэмт үйлдлүүдийг хийхээр заасан нь оновчтой биш юм. Иймд дээр дурдсан байдлуудыг үндэс болгон Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Тагнуул хийх”, “Эх орноосоо урвах” гэмт хэргүүдийн диспозицоос тэдгээрт дурдсан зорилгыг хасч, харин тухайн гэмт хэргийг Монгол Улсын ҮАБ-д хохирол учруулах зорилгоор үйлдсэнийг хүндрүүлэх шалтгаануудын нэгэнд тооцох нь зүйтэй гэж үзэж байна.

Тагнуул хийх гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тусгай буюу зөвхөн гадаад улсын иргэн, эсвэл харьяалалгүй хүн байхаар Эрүүгийн хуульд заасан байна. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар “Гадаад улсын иргэн гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг хэлнэ”. “Харьяалалгүй хүн гэж аль ч улсын харъяат бус хүнийг хэлнэ.”³⁴ Дээрх субъект манай улсын иргэнийг элсүүлж гэмт зорилгодоо ашигласан бол гадаадын иргэнийг тагнуул хийх, манай улсын иргэнийг эх орноосоо урвах гэмт хэргээр зүйлчилнэ. Энэ гэмт хэрэг нь тагнуул хийх хэлбэрээр эх орноосоо урвах

³² Мөн тэнд. 794.

³³ (2010-209(4509)) *О предателе Щербакове знал не только “Ъ”* // Коммерсант.

³⁴ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль-5.1.1, 5.1.7.

гэмт хэргээс гэмт хэргийн субъектаараа ялгагдана. Өөрөөр хэлбэл, тагнуул хийх хэлбэрээр эх орноосоо урвах гэмт хэргийн субъект нь манай улсын иргэн байдаг бол тагнуул хийх гэмт хэргийн субъект нь зөвхөн гадаад улсын иргэн буюу харъяалалгүй хүн байна.

Эрүүгийн хуульд Тагнуул хийх, Эх орноосоо урвах гэмт хэргийн субъект нь төрийн нууц мэдээг зөвхөн гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн бол дээрх гэмт хэргүүдийг үйлдсэнд тооцохоор заасан. Гэтэл олон улсын террорист байгууллага, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд аюулгүй байдлаа хангах маш нарийн тогтолцоотойн дотор тагнуулын үйл ажиллагаа чухал байр суурь эзэлдэг. Тийм учраас тэдгээрийн тагнуулч, туршуул Монгол Улсын УАБ-д хохирол учруулах зорилгоор нууц мэдээ олох, цуглуулах, хадгалах, гэмт байгууллагадаа дамжуулах, манай иргэнийг эх орноос нь урвуулан гэмт зорилгодоо ашиглахыг үгүйсгэх учиргүй тул тэдгээрийн дээрх үйлдлүүдийг мөн тагнуул хийх гэмт хэрэг үйлдсэнд тооцох, энэ тухай заалтыг Эрүүгийн хуульд нэмж оруулах нь зүйтэй.

Бидний санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг Эрүүгийн хуульд оруулах нь өнөө үед улам идэвхижиж илрүүлэх, таслан зогсоох, нотлох, холбогдох хариуцлага хүлээлгэхэд бэрхшээлтэй болж буй тагнуул хийх гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлэхэд зохих алхам болохсон билээ.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ТӨЛӨӨЛӨЛ



МУИС-ийн Хууль
зүйн сургуулийн
ахлах багш,
докторант Д.Хуяг

**I. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд
төлөөлөгч оролцох үндэслэл, шалтгаан.
Төлөөллийн тухай ойлголт**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлэгч (хэргийн зохигч) өөрөө биечлэн оролцох буюу эсвэл төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн зохигч биечлэн оролцоход дараах хүндрэл, бэрхшээл ба оролцох боломжгүй нөхцөл байдал байдаг. Үүнд:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлзэх зарчмын үндсэн дээр явагдах болж шүүх мөрдөн шалгах зарчмаас татгалзаж өөрийн санаачлагаар нотлох баримт цуглуулах үүргээс

чөлөөлөгдөж, нэхэмжлэгч нь өөрийн шаардлагаа нотлож, хариуцагчийн татгалзлыг үгүйсгэж байгаа, хариуцагч нь өөрийн татгалзлын үндэс болж байгаа нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх үүрэг тус тус хүдээлгэсэн нь материаллаг болон процессийн хуулиудын хангалттай мэдлэггүй, эрх зүйн мэдлэг боловсрол дутмаг байдаг;

2. Хэргийн зохигч ажил албанаасаа шүүхэд очих, шүүх нь түүний ажил, алба ба оршин суугаа газраас нь өөр газар байх, ажлын зав зай, цаг хүрэлцэхгүй байх, өндөр настай, биеийн эрүүл мэндийн байдал зэрэг нь хүндрэл учруулдаг;

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн чадамжгүй, зарим чадамжтай, бүрэн бус чадамжтай, хязгаарлагдмал чадамжтай этгээд оролцох болсон тохиолдолд тэдгээрийг эрх бүхий этгээд төлөөлөх шаардлага гардаг;

4. Гадаадын улс оронд ажиллаж амьдарч байгаа ба хорих ял эдлэж байгаа этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх шаардлага гардаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөллийн талаар судлаачид дараах тодорхойлолтыг өгчээ.

Дэд доктор Е.В.Салогубова "Шүүхэд төлөөлөх гэдэг нь төлөөлүүлэгчээс төлөөлөгчид олгосон эрх хэмжээний үндсэн дээр шүүхэд төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс оролцож түүнд ашигтай шийдвэр гаргуулахын тулд төлөөлүүлэгчид өөрийн эрхээ хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрхийг нь зөрчихөөс сэргийлэх,

шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлэх зорилготой”.¹

Доктор В.В.Ярков “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөлөл гэдэг нь нэг этгээд нөгөө этгээдийн нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг түүний ашиг сонирхлын тулд хийхийг хэлнэ”.²

Доктор М.С.Шакарян “Шүүхэд төлөөлөх гэдэг нь төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд түүний нэрийн өмнөөс эрх ашгийг нь хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэл) хийж үүний улмаас төлөөлүүлэгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх үүрэг үүсдэг эрх зүйн харилцааг хэлнэ”.³

Хуульч А. Дугармаа “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөлөл гэдэг нь сонирхогч этгээдүүдийн нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, эрх зүйн чадвар чадамж бүхий субъектүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үйл ажиллагаа юм”, “Өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалуулахын тулд шүүхэд бүсдыг оролцуулж байгаа талыг төлөөлүүлэгч, тухайн үйл ажиллагааг түүний нэрийн өмнөөс гүйцэтгэж байгаа этгээдийг төлөөлөгч гэнэ” гэжээ.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч оролцох тухай Монгол Улсын анхны Иргэний байцаан шийтгэх хуулиудад дараахь байдлаар заажээ. Тухайлбал, 1952 онд батлагдсан БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 9 дүгээр зүйлд “Шүүхээс хэргийг таслахад зохигчид нь өөрөө буюу эсхүл өөрсдийн төлөөлөгчөөр дамжуулан оролцоно”, 1967 онд батлагдсан БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 47 дугаар зүйлд “Иргэд нь өөрийн биеэр буюу төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд хэрэг хэлэлцүүлж болно”⁴ гэж тус тус заажээ.

II. Төлөөллийн зорилго, ач холбогдол

1. Иргэн хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг бүрэн дүүрэн хангаж хамгаалах;
2. Хэрэг хэлэлцэх ажиллагаа сунжирч удаашрахаас сэргийлэх;
3. Хэрэг хэлэлцэх ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд талуудыг төлөөлөх (сайн дурын төлөөлөл);
4. Зохигчдийн албан ёсны ашиг сонирхлыг мэргэжлийн үүднээс хамгаалах, өмгөөлөх боломжоор хангах (гэрээгээр төлөөлөх);

¹ Треушников М.К (Ред.) (2008) *Гражданский процесс* Москва, С. 161.

² Ярков В.В (Ред.) (1999) *Гражданский процесс* Москва, С. 95.

³ Шакарян М.С (Ред.) (1996) *Гражданское процессуальное право* России; Москва, С. 85.

⁴ Мөхжаргал Т (2008) *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Ерөнхий анги* Уб, 81.

⁵ Энхбаяр С (2005) *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд* Уб, 66, 109.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох боломжоор хязгаарлагдсан, тухайлбал, эрх зүйн чадамжгүй, зарим чадамжтай зэрэг этгээдийн эрхийг хамгаалж, туслалцаа үзүүлэх (хууль ёсны төлөөлөл).⁶

III. Төлөөллийн төрөл

Төлөөллийг төлөөлөл үүсгэж байгаа үндэслэлээс нь хамааруулан дараах төрөлд ангилж болно. Үүнд:

1. Хуульд заасан төлөөлөл (хууль ёсны төлөөлөл);
2. Сайн дурын төлөөлөл;
3. Гэрээгээр төлөөлөл.

Хуульд заасан төлөөлөл нь эрх зүйн чадамжгүй (7 хүртлэх насны), зарим (7-14 насны) буюу бүрэн бус чадамжтай (14-18 насны) хүнийг шүүхэд төлөөлөл ажиллагаа байх бөгөөд төлөөтүүлж байгаа этгээдүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй субъектүүд байх ба тэдгээрийг эцэг эх нь шүүхэд төлөөлнө. Бүтэн өнчин, эсхүл эцэг эх нь эцэг эх байх эрхээ хасуулсан иргэдийг асран хамгаалагч, харгалзан дэмжигч шүүхэд төлөөлнө. Сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр асран хамгаалагчаар томилогдсон этгээд шүүхэд төлөөлнө.

Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 тоот тогтоолын (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай) 8 дахь хэсэгт, ИХШХШ тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бүрэн эрхийг нотлох баримт бичигт “хууль ёсны төлөөлөгчийн төлөөлөл эрх нь иргэний үнэмлэх, гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ, асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын шийдвэр байна” гэжээ.

Хуульд заасан төлөөлөлд иргэнийг сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг төлөөлөл ажиллагаа хамзарна. Тухайлбал, Иргэний хуулийн 23 дугаар зүйлд заасан сураггүй алга болсонд тооцогдсон хүн оролцвол зохих байсан хэрэгт эд хөрөнгийг нь эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүнийг төлөөлнө. Тухайн иргэнийг сураггүй алга болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрт эд хөрөнгө эрхлэн хамгаалагчийг томилдог тул тухайн этгээд шүүхийн шийдвэрийн хувийг нотлох баримтын хэмжээнд шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй. Нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан хүний өв залгамжлагч оролцвол зохих байсан хэрэгт уг өвийг хүлээж аваагүй

⁶ Түвшинтулга А (2005-2) *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь төлөөлөлтийн зарим асуудал // Хууль дээдлэх ёс*, 38.

байвал өвлөгдөх эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүнийг төлөөлөн оролцоно.

Сайн дурын төлөөлөл. Хэргийн оролцогч эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийгөө сайн дурын үндсэн дээр бусдаар төлөөлүүлэх эрхтэй. Төлөөлж байгаа этгээд нь эрх зүйн бүрэн чадамжтай ямар ч иргэн (найз нөхөд, танил хүмүүс, заавал өмгөөлөгч биш хуульч гэх мэт) байж болно. 2002 онд батлагдсан МУ-ын ИХШХШ тухай хуулийн 32.4-т сайн дурын төлөөлөлд зөвхөн “гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа” төлөөлүүлж болохоор заасан нь явцуу заалт байсан бөгөөд дээрх хуульд 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдөр орсон өөрчлөлтөөр сайн дурын төлөөллийг “бусдаар” гэж өөрчилсөн нь зүйтэй болсон гэж үзэж байна. Сайн дурын төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлээр батлагдана.

Гэрээгээр төлөөлөх. Иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэх эрхтэй. Ингэхдээ мэргэжлийн өмгөөлөгчтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх буюу хөлсөөр ажиллах гэрээ байгуулна. Өмгөөлөгч нь гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан шаардлагатай арга хэмжээг авах ба хэргийн бодит үнэнийг тогтооход туслалх үүрэгтэй. Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 тоот тогтоолын (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай) 8 дахь хэсэгт “...гэрээгээр төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгч, төлөөлөгчийн хооронд хийгдсэн бичгийн гэрээгээр тодорхойлогдоно... гэж заажээ.

Хуульч Ц.Амарсайхан иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөллийг хуульд заасан, сайн дурын, гэрээгээр төлөөлөх гэсэн гурван ангилалд биш зөвхөн хуульд заасан ба сайн дурын гэж хоёр ангилж (тухайлбал, гэрээгээр төлөөлөх явдал нь сайн дурын төлөөллийн нэг хэлбэр) гэж авч үзсэн байх ба энэ ангилал нь боломжтой гэж үзэж байна. Учир нь хууль ёсны төлөөлөгчийн хувьд хуульд нэрлэн заасан этгээдүүдийг шүүхэд төлөөлөх нь тэдний хуульд заасан үүрэг (тэдний хүсэл зоригоос үл хамаардаг) ба сайн дурын төлөөлөл, гэрээгээр төлөөлөх ажиллагаанд тухайн төлөөлөгчийн төлөөлөх тухай хүсэл зориг заавал байдаг нь сайн дурын ба гэрээгээр төлөөлөх ажиллагааг адил төстэй болгох талтай.

IV. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл иргэний эрх зүйн төлөөллөөс ялгаатай болох нь

¹ Амарсайхан Ц. нар (2008) *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар* УБ, 112-113.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл нь иргэний эрх зүйн төлөөлөлтэй адил болон ялгаатай шинжүүд байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл нь иргэний эрх зүйн төлөөлөлөөс ялгаатай тал нь тухайн эрх зүйн харилцаануудын зорилго, шинж чанар, төлөөлөгч, төлөөлүүлэгчийн хоорондын харилцаа, шүүхэд төлөөлөгчөөр оролцох хүмүүсийн хүрээгээр ялгаатай байна. Тухайлбал, иргэний эрх зүйн төлөөлөл нь төлөөлүүлж байгаа этгээдэд иргэний эрх үүрэг үүсэх, өөрчлөх, дуусгавар болгох явдал байна. Гэтэл шүүхэд төлөөлөх ажиллагааны зорилго нь шүүхэд төлөөлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх эдлэх, үүрэг биелүүлэхэд нь туслах явдал.

V. Төлөөлөгчийн бүрэн эрх ба итгэмжлэл

Төлөөлөгчийн бүрэн эрх гэдэг нь төлөөлөгч төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон эрх зүйн үйлдэл хийж төлөөлүүлэгчид эрх зүйн үр дагавар бий болгох эрх юм. Төлөөлөгчийн бүрэн эрх нь төлөөлүүлэгч этгээдийн өөрийн хүсэлтээр эсвэл эрх зүйн актын үндсэн дээр бий болдог. Шүүхэд төлөөлж байгаа этгээд нь тэдэнд эрх олгосон этгээдийн нэрийн өмнөөс тэдний даалгавараар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон үйл ажиллагааг хийдэг ба тэдний бүрэн эрхийн хүрээ нь төлөөлүүлэгчийн эрх зүйн байдалтай (нэхэмжлэгч, хариуцагч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд гэх мэт) холбоотой байна. Төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээ нь төлөөлүүлэгчийн эрх зүйн байдал ба төлөөлүүлэгчид өөрийнхөө ямар бүрэн эрхийг шилжүүлэн өгсөн гэсэн хоёр нөхцөлөөс хамаарна. Төлөөллийг бүрэн эрхийн хүрээгээр нь:

1. Ерөнхий бүрэн эрх;
2. Тусгай бүрэн эрх гэж ангилна.

Ерөнхий бүрэн эрх гэдэг нь итгэмжлэлд тусгайлан дурдагдсан эсэхээс үл хамааран төлөөлөгч, төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хийж байгаа хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаа юм. Тухайлбал, хэргийн материалтай танилцах, түүнээс шаардлагатай зүйлийг хувилж хуулбарлан авах, шүүх бүрэлдэхүүн ба бусад оролцогчийг татгалзан гаргах, шүүх хуралд нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох гэх мэт.

Тусгай бүрэн эрх гэдэг нь төлөөлөгч зөвхөн итгэмжлэлд тусгайлан дурдагдсан бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Тухайлбал, шүүхэд бусдыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээд нэхэмжлэл

гаргах эрхээ заасан итгэмжлэлийг шүүхэд заавал өгөх ёстой.

Иргэний ба иргэний процессийн эрх зүйн харилцаан дахь төлөөллийн асуудлыг дээрх хуулиудаар зохицуулсан боловч хуулийн заалтыг буруу хэрэглэж байгаа нь шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргээс харагдаж байна. Тухайлбал:

Жишээ 1. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 97 дугаар тогтоолтой "У" холбооны нэхэмжлэлтэй иргэн "А"-д холбогдох хэрэгт ИХШХШ тухай хуулийн 36.3-т "төлөөлөгч өөрийн бүрэн эрхийг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ" гэсэн заалтыг нэхэмжлэгч "У" зөрчиж иргэн "Э"-гийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэйгээ Иргэний хуулийн 64.2-т заасны дагуу нотлож чадаагүй учир "У" холбооны гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хяналтын шатны шүүх хэвээр үлдээжээ.

Жишээ 2. Өвөрхангай аймгийн шүүхийн давж заалдах шатны 2005 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 01 тоот магадлалтай иргэн "Д"-ийн нэхэмжлэлтэй иргэн "Э"-д холбогдох хэрэгт хариуцагчийн өмгөөлөгч Т.О-д олгосон шүүхэд төлөөлөх итгэмжлэл нь жинхэнэ эхээрээ биш хуулийн шаардлага хангахгүй нотлох баримт байгаа, ИХШХШ тухай хуульд заасан нотлох баримтыг шүүхэд эхээр нь өгөх, хэрэв эхээр нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө гэсэн заалтыг зөрчсөн байсан тул Өвөрхангай аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн 2004 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1/267 дугаар шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаасан."

Жишээ 3. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2006 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 197 дугаар тогтоолтой хяналтын хэсэгт ("Р"-ийн нэхэмжлэлтэй иргэн "Т"-д холбогдох хэрэгт):

- "В" ББХК нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу шинэчилсэн бүртгэлд бүртгүүлээгүй (хх 9 дэх тал) байх бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхой бүс байхад шүүх уг компанийг Ю төлөөлөх эрхтэй гэж үзсэн нь Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт нийцээгүй байна;

- Өмгөөлөгч Д "В" компанийг төлөөлөх итгэмжлэлийг Ю нь 2003 оны 6 дугаар сарын 11-ний өдөр олгохдоо тодорхой хугацаа заагаагүй (хх-ийн 5 дахь тал) ба уг итгэмжлэлийн хугацаа Иргэний хуулийн 64.5 дахь хэсэгт зааснаар 2004 оны 6 дугаар сарын 11-ний өдөр дууссан байхад шүүх "В" компанийг төлөөлөх эрхгүй Д-г хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан нь

¹ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл Иргэний хэрэг Цуврал-5 54-56.

² Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл Иргэний хэрэг Цуврал-5 116-119.

иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчжээ.

- "В" ББХК-ийг төлөөлж өмгөөлөгч Д-ийн гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн (хх-ийн 3 дахь тал) атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчээр Р-ийг оролцуулсан нь ойлгомжгүй болжээ. Р нь Т-д холбогдох нэхэмжлэлийг шүүхэд гаргаагүй байна."

Төлөөлөгчийн бүрэн эрх төлөөлүүлэгчийн олгосон итгэмжлэлээр баталгаажна. Итгэмжлэл нь төлөөлүүлэгч бүрэн эрхээ шилжүүлэх гэсэн ойлголт юм. Итгэмжлэл гэдэг нь төлөөлүүлэгчээс төлөөлөгчид олгосон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон үйл ажиллагаа хийж хэргийг хянан шийдвэрлэхэд оролцох эрхийг бичгээр олгосон эрх зүйн баримт бичиг юм.

Бичгээр олгосон итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан тухай Иргэний хуулийн 64.2-т заасан. Үүнд:

1. Итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж тамга тэмдэг дарсан байх;
2. Хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх;
3. Итгэмжлэлийг олгосон он, сар, өдрийг заах;
4. Хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх.

Хуульд өөрчлөлт оруулах санал

- Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 25.2-т "иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн нь гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садангийн хүн, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэхээ сайн дураар сонгох эрхтэй" гэсэн заалт нь төлөөлүүлэгчийн бусдаар төлөөлүүлэх эрхийг зөрчиж төлөөллийн хүрээг явцууруулсан байх тул "гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садангийн хүн" гэдгийг "бусдаар төлөөлүүлэх" гэж өөрчлөх;

- ИХШХШ тухай хуульд "Зохигч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцож байгаа нь тухайн хэрэгт төлөөлөгч авч оролцуулах эрхийг нь хасах үндэслэл болохгүй" гэсэн нэмэлт оруулах;

- Иргэний хуулийн 19 дүгээр зүйлд заасан "хязгаарлагдмал чадамжтай этгээдийг" харгалзан дэмжигчээр төлөөлүүлэх асуудал ИХШХШ тухай хуульд орхигдсон байх тул уг хуульд нэмэлт оруулах.

¹⁰ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл Иргэний хэрэг Цуврал-5 205-208.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН СҮДАЛГАА¹

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Оршил

Энэхүү судалгааг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг² шинэчлэн өөрчлөх гэж буйтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар батлагдсан судалгааны ажлын удирдамжид заасны дагуу хийсэн болно. Судалгаагаар АНУ-ын зарим муж (Иллинойс, Калифорни), ХБНГУ, ОХУ, БНХАУ, Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн Вант улс, Франц, Украин, Эстони, Израиль, Чех улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох эрх зүйн зохицуулалтын зарим онцлог зэргийг ерөнхий байдлаар тоймлон авч үзсэн бөгөөд удирдамжид заасны дагуу (1-2 улсын эрх зүйн зохицуулалтыг судлах) ОХУ, БНХАУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг түлхүү судалсан болно.³

Судлах асуудлууд:

- 1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын тогтолцоо, уялдаа ямар байна?;
- 2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтыг ямар байгууллага хэрхэн зохион байгуулдаг?;
- 3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан баримт бичигт эрх зүйн ямар зохицуулалтыг тусгасан байна?;
- 4.Замын хөдөлгөөн зохион байгуулалт, замын хөдөлгөөн зохицуулалт, Авто зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх зохицуулалт ямар байдаг? Ямар баримт бичгээр зохицуулсан байдаг?;
- 5.Олон нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сургалтыг ямар байдлаар олгодог?;
- 6.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээ, ямар төрөл байдаг, хариуцлагыг хэрхэн хүлээлгэдэг?;

¹ Судалгааг хийж гүйцэтгэсэн Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч Р.Мухийт, эрдэм шинжилгээний ажилтан А.Түвшинтулга, Л.Амаржаргал, Олон улсын эрх секторын эрхлэгч Ж.Селмаа, эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх-Амгалан.

² Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 1996 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны №7-д нийтдэгдсэн.

³ Судалгааг хийх явцад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төслийн хувилбарыг ирүүлээгүй бөгөөд судалгааг ажлын хэсгийн хурлын үер яригдсан асуудал, судалгааны удирдамжид заасан асуулгын хүрээнд хийсэн болно.

7. Торгуулыг бэлэн бус хэлбэрээр ногдуулж байгаа зохицуулалт? Манай улсад нэвтрүүлэх боломжтой эсэх?;

8. Жолоочийн хариуцлагын онооны системийн зохицуулалт ямар байдаг?.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын тогтолцоо, уялдаа ямар байна? Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтыг ямар байгууллага хэрхэн зохион байгуулдаг?¹

ОХУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр гүйцэтгэх, мөрдөн шалгах, засан хүмүүжүүлэх, хянан шалгах, зөвшөөрлийн үүргийг Замын хөдөлгөөний эргүүлийн алба² хариуцдаг байна. Тус алба нь ОХУ-ын Дотоод явдлын яамны харъяа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын нэг алба болж, ОХУ-ын нийгмийг аюулаас хамгаалах цагдаагийн бүрэлдэхүүнд багтдаг байна.

Тус байгууллага нь дараахь бүрэлдэхүүний хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний эргүүлийн албаны үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах албад;
- Хотын, дүүргийн, бүсийн, захиргаа, нутаг дэвсгэрийн хаалттай байгууламж, онцгой зохицуулалттай бүсүүд зэрэг газарт Замын хөдөлгөөнт эргүүлийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэгч албад;
- Замын хөдөлгөөний эргүүлийн албаны жагсаалын албууд.

Замын хөдөлгөөний эргүүлийн алба нь Дотоод явдлын яамны харъяа бусад газрууд, тээврийн хэрэгслийн цэргийн эргүүлийн алба, бусад төрийн байгууллага, хуулийн этгээд, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг байна.

Замын хөдөлгөөний эргүүлийн албаны гол зорилго нь замын хөдөлгөөнд оролцогч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журмыг баримтлах, улмаар амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлоос урьдчилан сэргийлэх, нийгмийн болон улсын эрх ашгийг хамгаалах, тээврийн хэрэгслийн зохистой хөдөлгөөнийг хангахад оршино. Замын хөдөлгөөний хяналтын үүргээ биелүүлэхдээ техник хэрэгсэл ашигласан видео ажиглалт хийх, зам дээр эргүүлийн албаны цагдаа нар хянах, техник хэрэгсэл ашиглан хурдыг хянадаг байна. Замын хөдөлгөөний эргүүлийн албаны ажилтан нь дараахь үүрэгтэй³

¹ 1. 2 дугаар судалгааны асуултын хариултыг нэгтгэн бичив.

² Приказ МВД РФ от 20.04.1999 г. № 297 "Об утверждении наставления по работе дорожного движения службы Государственной инспекции безопасности дорожного движения МВД РФ"

³ Указ Президента РФ от 15.06.1998 № 711 "О дополнительных мерах по обеспечению безопасности дорожного движения"

Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдал болон түгжрэлгүй явцыг хангах;
- Постын орчимд болон эргүүлийн талбай дахь нөхцөл байдлыг хянах;
- Замын хөдөлгөөнд оролцогч нарын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахиж байгаа эсэхэд хяналт тавих;
- Зам дээр гарч буй гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах;
- Жолооч нарт зам дээр гарсан ослын байдал, замын эвдрэл, гэмтэлийн талаар мэдээлэх;
- Тодорхой үйлдэл, дохио ашиглан замын хөдөлгөөнийг зохицуулах;
- Хуулиар тогтоосон журмын дагуу торгууль оногдуулах зэрэг орно.

ОХУ-ын хувьд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан хотын зөвлөлийн тухай” Москва хотын даргын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 435-РМ тоот тушаалаар замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулах зөвлөл байгуулагджээ⁷. Тус Зөвлөл⁸: нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Зам дээр гарч буй осолыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд зориулсан ухуулгын, танин мэдэхүйн шинжтэй арга хэмжээ зохион байгуулах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр гарч буй хууль, эрх зүйн актын шинэчлэл, хэрэгжилтэнд хяналт тавих;
- Зам дээр гарсан осолын талаар нэгдсэн статистик дүн гаргах, зам дээрхи зөрчлийг бууруулах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- Автотээврийн зөрчил, гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи жил бүрийн мэдээг ОХУ-ын Засгийн газарт бэлтгэх, танилцуулах;
- “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт Москва хотын сангийн (фонд)-ыг хөгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи нийгмийн идэвхи зүтгэлийг сайжруулах.

Белорусь Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар, замын хөдөлгөөн, түүний аюулгүй байдлыг Беларусь Улсын Хууль зүйн яамны харьяа Тээврийн хэрэгслийн улсын хяналтын газар хариуцдаг байна”. Тус

⁷ “Распоряжение мэра Москвы” О городской комиссии по безопасности дорожного движения” 2005.12.30 № 435-РМ http://www.businesspravo.ru/Docum/DocumShow_Docu-mID_107340.html /сүүлд үзсэн 2011.03.17/

⁸ Мөн тэнд.

⁹ Закон об Дорожном движении Республики Бурятия, 2006.01.25 4/22

байгууллагын эрх үүргийг “Белорусь Улсын Дотоод Явдлын яамны Тээврийн хэрэгслийн улсын хяналтын газрын тухай Тогтоол”-оор зохицуулжээ. Тус байгууллагын бүрэлдэхүүнд Тээврийн хэрэгслийн улсын газрын удирдлагын газар, Минск хотын гүйцэтгэх хорооны тээврийн хэрэгсэл хяналтын газар, дүүргийн, баг хорооны, тойргийн гүйцэтгэх хорооны тээврийн хэрэгсэл хяналтын газар, зам засварын тусгай барилгын багууд багтдаг.

АНУ-ын Калифорни мужийн хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд холбогдох төрийн байгууллагууд болон бусад этгээд нь нэлээд уялдаатай ажилладаг байна. Жишээ нь: улаан гэрлээр дүрэм зөрчсөн, эсхүл машинаа хориглосон зогсоолд тавьсан зэрэг зөрчлөөс үүдсэн торгууль (хотын захиргаанаас оногдуулсан торгуулийг), мөн шүүхээс (хотын цагдаагийн хүргүүлсэн баримтыг үндэслэн) авто замын ослын холбогдох зөрчилд оногдуулсан торгуулийг төлөхгүй хугацаа хэтрүүлбэл тухайн торгууль оногдуулсан байгууллагуудаас нь (DMV Department of motor vehicle) тухайн мужийн авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг байгууллагад нь мэдээлэл очиж, тухайн зөрчил гаргасан этгээдийн жолоодох эрхийг хасах, эсхүл машины улсын бүртгэлийг хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна.¹⁰

Мөн авто машины яндангийн утаанаас гарч байгаа хорт хийн зөвшөөрөгдөх хэмжээг тухайн мужийн хотын захиргаанаас жил бүр шалгаж хэрэв шаардлагад нийцэхгүй тохиолдолд мужийн авто машин эзэмшигчидийг бүртгэдэг байгууллагад (DMV Department of motor vehicle) мэдээллийг хүргүүлж улмаар уг авто тээврийн хэрэгслийн дугаарын бүртгэлийг хийдэггүй бөгөөд энэ тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй болдог байна. Өөрөөр хэлбэл авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн газар (DMV), хотын захиргаа, замын цагдаа зэрэг байгууллагууд нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагууд ба эдгээр хоорондоо нягт уялдаатай ажилладаг байна.

АНУ-ын Калифорни мужийн Авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг газар (DMV Department of motor vehicle) нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.¹¹

- Авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг газарт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрчилгээ (эрхийн гэрчилгээ) олгох;
- Жолоочн осол аваар, ял шийтгэлд холбогдсон эсэх талаарх мэдээллийг хадгалах;
- Хувь хүмүүст жолооны үнэмлэх олгох ;
- Усан онгоцны эзэмшигчийн тэмдэглэл болон бүртгэл хийх;

¹⁰ http://www.cyberdrivellinois.com/publications/rules_of_the_road/irr_chap08.html /visited 2011.3.25./

¹¹ http://www.dmv.ca.gov/about/profile/what_dmv_does.htm/visited 2011.3.25./

- Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгч, тээвэрлэгч, нийлүүлэгч, зуучлагч, тээврийн хэрэгслийг борлууллагч, сэлбэг хэрэгсэл худалдагчийг зохицуулах болон гэрчилгээ олгох ;
- Санхүүгийн хариуцлагын хуулийг хэрэгжүүлэх;
- Хэрэглэгчийн гомдолыг шалгах;
- Хуулийн дагуу бүртгэлийг тогтмол шинэчлэж хадгалах;
- Жилд ойролцоогоор 6.5 тэрбум ам доллар цуглуулж улсын орлого болгоно.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан баримт бичигт эрх зүйн ямар зохицуулалтыг тусгасан вэ?

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан зарим орны онцлог зохицуулалтаас доор дурдав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар зохицуулсан тусгайлсан хуультай улсад: Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн вант улс, Украин Улс, Эстоний Улс багтана¹². Испани Улсад "Механик тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ба замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Үндсэн (гол) хууль" хэмээх хууль үйлчилдэг байна. Болгар, Дани, Испани, Украин, Финлянд зэрэг улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль нь энэ салбарыг зохицуулж буй ерөнхий хууль юм.¹³

Норвеги Улсад "Замын хөдөлгөөний тухай" хуулийн зэрэгцээ 1936 оны 7 дугаар сарын 1-ны өдрийн "Зарим төрөл мэргэжил бүхий этгээдийн үүргийн хязгаарлалтын тухай" хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулна. Энэхүү хуулиар зарим төрлийн мэргэжил бүхий этгээд, түүний дотор ачаа тээврийн жолоочийг жолоо барихын өмнө 8 цагийн дотор архи, мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх зүйл хэрэглэхийг бүрэн хоригложээ.¹⁴

Франц Улсын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи онцлог зохицуулалтыг агуулсан хуультай байна. Франц Улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм (5 боть), Замын засвар, үйчилгээний дүрэм, Замын тэмдэг, тэмдэглэгээний болон дохионы тусгай дүрэм зэрэг эрх зүйн баримтууд үйлчилдэг байна.¹⁵ Францын замын хөдөлгөөний дүрмийн 5 боть хууль тогтоох болон журамлах хэсэгт ангилагдахаас гадна, Замын хөдөлгөөнтэй холбоотой

¹² Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах <http://www.auto016.ru> /сүүлд үзсэн 2011.03.03/

¹³ Мөн тэнд.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Мөн тэнд.

бүх асуудлыг зохицуулах иж бүрэн хэм хэмжээг зохицуулсан байна.

ХБНГУ-д “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-иас гадна “Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн тухай хууль”, “Замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрөх тухай хууль” (тус хууль нь жолооны үнэмлэх, хүрээлэн буй орчны бохирдол, тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, зөвшөөрөл зэрэг асуудлыг зохицуулдаг) зэрэг хууль үйлчилдэг.

Шведийн Вант Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр дараахь хуулиуд үйлчилдэг байна. Үүнд¹⁵:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- Жолооч бэлтгэх, жолооны үнэмлэх олгох, жолооны үнэмлэх хурааж авах тухай хууль;
- Жолооч бэлтгэх авто сургуулийн тухай хууль.

Швед Улсад тусгай бие даасан хуулиас гадна: замын хөдөлгөөний журмыг ноцтой зөрчсөн зөрчил (жолооны үнэмлэхгүй буюу согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон); жолооч бэлтгэх болон жолооны үнэмлэх хураах журам; авто сургуульд хамаарах үндсэн шаардлага; зогсоолын журам зөрчсөний торгууль; тээврийн хэрэгслийг албадан зөөвөрлөх тухай; аюултай ачааг тээвэрлэх; зөвшөөрсөн жинг хэтрүүлсний торгууль гэх зэрэг асуудлыг зохицуулсан дээрх хуулиуд үйлчилнэ.

Эстони Улсад тээврийн хэрэгслийн төрөл (нийтийн тээврийн, ачаа тээврийн гэх зэрэг) болгон хуультай байхаас гадна мөн замын тухай хууль ч бий. Мөн тусгай хуулиудаар: захиргааны эрх зүйн хэм хэмжээ зөрчих; тээврийн хэрэгслийн даатгал; замыг хамгаалах, ашиглах, татвар төлөхөд замын хөдөлгөөнд оролцогчид, замын эзэмшигч, өмчлөгчийн хүлээх хариуцлагыг, мөн түүнчлэн тээврийн хэрэгслийг зогсоолын асуудлыг тусгай хуулиудаар зохицуулдаг.

Зарим улс орон зөвхөн замын хөдөлгөөний дүрэм батлан гаргахаар хязгаарлана. Гэвч эдгээр нь эрх зүйн нэгдмэл актын агуулга байхгүй. Жишээ нь замын тэмдэглэгээ хийх болон замын тэмдэг ашиглах журам: Тээврийн механик хэрэгслийн тухай хуулийг хэрэглэх (Австри); автомашин бүртгэх болон тээврийн тооллогын бүртгэлтэй холбоотой, техникийн үзлэг, гэрлэн дохионы зохицуулалт, замын барилга, байгууламжтай холбоотой журам, зам хөндлөн гарах, овор ихтэй болон хүнд даацын автомашины хөдөлгөөнийг зөвшөөрөх процедур (Болгар); тээврийн механик хэрэгсэл, түүний тоног төхөөрөмжийг бүртгэх, жолооны үнэмлэх олгох болон жолооч бэлтгэх (категори

¹⁵ Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах <http://www.auto016.ru> /сүүлд үзсэн 2011.03.03/

бүрийг тус тусад нь, мөн энд жолооны багшийн хүлээх хариуцлагыг мөн тодорхойлж өгсөн), мөн түүнчлэн замын тэмдэг болон дохионы тухай акт (Дани) тус тусдаа үйлчилж байна.

ОХУ болон тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн бусад улс оронд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиуд үйлчилж байна.

ОХУ-ын Замын хөдөлгөөнийг зохицуулах зарим хууль, эрх зүйн актаас [*]		
1.	Захиргааны хариуцлагын тухай ОХУ-ын хууль	2001.12.30
2.	ОХУ-ын Эрүүгийн хууль	1996.06.13
3.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Холбооны хууль	1995.12.10
4.	Тээврийн хэрэгслийн үнэмлэх хэрэглэх тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1993.05.18
5.	ОХУ-ын нутаг дэвсгэр дээр автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч тээврийн хэрэгсэлийн улсын бүртгэлийн тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1994.08.12
6.	ОХУ-д тээврийн хэрэгсэл ашиглах тухай зарим асуудлын ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1992.04.08
7.	ОХУ-ын Дотоод хэргийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газарт бүртгүүлсэн тээврийн хэрэгсэлийн улсын техник үзлэгийг явуулах журмын тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1998.07.31
8.	Замын хөдөлгөөний Дүрмийн тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	1993.10.23
9.	Тусгай гэрлэн болон дохиот тэмдэгийн тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	2006.12.01
10.	Тээврийн хэрэгсэлийн хараат бүс техник шинжилгээ хийх тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	2003.04.24
11.	Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн даатгалд хамруулах тухай журам	2003.05.07
12.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээний тухай ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг	1998.05.16
13.	Тээврийн хэрэгсэлийн бүртгэлийн тэмдэгийг улсын бүртгэлд бүртгэх тухай ОХУ-ын Дотоод хэргийн яамны тушаал	2002.03.28

^{*} Нормативные документы <http://www.gibdd.ru/documents/> (сүүлд үзсэн 2011.03.17)

14.	Олон улсын жолооны үнэмлэхний тухай ОХУ-ын Дотоод хэргийн яамны тушаал	1998.09.28
-----	---	------------

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн зохицуулалт

БНХАУ өндөр хөгжилтэй гүрний хувьд авто замынхаа хөгжлөөр дэлхийд дээгүүрт ордог. Үүнийг дагаад авто замын хөдөлгөөн зохицуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих техник хэрэгсэл нь өндөр хөгжсөн. Замын хөдөлгөөнд тавих хяналтыг замын цагдаа дангаараа бус, ажиглалтын видео камер, фото аппарат зэрэг техник хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэдэг.

БНХАУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн зохицуулалтыг дараах хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно. Үүнд:

1. БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль¹⁷;
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх дүрэм¹⁸;
3. Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ¹⁹;
4. Авто машин жолоодох үнэмлэх авах ба ашиглах дүрэм²⁰.

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. Тус хууль нийт 8 бүлэг, 124 зүйлтэй.

Бүтэц:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар бүлэг. Тээврийн хэрэгсэл ба жолооч

1) авто машин, автобус машин

2) авто машины жолооч

Гуравдугаар бүлэг. Замаар зорчих нөхцөл

Дөрөвдүгээр бүлэг. Замаар зорчих дүрэм

Энгийн дүрэм

Автомашин замаар зорчих дүрэм

Автобус машин замаар зорчих дүрэм

Явган зорчигч ба тээврийн хэрэгслээр зорчигчийн дүрэм

Өндөр хурдны замын тусгайлсан дүрэм

¹⁷ 2003 онд батлагдаж, 2004 оноос мөрдөгдөж байна.

¹⁸ 2004 оны 4 дүгээр сарын 28-нд батлаж, 2004 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

¹⁹ "Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ"-ний 24 дүгээр зүйлд "орон нутгийн шинжтэй дүрэм журамд заасны дагуу жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны хэлбэр хэмжээг зөвхөн тухайн орон нутгийн жолоочийн хувьд "хэрэглэнэ" гэж зааснаас харахад муж, орон нутаг бүрт нэгэн адил дүрэм үйлчилдэггүй байна.

²⁰ 2009 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан.

Тавдугаар бүлэг. Замын ослын зохицуулалт
Зургаадугаар бүлэг. Хуулийн хэрэгжилтийн хяналт
Долоодугаар бүлэг. Хуулийн хариуцлага
Наймдугаар бүлэг. Хавсралт

Тус хууль дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, зохицуулалттай холбоотой зүйл, заалтууд:

4 дүгээр зүйл. Шат шатны Ардын засгийн газар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах ажил ба эдийн засгийн бүтээн байгуулалт болон нийгмийн хөгжилд тохируулан зохицуулах явдлыг баталгаажуулна.

Хошуунаас дээш орон нутгийн шат шатны Ардын Засгийн газар замын хөдөлгөөний хөгжлийн хэрэгцээнд тохируулан, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, төрийн холбогдох бодлогыг баримтлан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

5 дугаар зүйл. Төрийн зөвлөлийн Аюулгүй байдлын яам улс орон даяар авто замын аюулгүй байдлыг удирдах ажлыг хариуцна. Хошуунаас дээш шат шатны Ардын засгийн газар Аюулгүй байдлын байгууллагын замын хөдөлгөөнийг удирдах газар нь тухайн засаг захиргааны нутаг дэвсгэр доторхи авто замын хөдөлгөөнийг удирдан зохицуулах ажлыг хариуцна.

Тус хууль дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалттай холбоотой зохицуулалт:

6 дугаар зүйл. Шат шатны засаг захиргаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи сургалтыг тогтмол явуулж, иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай мэдлэгийг дээшлүүлэх үүрэгтэй.

Байгууллага, газар хэлтэс, нэгж, аж ахуйн байгууллага, иргэний нийгмийн нэгдэл болон бусад байгууллага бүр тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт явуулна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сургуулиуд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтыг эрх зүйн сургалтын агуулгад багтааж явуулна.

Хэвлэл мэдээлэл, радио, телевиз зэрэг холбогдох байгууллага нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт явуулах үүрэгтэй.

7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдан

зохион байгуулах ажилд шинжлэх ухааны судалгааг сайжруулж, тэргүүний, ололтод удирдлагын арга барил, техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, ашиглах.

Тус хуульд замын цагдаагийн ажил үүрэг, эрх хэмжээний асуудлыг хуулийн хэрэгжилтэд тавих хяналт гэсэн бүлэгт тодотгож өгсөн бөгөөд тухайлбал тус хуулийн 83 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд замын цагдаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг болон замын ослын хэргийг шалгаж шийдвэрлэхээс татгалзана. Үүнд:

1. Тус хэргийн холбогдогч (зохигч) эсвэл холбогдогчийн ойрын хамаатан садан;
2. Тухайн этгээд, эсвэл түүний ойрын хамаатан садан тухайн хэрэгт ашиг сонирхлын зөрчилтэй;
3. Тухайн хэргийн холбогдогч болон бусад харилцаа холбооны шалтгаанаар хэргийг шударгаар шийдвэрлэхэд нөлөөлж болзошгүй.

Мөн тус хуулийн 117 дугаар зүйлд "Замын цагдаа албан-тушаал, эрх мэдлээ ашиглан нийтийн эд хөрөнгийг эзэмших, олж авах, авлига авах, эсхүл эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэх байдлаар гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ," гэж хуульчилжээ.

4. Замын хөдөлгөөний зохион байгуулалт, замын хөдөлгөөний зохицуулалт, Авто зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх зохицуулалт ямар байдаг? Ямар баримт бичгээр зохицуулсан байдаг?

Зам засварын ажлын тухайд *ОХУ-ын* Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсны дагуу замыг засварлах, шинээр зам тавих, эвдрэлийг арилгах нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана¹. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, ОХУ-ын субъект улсын гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон хариуцдаг замтай хуулийн этгээд, иргэний хувьд зам засвар, эвдрэл арилгах ажлыг өөрөө хариуцдаг байна. Ингэхдээ улсаас тогтоосон зам засварын журмыг баримтлах буюу мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн зам засвар, барилгын багийг ажиллуулна².

ХВНГУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай

¹ Федеральный Закон о Безопасности дорожного движения 15 ноября 1995 года с изменениями от 2010.07.27/ Статья 11, 12.

² Мөн тэнд, статья 13.

хууль тогтоомжийг зөрчсөн жолоочид торгууль оногдуулдаг байна. Тухайлбал, тогтоосон хэмжээнээс хурд хэтрүүлсэн тохиолдолд цагт 25 км-ээр хэтрүүлсэн бол 200 евро, 30 км-ээр хэтрүүлсэн бол 240 евро, 40 км-ээр хэтрүүлсэн бол 400 еврогоор тус тус торгож, жолооны үнэмлэхийг сарын хугацаатай хураан авдаг байна²³. 150 Евро хүртэлхи хэмжээний торгуулийг газар дээр нь замын цагдаагийн байцаагчид торгуулж, түүнээс дээш хэмжээний торгуулийг 7 хоногийн дотор банкны тодорхой дансанд тушаах ёстой. ХБНГУ-ын хувьд “нууцаар” буюу видео ажиглалт ашиглах, хурдны зам дээр хурд хэмжигч төхөөрөмж байрлуулах зэрэг аргыг ашиглаж зөрчлийг тогтоодог. Тус төхөөрөмж (Police Pilot) нь тогтоосон хурд хэтрүүлэхийг хянахаас гадна, гэрлэн дохионы зөрчил, огцом манёвр хийх зэргийг мэдэрдэг байна.

Украин²⁴, Эстони улсын²⁵ замын хөдөлгөөний хуулиар “Хүрээлэн буй орчны хамгаалалтын хувьд хүлээх үүрэг” хэмээх бүтцийг агуулсан байдаг нь бусад орны зохицуулалтаас онцлог юм. Тус зохицуулалтын дагуу жолооч бусад болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэх, чанга дуу авиа гаргах, их хэмжээгээр утаа гаргах, амьтан болон шувуу дайрахыг хориглодог. Эстони Улсын Замын хөдөлгөөний Дүрмийн 16 дугаар зүйлд зааснаар, жолооч орон сууцны төвлөрөл ихтэй бүсэд 2 минутаас илүү хугацаагаар тээврийн хэрэгсэлээ асаалттай байлгахыг хориглодог байна²⁶. Мөн гол, мөрөн, горхи, усны эргээс 10 м ойр зайд тээврийн хэрэгсэлээ угаах, зориулалтын бүс газар тос, масло солих, хүрээлэн буй орчныг бохирдуулах зүйл гоожиж байгаа тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно. Тээврийн хэрэгслийн гаргах дуу авианы чанга, цацаж буй утааны хэмжээг Эстони Улсын Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны Сайдын тушаалын 5 дугаар зүйлээр тогтоодог ба тогтоосон хэмжээг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг байна.

5. Олон нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сургалтыг ямар байдлаар олгодог?

ОХУ-ын Дотоод явдлын яамны харъяа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын эрх зүйн байдлын тухай ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 711 тоот зарлиг, ОХУ-ын Дотоод явдлын яамны 2003 оны 12 дугаар сарын 2-ны

²³ ПДД в Германии <http://pdd-ru.info/701.php> /сүүлд үзсэн 2011.03.17/

²⁴ Правила Дорожного движения Украины http://auto.meta.ua/autolaw/pdd_rus/ /сүүлд үзсэн 2011.03.17/

²⁵ Правила Дорожного движения Республики Эстония <http://pdd-ru.info/445.php> /сүүлд үзсэн 2011.03.17/

²⁶ Мөн тэнд. 16 дугаар зүйл.

өдрийн №930 тоот "ОХУ-ын Дотоод явдлын яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ухуулгын ажил зохион байгуулах тухай" тушаалын дагуу ОХУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөнд оролцож буй явган зорчигч, тээврийн хэрэгсэл жолоодогчийн эрх, үүрэг, зам дээр гарч буй ослын талаар олон нийтэд мэдээлэх үүргийг ОХУ-ын Дотоод явдлын яамны харъяа Замын хөдөлгөөн аюулгүй байдлын улсын хяналтын газар (ГИБДД) хариуцдаг байна. Өөрийн чиг үүргийн хүрээнд тус байгууллага нь ард иргэдийн дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар, зам дээр гарч буй осол, замын хөдөлгөөнд боловсон, зохистой оролцох, насанд хүрээгүй этгээдийн замын хөдөлгөөнд оролцох, жолоочийн хариуцлагын талаар тус тус сургалт, видео хичээл, материал, зар сурталчилгаа хэлбэрээр ухуулга явуулдаг байна.

Тус тушаал нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ухуулгын арга хэмжээ явуулахад баримтлах журмыг хавсралтаар баталсан бөгөөд тус ухуулгын арга хэмжээг зохион байгуулахдаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- 1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газар нь олон нийтийн дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи ухуулгын ажил явуулах ажиллагаа нь тус байгууллагын хотын замын хөдөлгөөний аюулгүй бүх албадуудад хамааралтай арга хэмжээ байна;
- 2.Ухуулгын ажлыг зохион байгуулахдаа тус байгууллага нь ОХУ-ын Үндсэн хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад эрх зүйн актуудыг мөрдлөгө болгоно.
- 3.Ухуулгын арга хэмжээний гол зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг олон нийтэд бүрэн дүүрэн, зөв зохистой таниулахад оршино.
- 4.Ухуулгын ажлын субъектэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газар, түүний бүрэлдэхүүнд багтаж буй албууд, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, автотээврийн газар, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон нийтийн байгууллагууд, боловсролын байгууллагууд орно.

Судалгааны ажлын асуултын дагуу тус журманд гарч буй олон нийтэд явуулах ухуулгын арга хэмжээний төрлийн хүрээнд авч үзвэл:

- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудал, осол гарч буй нөхцөл байдал, шалтгаан, эрх зүйн шинэ зохицуулалтын талаар мэдээлэх;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжсэн уриатай олон нийтийн гүйлт, автомашины уралдаан, тэмцээн, нээлттэй

хаалганы өдөр зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сэдэвтэй зурагт хуудас, танилцуулга, брошюр, плакат бэлтгэх, хэвлүүлэх, мэдээллийн самбар байрлуулах;

- Галт тэрэгний буудал, нисэх онгоцны буудал, нийтийн тээврийн хэрэгсэл, худалдааны томоохон төвүүд зэрэг олон нийтийн нягтралын газруудад техникийн хэрэгсэл ашиглан замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи мэдээллийг нэвтрүүлэх;

- Насанд хүрээгүй этгээдийн замын хөдөлгөөнд оролцох, тэдгээрийн ослын талаар боловсролын байгууллагатай хамтран ажиллах. Тухайлбал, бага, дунд сургуулийн хүрээнд хүүхдэд зориулсан хичээл зохион байгуулах, сургуулийн бүсэд буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах, сургуулийн гадна тодорхой бүсийн замын хөдөлгөөний схемийг байрлуулах, замд хурдны хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээнүүд орно.

ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын боловсруулсан зарим видео материалын уриалгыг танилцуулахад:

1. “УУСАН БОЛ БҮҮ ЖОЛООД!” ТӨСӨЛ²⁷:

Зорилго:

ОХУ-ын хувьд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үед гарч буй ослын дийлэнх хувь нь баярын үеэр таардаг болох нь тогтоогджээ. Тус арга хэмжээг баярын үе болох 2009 оны 12 дугаар сар, 2010 оны 1 дүгээр саруудад явуулахаар төлөвлөжээ.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1.1. 12 метрийн өндөртэй, ослын улмаас эвдэрсэн машинаар дүүргэсэн архины шилний дүрс бүхий хөшөөг Москва хотын замын хөдөлгөөний оргил цэгт байршуулжээ. Энэ үеэр Москва хотод замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр олон улсын хэмжээний хурал зохион байгуулагдаж байсан бөгөөд гадаад улсын сэтгүүлчид тэрхүү хөшөөг өөрийн улсдаа нэвтрүүлснээр ОХУ төдийгүй гадаадын олон оронд танигджээ;

2.2. “Уусан бол бүү жолоод” уриа бүхий мэдээллийн самбар ОХУ-ын томоохон хотуудын төвд, зурагт хуудсууд орон даяар тараагдсан ба хотын дийлэнхи гаражийн үүдэн дээр уриа бүхий графиттиг байршуулсан байна;

3.3. Авто радиогоор согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үед үүсэх нөхцөл, ослын талаархи мэдээллийг өдөр тутам сонсогч нарт мэдээлсэн төдийгүй телевизээр болон кино театр кино эхлэхийн өмнө зар сурталчилгааны дундуур видео материал нэвтрүүлж байв. Видео материалын агуулгыг товч тайлбарлахад, энгийн нэгэн гэр бүлийн уулзалтын үеэр гэр бүлийн тэргүүн дарс бага зэрэг уусан бөгөөд хоёр хүүхдийн хамт гарч явахдаа аймшигт

²⁷ Кампания «Выпил – не заводись!» <http://www.qibdd.ru/video/1/> /сүүлд үзсэн 2011.03.16/

осолд орох тухай өгүүлнэ.

Гарсан үр дүн:

Тус төслийн талаар ОХУ-ын нутаг дэвсгэр дээр төдийгүй дэлхий олон орны хүрээнд авч хэлэлцэх болсон бөгөөд интернетэд нийт 74 сая хүн тус арга хэмжээний талаар мэдээлэл солилцож, саналаа үлдээжээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас нас барсан хүний тоо өнгөрсөн онуудтай харьцуулахад 2009 оны 12 сард 28 хувиар, 2010 оны 1 дүгээр сард 48 хувиар тус тус буурчээ.

“АЮУЛГҮЙ ХӨДӨЛГӨӨН” ТӨСӨЛ”:

Зорилго:

Зам дээр гарч буй осолын дийлэнхи хувийг эзэлдэг зөрчлүүдийг таван дэд сэдэв болгон хувааж төслийг хэрэгжүүлсэн болно. Энэхүү 5 төрлийн зөрчлийг арилгаснаар зам дээр гарч буй ослын хэмжээ буурах гол нөхцлийг бүрдүүлнэ хэмээн үзсэн байна.

Хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Дээр хэлсэнээр төслийг 5 дэд сэдэвт хуваасан болно. Үүнд:

- “Хурдаа сааруул” (хурд хэтрүүлэх талаар);
- “Биднийг битгий алдаач” (бага насны хүүхэдтэй зам дээр тохиолдож буй ослын талаар);
- “Согтуу хүнийг зогсоо” (согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэж буй хүнийг таслан зогсоох талаар);
- “Хүнлэг бай” (замын хөдөлгөөнд оролцогч нарын ёс зүй, зан харилцааны талаар);
- “Бүсээ бүсэл” (нийт жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүй бүсээ бүслэх талаар сурталчилсан).

“Хурдаа сааруул”. (хурд хэтрүүлэх талаар)-Энэ ажлын хүрээнд видео материал бэлтгэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлсэн байна. “Хурдаа сааруул чамайг хүлээж л байх болно” хэмээх уриатай тус видеоны утгыг тайлбарлавал, бага насны хүүхэд цонх нь дээр аавыгаа хүлээж байхад, аав нь өндөр хурдтай машин жолоодож явж байгаад машины осолд орж байгаа талаар өгүүлнэ.

Мөн энэ ажлын хүрээнд сахисан тэнгэрийн далавчтай охидууд гудамжаар явж “Цагаасаа өмнө тэнгэр лүү нисэхийг хүсэхгүй бол хурдаа хас” гэсэн зөвлөгөө өгч, далавчтай наалтуурыг гарааж байв. Уг наалтуур дээр “Явах заяатай хүн нисэх заяагүй” гэсэн бичиг байв.

“Биднийг битгий алдаач” (бага насны хүүхэдтэй зам дээр тохиолдож буй осолын талаар)-Эцэг, элчүүдийн дунд бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхиж болохгүй, замын ойролцоо талбайд тоглуулахгүй байх талаар сурталчилгаа явуулжээ. Мөн улс даяар дунд сургуулийн

2* О проекте “Движение без опасности” <http://www.qibdd.ru/video/> /сүүлд үзсэн 2011.03.16/

хүүхдүүдийн дунд “Анхааралтай яваарай - БИД” гэсэн сэдэвт тэмцээн зарлан явуулсан байна.

“Согтуу хүнийг зогсоо” (согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэж буй хүнийг таслан зогсоох талаар)-энэ ажлын хүрээнд өөрийн ойр дотны, хайртай хүмүүсээ алдахыг хүсэхгүй байгаа бол согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглохыг уриалсан сурталчилгаа явуулсан байна. Мөн бүрсгэр дүрслэлтэй хуванцар, нэг удаагийн нүдний шил жолооч нарт тарааж, согтуугаар жолоодоход харах байдал нь тэрхүү нүдний шилийг зүүхтэй ижил мэдрэмж төрүүлэх талаар тайлбарлажээ.

“Хүнлэг бай” (замын хөдөлгөөнд оролцогч нарын ёс зүй, зан харилцааны талаар)-ОХУ-ын зар сурталчилгааны зах зээлийн нийт 6 хувийг тээврийн хэрэгслийн борлуулалтын зар эзэлдэг байна. Гэтэл жолоочийн харилцаа, ёс суртахууны талаар мэдээлэл хомс байдаг. Энэ үүднээс тус төслийн хүрээнд жолоочийг зам дээр ёс суртахуунтай, эелдэг, хүнлэг харилцахыг уриалсан сурталчилгаа явуулсан байна. Мөн “гахайн” дүрстэй, “Хүн хэвээрээ бай” гэсэн бичигтэй машинд тавьдаг агааржуулагчийг тараажээ.

“Бүсээ бүсэл” (нийт жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүй бүсээ бүслэх талаар сурталчилсан)-тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүйн бүсээ байнга бүслэх талаар сурталчилгааны ажил явуулж, “өглөө гэрээсээ гарахдаа охиноо үнсээд 5 давхар цонхноосоо үсэрч байгаа” гэсэн утгатай реклам нь 50 км хурдтай аюулгүй бүсгүй тээврийн хэрэгсэл жолоодох нь 5 давхар орон сууцнаас үсэрч амиа хорлохтой адил гэдгийг үзүүлжээ.

Гарсан үр дүн:

“Аюулгүй хөдөлгөөн” төсөл нь нийт ОХУ-ын нутаг дэвсгэр дээр өргөнөөр хэлэлцэгдэж, телевизийн нэвтрүүлэг, мэдээ, интернетийн блогоор маш өргөн хүрээнд хэлэлцэгдсэн сэдэв болсон юм. Төслийн үр дүнд тээврийн хэрэгслийн ослын улмаас нас барагсдын тоо 10 хувиар буурсан нь 3 000 хүний амь насыг авч үлдсэн гэж хэлж болно.

Жолооны эрхийн шалгалт

АНУ-ын Иллиноис мужийн хувьд жолооны шалгалт нь жолоодох үр чадварыг шалгах явдал юм. Тээврийн хэрэгсэл нь зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжийн хувьд бүрэн бүтэн аюулгүйн ажиллагааг сайн хангасан байх ёстой. Хэрвээ тээврийн хэрэгсэл Иллиноис мужид бүртгэгдсэн бол хүчин төгөлдөр гэрчилгээг Иллиноис мужийн хуулийн дагуу ил харагдах газарт наасан байх ёстой. Хэрвээ тээврийн хэрэгсэл Иллиноис мужаас гадна бүртгэгдсэн бол тухайн мужийн хуулийн шаардлагын дагуу бүртгүүлнэ. Тухайн тээврийн хэрэгсэл нь хөнгөлөлт эдэлдгүй бол Иллиноис мужийн албан ёсны даатгалын

хуулийг заавал биелүүлэх ёстой. Жолооны албаны хэлтэст тээврийн хэрэгсэл даатгагдсан гэдгийг батлан харуулахыг шаарддаг. Шалгалт өгч байхдаа замын хөдөлгөөний хууль зөрчих эсвэл аюултай үйлдэл хийвэл шууд шалгалтанд унах зохицуулалттай байна.²⁹

6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээг ямар төрөл байдаг, хариуцлагыг хэрхэн хүлээлгэдэг? Торгуулыг бэлэн бус хэлбэрээр ногдуулж байгаа зохицуулалт? Манай улсад нэвтрүүлэх боломжтой эсэх?³⁰

ОХУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тээврийн хэрэгсэл жолоодогч нь хуулинд заасан журмын дагуу сахилгын, захиргааны, эрүүгийн болон бусад төрлийн хариуцлага хүлээнэ³¹.

ХБНГУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу замын цагдаа ямар ч тохиолдолд бичиг баримтаа шалгуулахыг жолоочоос нэхэх эрхтэй ба энэ тохиолдолд бичиг баримт шалгах болсон шалтгаанаа тайлбарлах үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд жолооч Führerschein буюу жолооны үнэмлэх, Kraftfahrzeugschein буюу тээврийн хэрэгсэлийн гэрчилгээг шалгуулах үүрэг хүлээнэ. Замын цагдаагийн тус үйлдэл нь тухайн жолоочийн эрхийг зөрчиж байгаа хэмээн үзвэл тухайн жолооч дээд шатны байгууллага болох прокурорын газар (Staatsanwaltschaft) хандах эрхтэй.

Торгуулийг торгууль оногдуулах тухай баримтанд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаандаа төлөөгүй гул алданги тооцож, торгуулийн хэмжээ ихсэх талаар Mahnung буюу сануулга өгнө³².

ХБНГУ-д Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ногдуулахаас гадна жолоодох эрхийг нь хураах хүртэл арга хэмжээ авна. 150 хүртэл еврогийн торгуулийг газар дээр нь төлөх ба үүнээс их торгуулийг 7 хоногийн дотор банкинд тушаасан байх ёстой гэнэ. Торгуулийн төлбөрийг заасан хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд төлбөрийн хэмжээ хоног тутамд нэмэгдэнэ. Үүнээс гадна хүнд гэмт хэрэг буюу ноцтой зөрчил гаргасан жолоочид торгуулийн оноо тооцох бөгөөд уг оноог Германы умард хэсэгт орших Фленсбург хотын төв банкинд (үүнийг "зөрчигсэнийг бүртгэх компьютер"-

²⁹ http://www.cyberdrivellinois.com/publications/rules_of_the_road/rtdoc.html /visited 2011.3.28/

³⁰ 6.7 дугаар асуултын хариулыг нэгтгэв.

³¹ Федеральный Закон о Безопасности дорожного движения 15 ноября 1995 года /с изменениями от 2010.07.27/ Статья 31.

³² Мөн тэнд.

«Flensburger Verkehrssunder-Datei» гэж нэрлэнэ) бүртгэдэг байна. Жолоочийн торгуулийн оноо тогтоосон хязгаараас давсан тохиолдолд түүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх цуцлагдаж, түр хугацаагаар эрх хасах шийтгэл ногдуулна.

Герман улсад Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргагсад хариуцлага тооцох механизм их боловсронгуйд тооцогддог. Зөрчлийн төрөл болон тэдгээрт ногдуулах шийтгэлийн арга хэлбэрийг «Торгуулийн цэс (Bussgeldkatalog)» хэмээх баримт бичигт нэг бүрчлэн тоочсон байх бөгөөд санаанд оромгүй зөрчлийг ч нарийвчлан жагсаасан байлаг. Замын цагдаа нар зөрчил илрүүлэхдээ мэргэшсэн бөгөөд хөдөлшгүй баримт нотолгоон дээр тулгуурладаг. Хотын төвийн болон гаднах замуудад, ялангуяа гэрлэн дохионуудын дэргэд байрлуулсан хяналтын автомат фото аппаратууд нь жолоочийн хурд хэтрүүлсэн, хөдөлгөөний чигээ огцом өөрчилсөн, хориглосон дохиогоор нэвтэрсэн зэрэг зохисгүй үйлдлүүдийг тэр даруй фото хальснаа баримтжуулж цагдаагийн хөдөлгөөнт эргүүлүүдэд шүүрхай мэдээлдэг. Хэтрүүлсэн хурдны хэмжээг алсын зайнаас мэдрэгч төхөөрөмжүүд өндөр нарийвчлалтайгаар тогтоох зэргээр өндөр хөгжсөн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар зөрчлийг илрүүлдэг байна.

Зөрчил гаргагсад хүлээлгэх хариуцлагыг хэрхэн тооцогийг дараах жишээнээс харж болно. Үүнд:

Суурин газарт тээврийн хэрэгслийн тогтоосон хурдыг дор дурдсан хэмжээгээр хэтрүүлбэл дараах шийтгэлийг ногдуулна:

- цагт 10 хүртэл км-ээр хэтрүүлбэл 15 евро;
- цагт 11-15 км-ээр хэтрүүлбэл 25 евро;
- цагт 16-20 км-ээр хэтрүүлбэл 35 евро;
- цагт 21-25 км-ээр хэтрүүлбэл 50 евро + торгуулийн 1 оноо;
- цагт 26-30 км-ээр хэтрүүлбэл 60 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 31-40 км-ээр хэтрүүлбэл 100 евро + торгуулийн 3 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 41-50 км-ээр хэтрүүлбэл 125 евро + торгуулийн 4 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 51-60 км-ээр хэтрүүлбэл 175 евро + торгуулийн 4 оноо + 2 сараар эрх хасах;
- цагт 61-70 км-ээр хэтрүүлбэл 300 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах;
- цагт 70 км-ээс дээш хэтрүүлбэл 425 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах.

Суурин газрын гаднах замд тээврийн хэрэгслийн тогтоосон хурдыг дор дурдсан хэмжээгээр хэтрүүлбэл дараах шийтгэлийг ногдуулна:

- цагт 10 хүртэл км-ээр хэтрүүлбэл 10 евро;

- цагт 11-15 км-ээр хэтрүүлбэл 20 евро;
- цагт 16-20 км-ээр хэтрүүлбэл 30 евро;
- цагт 21-25 км-ээр хэтрүүлбэл 40 евро + торгуулийн 1 оноо;
- цагт 26-30 км-ээр хэтрүүлбэл 50 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 31-40 км-ээр хэтрүүлбэл 75 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 41-50 км-ээр хэтрүүлбэл 100 евро + торгуулийн 3 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 51-60 км-ээр хэтрүүлбэл 150 евро + торгуулийн 4 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 61-70 км-ээр хэтрүүлбэл 275 евро + торгуулийн 4 оноо + 2 сараар эрх хасах;
- цагт 70 км-ээс дээш хэтрүүлбэл 375 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах.

АНУ-ын хувьд видео ажиглалтын аргаар аливаа төрлийн зөрчлийг илрүүлдэг бөгөөд зөрчил гаргасан этгээд тун удахгүй өөрийн гаргасан зөрчил, торгуулийн хэмжээ, төлөх банкны мэдээллийг шуудангаар хүлээн авах болно³⁴. АНУ-ын хувьд зам нь “нээлттэй ном” гэж нэрлэдэг. Учир нь тус улсын хувьд замын хөдөлгөөний дүрмийг замын хажууд зургаар тайлбарласан байдаг ба тус тайлбар нь гадаадын иргэд ч ойлгох боломжтой байдгаараа давуу талтай. Энэ тохиолдолд замын хажуугийн тэмдэглэгээгээр анхааралтай харж явбал дүрмийн зөрчил гаргахгүй байх боломжтой.

Торгуулийг бэлнээр эсхүл чекээр буюу онлайнаар төлж болдог байна. Торгуулийг зөрчлөөс хамааран өөр өөр субъектүүд оногдуулдаг байна. Жишээ нь: АНУ-ын Калифорни мужид л гэхэд хотын захиргааны авто тээврийн хэрэгслийг зам дээр буруу тавьсан тохиолдолд зөрчлөөс нь хамааран 50-1804 доллараар торгодог. Мөн хурд хэтрүүлсэн нөхцөлд замын цагдаа торгууль оногдуулдаг. Харин тухай зөрчилд торгуулиар өөр шийтгэл оногдуулахаар бол түүнийг шүүхэд шилжүүлдэг бөгөөд жолоодох эрхийн үнэмлэхийг хураан авдаг байна. Харин улаан гэрэл дохион журам зөрчсөн нөхцөлд камераар зөрчил гаргасан тохиолдлыг бичиж шуудангийн хаягаар торгуулийг хотын захиргаа хүргүүлдэг байна. Торгуулийн шийтгэвэрт гомдол гаргах эрхтэй байдаг байна.

АНУ-ын Иллиноис мужийн Замын хөдөлгөөний дүрэм (2010 он)³⁴-д зааснаар жолоодох эрх олгохоос татгалзах, жолоодох эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох мөн дээр дурдсанаар торгох зэрэг шийтгэлийг оногдуулж байна. Эдгээрээс жолоодох эрхийг ямар тохиолдолд хүчингүй болгодог зохицуулалтыг авч үзвэл:³⁵

Хүчингүй болгох гэдэг нь тодорхойгүй хугацаагаар жолооны эрхийг мужийн захирагчийн албанаас хасахыг хэлдэг. Жолооны эрхээ дахин

³⁴ ПДД США <http://pdd.ru.info/701.php> /сүүлд үзсэн 2011.03.17/

³⁵ http://www.cyberdriverillinois.com/publications/rules_of_the_road/rdoc.html /visited 2011.3.28/

³⁶ Мөнд тэнд

авахаар хуульд өөрөөр заагаагүй бол доод тал нь 1 жилийн дараа дахин хандаж болно.

Доорх зөрчлүүд жолооны эрхийг хүчингүй болгоно. Харин хязгаарлахгүй.

- Анхаарал болгоомжгүйгээр хүн алах- Болгоомжгүйгээр жолоодооны улмаас хүн амь нас хохироох (доод тал нь 2 жилийн хугацаатайгаар хүчингүй болгоно.)

- Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих

- а. Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьж хүний эрүүл мэндэд хохирол учруулах эсвэл хүний амь нас хохироох;

- б. Болгоомжгүйгээр хүний амь нас хохироох ял шийтгэл өмнө нь авч байсан эсхүл хүндрүүлэх нөхцөлтэйгээр согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьж хүний амь нас хохироох;

- в.3 дахь удаагаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьсан үүний улмаас ял шийтгэгдэж байсан;

- г.тээврийн хэрэгслийн даатгалгүй эсвэл хүчин төгөлдөр жолоодох эрхийн зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих;

- д. хүүхэд сургуулийн автобусаар тээвэрлэж байхдаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэж жолоо барьсан гэмт хэрэг үйлдсэн;

- е.тухайн гэмт хэргийн төрөл болон өмнөх түүхээс хамаарч хамгийн богино хугацаагаар хүчингүй болгох шийтгэл оногдуулахгүйгээр ял шийтгэл хүлээлгэдэг.

- “Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих”³⁶

- а. Мансууруулах бодис болон хар тамхи, архи хэрэглэн жолоо барих.

- б. 21 нас хүрээгүй хүн анх удаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд доод тал 2 жилийн хугацаатайгаар хүчингүй болгох шийтгэл ногдуулна. Өмнөх түүхээс нь хамаарч хамгийн богино хугацаатайгаар хүчингүй болгон өөрчилж болно.

- Хүнд гэмт хэрэг (хүнд гэмт хэрэг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан нөхцөлд);

- Хэрэг явдал болсон газрыг орхих (авто тээврийн ослын улмаас

³⁶ driving under influence “Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих гэсэн утгатай”. Орчуулсан ЭША Л. Амаржаргал

“Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих” бол хүнд гэмт хэргийн нэг төрөл бөгөөд Иллиноис муж хүч хэрэглэсэн гэмт хэрэг гэж ангилсан. Энэ төрлийн гэмт хэрэг хийсэн тохиолдолд жолооны бүртгэлд тэмдэглэн үлдэнэ. Хэрвээ баривчлагдсан эсвэл шийтгэгдсэн бол жолоодох эрх болон тээврийн хэрэгслийн бүртгэлээ алдаж магадгүй мөн тогтруулах юмуу шоронд сууна. Дахин баривчлагдах эсвэл ял шийтгүүлэх юм бол хүнд шийтгэл ногдуулдаг.

хүн нас барсан эсвэл гэмтсэн тохиолдолд орхиж явах;

- Хуурамч мэдүүлэг өгөх-буруу ташаа мэдээлэл төрийн байгууллагад өгөх;

- Болгоомжгүйгээр жолоодох-12 сарын дотор 3 удаа болгоомжгүйгээр жолоо барьсан гэсэн шийтгэл авсан, эсвэл тийм байдалтай жолоодсоны улмаас хүний биед хүнд гэмтэл учирсан, тахир дутуу болсон, бусад хүнийг зэрэмдэг болгосон;

- Хүндрүүлсэн байдлаар болгоомжгүй жолоо барих-Болгоомжгүйгээр жолоо барьсаны улмаас хүний биед хүнд гэмтэл учруулж, тахир дутуу болгосон, бусад хүнийг зэрэмдэг болгох;

- Гудамжинд уралдах-Бусад тээврийн хэрэгсэлтэй хууль бусаар уралдах;

- Болгоомжгүйгээр харьцах-Болгоомжгүй зангаар тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл учруулах эсвэл аюултай байдалд оруулах;

- Авто хулгай-Тээврийн хэрэгсэл болон тээврийн хэрэгслийн эд ангийг хулгайлах;

- Цагдаагаас зугтах- Цагдаа зогс гэж дохиход зугтаах.

Финлянд Улсын хувьд зам дээр гарсан осол, зөрчилл бага арал тоогоор дэлхийд тэргүүлдэг улс юм¹⁷. Финлянд Улсын хувьд видео ажиглалтын тоног төхөөрөмжийг маш өргөнөөр хэрэглэдэг нь зөрчлийг таслан зогсоох гол арга байдаг. Финляндын хувьд торгуулийн хэмжээ маш өндөр байдаг ба тус улсын жолооч нар замын хөдөлгөөний дүрэм баримтлах байдал, жолоочийн ёс зүй, харилцаагаараа бусад улсаас огцом ялгардаг байна¹⁸.

Гадаадын дийлэнхи улс орнууд жолоочид материаллаг хариуцлага оногдуулах бодлогыг баримталдаг. Энэ нь зөвхөн их хэмжээний торгууль бус, мөн тээврийн хэрэгсэлийг хурааж авах, жолооны үнэмлэх хүчингүй болгох, тээврийн хэрэгслийн зайлшгүй даатгалын хэмжээг ихэсгэх зэрэг арга хэмжээ юм.

Тухайлбал, ХБНГУ-д зөрчил гаргасан жолооч тодорхой торгуулийн оноо цуглуулах ба онооны өсөлтөөс түүний даатгалд төлөх дүнгийн хэмжээ 1000 евро хүртэлхи хэмжээгээр өсөх болдог. 3000-4000 Евроны дундаж цалинтай германы иргэний хувьд энэ нь өндөр төлбөр бөгөөд зарим жолооч нар зөрчил гаргасны хариуд даатгалын төлбөрөө төлөх хүртэл жил хүртэл хугацаанд тээврийн хэрэгсэлээ жолоодохгүй явганаар явах тохиолдол гардаг байна. Мөн энэ жишиг АНУ-д хэрэглэдэг. Гадаадын зарим оронд замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг зөрчсөн тохиолдолд торгуулийн хэмжээг оногдуулахдаа дараахь үзүүлэлтийг харгалзаж оногдуулах бодлого баримталж байна. Тухайлбал, торгуулийн хэмжээ оногдуулахдаа

¹⁷ Информация по ПДД и вожению автомобиля в Финляндии <http://pdd-ru.info/701.php>
/сүүлд үзсэн 2011.03.17/

¹⁸ Мөн тэнд.

дараахь үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд: 1. Зөрчил гаргагчийн сарын орлогын хэмжээ (татварыг хассан дүнгээр), 2. Зөрчил гаргагчийн жилийн орлогын хэмжээг тус тус харгалзаж үзэх болжээ”.

Франц, Герман, Итали, Испани зэрэг улсын хувьд торгууллын системтэй онооны системийг *хослуулан* хэрэглэдэг бөгөөд энэхүү зохицуулалт нь гадаадын иргэнд мөн ижил хүчинтэй үйлчилдэг байна. Одоогийн байдлаар АНУ, Беларусь, Герман зэрэг улсад тээврийн хэрэгсэл жолоодох үед тамхи татаж болохгүй талаархи зохицуулалт бүхий хууль бэлтгэгдэж, яригдаж байгаа бөгөөд Австралийн хувьд машинд 12 наснаас доош насны хүүхэд байгаа тохиолдолд тээврийн хэрэгсэлд тамхи татахыг хориглодог байна. Их Британийн Засгийн газраас олон нийтийн шаардлагаар нойрмог байдалтай тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох тухай зохицуулалт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмэнд оруулжээ”.

Израиль Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм бусад орноос огцом ялгардаггүй байна. Зарим нэг онцлог талуудыг дурьдвал, тус улсын хувьд тээврийн хэрэгслийг заавал хоёр гараараа жолоодох үүрэгтэй, тээврийн хэрэгслийн үрд сууж байгаа болон хойно сууж байгаа бүх зорчигчид заавал аюулгүйн бүс зүүсэн байх, 4 хүртэлхи насны хүүхдүүд тусгай хүүхдийн суудалд суусан байхыг шаарддаг. Тээврийн хэрэгслийн жолооч нь өөрийн согтуурлын хэмжээг тусгай төхөөрөмжөөр шалгуулахыг татгалзах нөхцөл нь түүний согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоныг хүлээн зөвшөөрч байна гэж тооцдог байна.

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд хариуцлагын талаар заасан нь:

Тус хуулийн 7 дугаар бүлэг нь “Хуулийн хариуцлага” гэсэн нэртэй 88 дугаар зүйлд зааснаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд дараахь шийтгэлийг оногдуулна. Үүнд: анхааруулах, торгох, жолооны үнэмлэхийг түр хураах, эсвэл хүчингүй болгох, баривчлах орно.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчигсөд хүлээлгэх хариуцлагын хэмжээ гаргасан зөрчлөөсөө хамаараад харилцан адилгүй. Тухайлбал 87 дугаар зүйлд зааснаар “хэрвээ гаргасан зөрчил хөнгөн, замын хөдөлгөөнд нөлөө үзүүлэхээргүй бол үйлдсэн зөрчлийг хэлж, аман байдлаар анхааруулаад хөдөлгөөнд оролцуулна.” гэж заажээ. Тэгвэл 101 дүгээр зүйлд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж, автын онц том осол гаргаж, гэмт хэрэг үйлдсэн

²² Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах <http://www.auto016.ru> /сүүлд үзсэн 2011.03.03/

²³ Мөн тэнд.

бол хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэж, цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний удирдах газраас жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгоно. Авто замын осол гаргасны дараа оргон зугтасан бол цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний газраас жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгож, насан туршдаа авто машин жолоодох эрхийн үнэмлэх дахин олж авах эрхгүй болно гэж хатуу заасан байдаг.

Зарим онцлог зохицуулалт

89 дүгээр зүйл. Явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигч, авто биш тээврийн хэрэгслийн жолооч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн бол анхааруулах, эсвэл таваас тавь хүртэл юаниар торгох; авто биш тээврийн хэрэгслийн жолооч нь торгуулийн шийтгэлийг эсэргүүцсэн бол түүний авто биш тэргийг хурааж авна.

90 дүгээр зүйл. Авто тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж замаар зорчсон бол анхааруулах, эсхүл хориос хоёр зуу хүртэл юаниар торгож шийтгэнэ. Тус хуульд өөрөөр заасан бол тухайн заалтын дагуу шийтгэнэ.

91 дүгээр зүйл. Согтууруулах ундаа хэрэглэсний дараа тээврийн хэрэгсэл жолоодсон бол 1-3 сар хүртэл хугацаагаар жолооны үнэмлэхийг хураан авч, хоёр зуугаас таван зуу хүртэл төгрөгөөр торгож шийтгэнэ. Согтууруулах ундаа хэрэглэж согтуурсан үедээ авто машин жолоодсон бол цагдаагийн байгууллагын замын цагдаагийн газар эрүүлжүүлэх арга хэмжээ авч 15 хоног хүртэл баривчлах болон 3-6 сар хүртэл хугацаагаар жолооны үнэмлэхийг хураан авч, таван зуугаас хоёр мянга хүртэл юаниар торгож шийтгэнэ.

8. Жолоочийн хариуцлагын онооны системийн зохицуулалт ямар байдаг?

Торгуулийн оноогоор шийтгэх систем

Онооны систем нь 1974 оны 5 дугаар сард Германд анх үүссэн. 1960-аад оны үед Германд авто замын осол эрс ихэссэн бөгөөд түүнтэй тэмцэх арга боловсруулсан нь энэхүү "Онооны систем" юм. "Онооны систем"-ийн анхдагч зорилго нь замын хөдөлгөөний хууль тогтоомжийг давтан зөрчигчийн үйлдлийг тодорхойлох, таслан зогсооход оршиж байжээ. Замын хөдөлгөөний дүрэм давтан зөрчигчийн хайхрамжгүй, болгоомжгүй байдлыг тодорхойлох зорилгыг мөн агуулсан¹¹.

¹¹ http://www.fit-to-drive.com/2006/downloads/Schade_KBA.pdf

Замын хөдөлгөөний зөрчлийг тооцох онооны систем гэдэг нь гаргасан зөрчилд оноо тооцох замаар жолооны эрхэд шийтгэл оногдуулах арга хэмжээ юм. Шийтгэлийн оноо нэмэгдэх болон хасагдаж болно. Зөрчлийн төрлийг тодорхой нарийн заалтаар ангилж, оноо тооцсоноор жолооны үнэмлэхийг түр хураах, хүчингүй болгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж өгдөг.⁴² Энд тэмдэглэн хэлэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчигсөд торгуулийн арга хэмжээ авахын зэрэгцээ гаргасан зөрчлийг оноогоор бүртгэж, тодорхой хугацаанд⁴³ тогтоосон хязгаарт⁴⁴ хүрвэл арга хэмжээ тооцох арга юм. Улс орон бүрт нэгэн адил биш боловч нийтлэг шинжтэй зохицуулалтыг тухайн улс өөрийн үндэстний онцлогт тохируулан тусгадаг байна.

Гадаад орнуудын зохицуулалт

Онооны системийг хэрэгжүүлсэнээр Германд замын хөдөлгөөний зөрчил буурсан үр дүн гарсан учир бусад улс орон авч хэрэгжүүлсэн. Өнөөгийн байдлаар АНУ, Австрали, Япон, Итали, Франц, Чех, Хятад, Тайвань, Хонгконг зэрэг олон оронд энэхүү арга хэмжээг хэрэглэж байна.

Чех Улсад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочид мөнгөн торгууль ногдуулахаас гадна торгуулийн оноогоор шийтгэнэ. Торгуулийн оноог тухайн жолоочийн харъяалагдах хотын захиргаа бүртгэх бөгөөд 12 оноо хүрсэн тохиолдолд жолоодох эрх хасах шийтгэл ногдуулна. Тухайлбал, гадаадын харъяат иргэн торгуулийн 12 оноогоор шийтгүүлсэн тохиолдолд 1 жилийн хугацаагаар Чех улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй болно.

Торгуулийн оноогоор шийтгүүлсэн жолооч тодорхой хугацааны туршид (тухайлбал: 12, 24, 36 сар гэх мэт) дахин зөрчил гаргаагүй бол уг оноог нь шат дараалан бууруулах замаар урамшуулал үзүүлэх бөгөөд энэ нь тухайн жолоочид замын хөдөлгөөний дүрмийг сахин мөрдөх хүсэл эрмэлзэл төлөвшүүлэхэд хөшүүрэг болох ач холбогдолтой гэдэг. Торгуулийн оноог тухайн зөрчлийн агуулгад нийцүүлэн ногдуулах бөгөөд нэг удаагийн хөнгөн зөрчилд 1 оноо, ноцтой зөрчилд хамгийн дээд оноо буюу 7 оноо ногдуулдаг байна. Тухайлбал:

- замын тэмдэг, тэмдэглэлийн заалт зөрчсөн бол 1 оноо;
- хорооллын доторхи хөдөлгөөний журам зөрчсөн бол 1 оноо;
- тууш замд хориглосон тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон бол 1 оноо;

⁴² http://en.wikipedia.org/wiki/Point_system_%28driving%29

⁴³ Ихэвчлэн 12 сар буюу 1 жилийн хугацааг оноо тооцох 1 бүтэн хугацаа гэж үздэг.

⁴⁴ Ихэнх улсад оноо тооцох 12 сарын хугацаанд 12 оноог дээд хязгаар гэж авсан байдаг.

Тухайлбал Герман, Япон, Хятад, Чех зэрэг улсуудад оноо тооцох нэг бүтэн хугацаанд 12 оноо хүрвэл жолоочийн эрх хасагдана. Гэтэл дээд оноо 24 байхыг заасан орон бас байдаг.

- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 20 хүртэл км-ээр хэтрүүлсэн бол 2 оноо;
- хамгаалах бүс, хамгаалах малгай хэрэглээгүй бол 2 оноо;
- тээврийн хэрэгслийн даацыг хэтрүүлсэн бол 3 оноо;
- жолоочийн цусан дахь спиртийн агууламж 0.3 промилл хүртэл байвал 3 оноо;
- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 20-40 км-ээр хэтрүүлсэн бол 3 оноо;
- тээврийн хэрэгсэл жолоодож яваа үедээ гар утсаар ярьсан бол 3 оноо;
- хуурамч улсын дугаар хэрэглэсэн бол 4 оноо;
- давуу эрх бүхий хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгөөгүй бол 4 оноо;
- хориглосон дохиогоор нэвтэрсэн бол 5 оноо;
- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 40 км-ээс дээш хэтрүүлсэн бол 5 оноо;
- техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол 5 оноо;
- замын хориотой хэсэгт буцаж эргэсэн, ухарсан, урсгал сөрсөн бол 6 оноо;
- хориотой байдлаар гүйцэж түрүүлсэн бол 6 оноо;
- цусан дахь спиртийн агууламж 0.3 промиллоос илүү (гэхдээ согтоогүй) байвал 6 оноо;
- согтуурсан буюу мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол 7 оноо;
- согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулахаас зайлсхийсэн бол 7 оноо.

БНХАУ-д замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ногдуулахаас гадна торгуулийн оноогоор шийтгэх систем үйлчилдэг. Энэ нь “Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ”, “Авто машин жолоодох үнэмлэх авах ба ашиглах дүрэм” зэрэг журам дүрэмд бүрэн тусгагдсан, нэлээд боловсронгуй зохицуулалт юм. Энэ нь тухайн жолооч 12 сар буюу нэг жилийн хугацаанд жолооч 12-оос илүү торгуулийн оноо авсан тохиолдолд түүний жолоодох эрх хүчингүй болох ба жолоодох эрхээ сэргээлгэхэд заавал шалгалт өгөх ёстой болно. Шалгалтад тэнцсэн тохиолдолд өмнөх торгуулийн оноонуудыг хүчингүйд тооцож, жолоодох эрхийн үнэмлэхийг буцааж олгоно.

Нэг жилийн хугацаанд 12-оос илүүгүй торгуулийн оноо авсан жолооч мөнгөн торгуулийн төлбөрөө хугацаандаа төлсөн бол түүний оноонуудыг хүчингүйд тооцно. Харин төлбөрөө барагдуулаагүй бол уг торгуулийн оноонуудыг дараагийн жилд нь шилжүүлж тооцдог байна. Мөн зөрчилд ногдуулсан мөнгөн торгуулийг 3 сарын дотор төлж барагдуулаагүй, эсхүл хоёр удаа торгууль төлөлтийг хожимдуулсан

бол торгуулийн 12 оноогоор шийтгүүлнэ. Өөрөөр хэлбэл, эрх шууд хасагдана.

“Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ”-нд шийтгэлийн онооны утга агуулга, шийтгэлийн оноог хэрхэн хэрэгжүүлэх, дахин шалгалтад хамрагдах журам, түүнчлэн зөрчил гаргаагүй буюу оноогоор шийтгэгдээгүй жолоочийг хэрхэн урамшуулах талаар тодорхой зааж өгчээ.

Жолоочид тухайн гаргасан зөрчлийнх нь агуулгаас хамааруулан 1, 2, 3, 6, 12 гэсэн торгуулийн оноог ногдуулна. Дараах нийтлэг⁴⁵ байдлаар дүйцүүлэн торгуулийн оноогоор шийтгэнэ.

Үүнд, 12 оноо:

- тухайн ангилалд үл тохирох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодсон;
- согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл согтуурсан үедээ авто машин жолоодсон;
- зорчигч тээвэрлэгч машин зорчигчдын тоон хэмжээг 20-оос дээш хувиар хэтрүүлэн тээвэрлэсэн;
- авто осол гаргасны дараа оргон зугатсан, гэхдээ гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол;
- хуурамчаар үйлдсэн эсвэл өөрчлөлт оруулж үйлдсэн улсын дугаар, жолооны үнэмлэх, жолоочийн үнэмлэхийг ашигласан, эсвэл бусад тээврийн хэрэгслийн улсын дугаар, жолооны үнэмлэх ашигласан;
- өндөр хурдны зам дээр тээврийн хэрэгслээр ухарч буцах, эргэх, тусгаарлах зурвас хэтрэх.

6 оноо:

- жолооны үнэмлэхээ түр хугацаагаар хураалгасан үедээ авто машин жолоодсон;
- зорчигч тээвэрлэх зохистой тоог хэтрүүлсэн боловч хэтрүүлсэн хэмжээ 20 хувиас доош бол;
- хурдны тогтоосон дээд хязгаарыг 50 хувиар хэтрүүлсэн;
- өндөр хурдны замын зорчих хэсэгт тээврийн хэрэгсэлээ зогсоосон;
- тэсэрч дэлбэрэх аюултай болон шатамхай химийн бодис, бүтээгдэхүүн болон хортой, хийтэй зэрэг аюултай эд зүйлсийг тогтоосон хугацаа, зам, хурдны хэмжээг зөрчиж тээвэрлэсэн, эсхүл анхааруулга тэмдгийг хэрэглээгүй, аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээг аваагүй;
- зорчигч тээвэрлэсэн болон аюултай шинж бүхий ачаа тээвэрлэсэн тохиолдолд тээврийн хэрэгсэлээ жолоодож явсан хугацаа 4 цаг хүрэхэд зогсоолгүй, үргэлжлүүлэн тээвэрлэсэн, эсвэл зогсоосон боловч 20 минутаас бага хугацаагаар зогсоож

⁴⁵ “Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ”-ний 24 дүгээр зүйлд “орон нутгийн шинжтэй дүрэм журамд заасны дагуу жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны хэлбэр хэмжээг зөвхөн тухайн орон нутгийн жолоочийн хувьд хэрэглэнэ” гэж зааснаас харахад муж, орон нутаг бүрт нэгэн адил дүрэм үйлчилдэггүй байна.

амраасан бол;

- зам дээр жолоодож буй тээврийн хэрэгслийн улсын дугаарыг зүүгээгүй, эсвэл дугаарыг санаатайгаар эвдэж, гэмтээсэн, эсхүл зохих журмын дагуу байрлуулаагүй;

- нууцаар болон хуурч мэхлэх замаар жолооны үнэмлэх олж авсан.

3 оноо:

- Ачааны тээврийн хэрэгслийн даацыг зохистой хэмжээний 30 хувиас дээш хэмжээгээр хэтрүүлэн тээвэрлэсэн эсхүл зорчигч тээвэрлэх журмыг зөрчсөн;

- Нийтийн зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгслээс бусад зорчигч тээвэрлэх машин зорчигчдын зохист тоог 20 хувиас дээш хэмжээгээр хэтрүүлсэн;

- Гэрэл дохио зөрчсөн;

- хурдны тогтоосон дээд хязгаарыг 50 хувиас бага хэмжээгээр хурд хэтрүүлсэн;

- өндөр хурдны зам дээр зөвшөөрөгдсөн хурдны доод хэмжээнээс бага хурдаар жолоодсон;

- өндөр хурдны замаар зорчихыг хориглосон тээврийн хэрэгсэл өндөр хурдны зам руу орж зорчсон;

- хориглосон болон анхааруулсан тэмдэг зөрчих;

- тогтоосон журам зөрчиж тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх, зорчих, эсхүл ухарч будаасан;

- тогтоосон журам зөрчиж бусад тээврийн хэрэгслийг чирсэн;

- хөдөлгөөнд саад тохиолдсон болон осол гарсан тохиолдолд гэрэл асаах ба анхааруулах тэмдэг тавих журам зөрчсөн;

- тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны үзлэгт хамрагдаагүй.

2 оноо:

- Нийтийн зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгслээс бусад зорчигч тээвэрлэх машин зорчигчдын зохист тоог 20-оос доош хувиар хэтрүүлсэн;

- Ачааны тээврийн хэрэгслийн даацыг зохистой хэмжээний 30-аас доош хувиар хэтрүүлэн тээвэрлэсэн;

- Явган зорчигчийн гарц дээр хурд сааруулах, тээврийн хэрэгслээ зогсоох журмыг зөрчсөн, явган зорчигчид зам тавьж өгөөгүй;

- Гар утсаар залгах, утсаа гараагаа барьж ярих, сонсох зэргээр хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах үйлдэл хийх;

- 2 дугуйтай мотоцикль жолоодохдоо хамгаалах малгай өмсөөгүй;

- Өндөр хурдны зам болон хотын хурдны зам дээр тээврийн хэрэгсэл жолоодох үедээ жолооч аюулгүйн бүсээ зүүгээгүй.

1 оноо:

- Зохих журмын дагуу гэрэл ашиглаагүй;
- Тээврийн хэрэгслийн ачааны урт, өргөн, өндрийн хэмжээг зөрчих;
- тээврийн үзлэгийн тэмдэг, даатгалын тэмдгийг нааж байршуулаагүй, жолооны үнэмлэх, жолоочийн үнэмлэхийг биедээ авч яваагүй.

Тус зохицуулалт нь зөвхөн шийтгэлийн асуудлыг багтаагаагүй бөгөөд замын хөдөлгөөний хууль тогтоомжийг сахин биелүүлж, зөрчил гаргаагүй жолоочийг урамшуулах талаар тухайлан онцолж, дараахь байдлаар урамшуулна гэж заажээ. Үүнд:

- авто машины жолооч шийтгэлийн онооны 2 дараалсан бүтэн хугацаанд шийтгэлийн оноо аваагүй бол 1 удаа хяналтын үзлэгт орохоос чөлөөлөгдөнө;
- Дараалан 5 удаагийн хугацаанд оноогоор шийтгэгдээгүй бол жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацааг 2 жилээр сунгана;
- Дараалан 10 удаагийн хугацаанд шийтгэл аваагүй бол 20 жилийн хугацаанд үзлэгт орохоос болон үнэмлэх солихоос чөлөөлөгдөнө.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар АНУ-ын зарим муж (Иллинойс, Калифорни), ХВНГУ, ОХУ, БНХАУ, Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн Вант улс, Франц, Украин, Эстони Улс, Израиль, Чех Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох эрх зүйн зохицуулалтаас харахад шинэчлэн боловсруулж буй хуулийн төсөлд тусгавал зохих зохицуулалт нэлээд байна. Иймд тэдгээр улсын эрх зүйн зохицуулалтыг холбогдох мэргэжлийн байгууллага, ажлын хэсгийн гишүүдийн санал, практик нөхцөл байдал, техник эдийн засгийн боломж зэргийг харгалзан, харьцуулан үзэж хуулийн төсөлд тусгах нь зүйтэй. Эл үндэслэлээр дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Санал, зөвлөмж**Зохион байгуулалтыг эрхлэх байгууллага**

ОХУ-ын хувьд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан хотын зөвлөлийн тухай” Москва хотын даргын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 435-РМ тоот тушаалаар замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулах зөвлөл

байгуулагджээ⁴⁶. Тус Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Зам дээр гарч буй осолыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд зориулсан ухуулгын, танин мэдэхүйн шинжтэй арга хэмжээ зохион байгуулах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр гарч буй хууль, эрх зүйн актын шинэчлэл, хэрэгжилтэнд хяналт тавих;
- Зам дээр гарсан осолын талаар нэгдсэн статистик дүн гаргах, зам дээрх зөрчлийг бууруулах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- Авто тээврийн зөрчил, гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи жил бүрийн мэдээг бэлтгэж ОХУ-ын Засгийн газарт бэлтгэх, танилцуулах;
- “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт Москва хотын санг (фонд)-ыг хөгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи нийгмийн идэвхи зүтгэлийг сайжруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам тээвэр, барилга, хот байгууллалтын яам, Замын цагдаагийн газар, Авто тээврийн газар, Нийслэлийн Засаг даргын ажлын алба, авто замын улсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, бусад холбогдох төрийн байгууллага, олон нийтийн төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах нь оновчтой.

Бүртгэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх

Авто машин, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эзэмшигч болон зөрчлийн талаарх бүртгэлийг сайжруулах судалгааны тайланд дурьдсан АНУ-ын Калифорни мужийн жишээг авч хэрэгжүүлэх нөхцөлийг судалж үзэх:

Торгуулийн оноогоор шийтгэх системийг Монгол Улсын хувьд авч хэрэгжүүлэх боломжтой. Онооны системийг хэрэглэх боломжийг төсөлд тусгах асуудлыг шийдэхийн зэрэгцээ замын хөдөлгөөний хууль тогтоомжийг сахин биелүүлж, зөрчил гаргаагүй жолоочийг урамшуулах талаар мөн тухайлсан зохицуулалтыг БНХАУ зэрэг орнуудын жишгийг авч хэрэгжүүлж болно;

⁴⁶ Распоряжение мэра Москвы” О городской комиссии по безопасности дорожного движения” 2005.12.30 № 435-PM http://www.businesspravo.ru/Docum/DocumShow_DocumID_107340.html /сүүлд үзсэн 2011.03.17/

Хариуцлагын төрөлд эдийн засаг, нийгэмд түстэй хэлбэрийг
илүүхүү оруулах

Гадаадын дийлэнх улс орон жолоочид материаллаг хариуцлага оногдуулах бодлогыг баримталдаг. Энэ нь зөвхөн их хэмжээний торгууль бус, мөн тээврийн хэрэгслийг хурааж авах, жолооны үнэмлэх хүчингүй болгох, тээврийн хэрэгслийн зайлшгүй даатгалын хэмжээг ихэсгэх зэрэг арга хэмжээнүүд юм. Тухайлбал, ХБНГУ-д зөрчил гаргасан жолооч тодорхой торгуулийн оноо цуглуулах ба онооны есөлтөөс түүний даатгалд төлөх дүнгийн хэмжээ 1000 евро хүртэлх хэмжээгээр өсч болдог. 3000-4000 евроны дундаж цалинтай германы иргэний хувьд энэ нь өндөр төлбөр бөгөөд зарим жолооч нар зөрчил гаргасны хариуд даатгалын төлбөрөө төлөх хүртэл хугацаанд тээврийн хэрэгсэл жолоодохгүй, явганаар явах гохиолдол гардаг байна. Эндээс авч үзвэл хариуцлага хүлээлгэх шийтгэл, зөрчлийн асуудлыг даатгалын системтэй холбон хэрэгжүүлж болохоор байна. Өөрөөр хэлбэл зөрчил гаргасан хувь хүнд чиглэсэн хариуцлагын механизмыг хэрэглэхийн зэрэгцээ эдийн засгийн хөшүүрэг нийгмийн шинжтэй хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх боломжийг судалж үзэх нь зүйтэй.

Байгаль орчинд болон иргэдийн амгалан тайван, аюулгүй байданд
үзүүлж буй нөлөөл

Украин⁴⁷, Эстони улсын⁴⁸ замын хөдөлгөөний хуульд “Хүрээлэн буй орчны хамгаалалтын хувьд хүлээх үүрэг” хэмээх бүлгийг агуулсан байдаг нь бусад орны зохицуулалтаас онцлог юм. Тус зохицуулалтын дагуу жолооч бусдал болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэх, чанга дуу авиа гаргах, их хэмжээгээр утаа гаргах, амьтан болон шувуу дайрахыг хориглодог. Эстони улсын Замын хөдөлгөөний Дүрмийн 16 дугаар зүйлд зааснаар, жолооч орон сууцны төвлөрөл ихтэй бүсэд 2 минутаас илүү хугацаагаар тээврийн хэрэгсэлээ асаалттай байлгахыг хориглодог байна⁴⁹. Мөн гол, мөрөн, горхи, усны эргээс 10 м ойр зайд тээврийн хэрэгсэлээ угаах, зориулалтын бус газар тос, масло солих, хүрээлэн буй орчныг бохирдуулах зүйл гоожиж байгаа тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно. Тээврийн хэрэгслийн гаргах дуу авианы, цацаж буй утааны хэмжээг Эстони Улсын Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны Сайдын тушаалын 5 дугаар зүйлээр тогтоодог ба тогтоосон хэмжээг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг байна. Ингэснээр жолоочийн зөвхөн гаргасан ослын зөрчилд нь хариуцлага хүлээлгэхээс гадна бүрэн бус, тээврийн

⁴⁷ Правила Дорожного движения Украины http://auto.meta.ua/autolaw/pdd_rus/ /сүүлд үзсэн 2011.03.17/

⁴⁸ Правила Дорожного движения Республики Эстония <http://pdd-ru.info/445.php> /сүүлд үзсэн 2011.03.17/

⁴⁹ Мөн тэнд, 16 дугаар зүйл.

хэрэгсэл ашиглах явцаа хүрээлэн буй орчин болон иргэдийн амар тайван байдалд нөлөөлөх үйлдэл хийсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан нь манай улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэ төсөлд заавал тусгах зүйл юм. Дээр дурдсан зөрчлүүд нь манайд түгээмэл байгаа бөгөөд эл асуудлыг зохицуулснаар олон хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад түлхэц үзүүлэх ач холбогдолтой.

Хариуцлага ногдуулахдаа зөрчлийн шинжийг харгалзах

Аливаа зөрчлийн шинжээс хамааран шийтгэлийг нарийн ялгамжтай ногдуулдаг болох нь ХБНГУ-ын хуулиас харагдаж байна. Энэ жишгийг судлан үзэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд тусгах асуудлыг судлах;

Замын аюулгүй байдлыг хангах холбогдох байгууллагын үүрэг, хариуцлагын асуудал

ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсны дагуу замыг засварлах, шинээр зам тавих; замын эвдрэлийг арилгах нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөл болно⁶⁰. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, ОХУ-ын субъектийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон хариуцдаг замтай хуулийн этгээд⁶¹, иргэний хувьд зам засвар, эвдрэлийг арилгах ажлыг өөрөө хариуцдаг байна. Ингэхдээ улсаас тогтоосон зам засварын журмыг баримтлах буюу мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн зам засвар, барилгын багийг ажилдуулна⁶². Өөрөөр хэлбэл эндээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад "зам" чухал үүрэгтэй болох нь харагдаж байгаа бөгөөд энэ асуудлыг тус хуулиар мөн зохицуулж хариуцсан байгууллагын чиг үүргийг зааж өгчээ. ОХУ-ын хуулийн энэ заалтаас харахад:

1. Замын аюулгүй байдал засварлалтын асуудал нь хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох болохыг тодорхойлон замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсан байна;
2. Замын засварлалтын асуудлыг холбогдох төрийн байгууллага нь хариуцахын зэрэгцээ тодорхой хувь иргэн, хуулийн этгээдэд тодорхой оршин буй газрынх нь замыг хариуцуулж өгдөг байна;
3. Замын засварлалтын асуудлыг тусгай зөвшөөрөлөөр магадлан

⁶⁰ Федеральный Закон о Безопасности дорожного движения 15 ноября 1995 года /с изменениями от 2010.07.27/ Статья 11. 12.

⁶¹ ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай хуулиар "зам"-засварлалт аюулгүй байдлын талаар тухайн төрийн хариуцсан байгууллага хариуцхаас гадна. Тухайлсан газар оршин буй иргэн, хуулийн этгээдэд тодорхой хэсэг замыг хариуцуулдаг бөгөөд уг хариуцсан замынхаа засварлалт аюулгүй байдлыг давхар хариуцдаг байна.

⁶² Мөн тэнд, статья 13.

итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг байна. Энэ жишгийг харгалзан тус төсөлд тухайлсан мэргэжлийн байгууллага хариуцахаар тусгах нь зүйтэй.

Олон нийтэд нөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх нь

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, аливаа зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тодорхой эрхийн акт, хөтөлбөр, төслийн хүрээнд хэрэгжүүлж хэвших чиглэлээр судалгааны тайланд дурдсан ОХУ-ын жишээ баримт бусад орны жишгийг судлаж хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг төсөлд тусгах.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд өөр бусад олон төрлийн хууль тогтоомж боловсруулах

Судалгаанаас харахад дийлэнх гадны орон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хуулиас гадна холбогдох бусад хамааралтай хууль тогтоомжийг давхар үйлчилдэг байна.

Иймд өөр холбогдох хууль, жишээ нь замын хөдөлгөөний дүрмийн зэрчлийн тухай гэх мэт хууль тогтоомжийг боловсруулах хэрэгцээ шаардлага үүсч болохоор байна.

ХАРЬАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙСЭН СУДАЛГАА*

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Оршил

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын иргэд гадаад улс руу цагаачлах, эсвэл өөр улсын харьяат болох тохиолдол олширч байна. “Харьяатын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл хилийн чанадад буй гадаад улсын иргэн болсон “иргэд”-ээ эх орондоо эгүүлэн татах зорилгоор тэдэнд хандсан эерэг бодлогыг баримталж байна. Иймд төсөөтэй зохицуулалт бүхий орнуудыг жишээ болгон судалсан.

Судлагааны ажлын хүрээнд гадаад оронд буй өөрийн улсын иргэн байсан, нэг үндэс, угсаатай хэдий ч өөр улсын харьяат болсон, эсхүл харьяаллаасаа гараагүй боловч өөр орны харьяат болсон буюу давхар харьяалалтай болсон “иргэд”-ээ харьяалалдаа эгүүлэн татах асуудлыг зохицуулж буй жишээг Бүгд Найрамдах Унгар Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казахстан улсуудын жишээн дээр, байнгын оршин суугчийн зохицуулалтын талаар Бүгд Найрамдах Чех Улс, Австрали Улс, Европын Холбооны улсууд болон бусад улсуудын жишээн дээр судаллаа. Мөн ХЗДХЯ-ны захиалгаар ХЗҮХ-ийн ОУЭЗС-ийн 2008 онд хийсэн “Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хийх хавсарга судлагаа”-ны ажлын тайланд буй жишээг олж үзэж болно.

Нэг. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэж буй байдал

Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орны тоонд Швед, Армян, Киркиз, Казахстан, Хятад¹ зэрэг орнууд багтана. Эдгээр орнууд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй боловч улс төрийн болон түүхэн шалтгааны улмаас тус орны иргэний харьяаллаас гарсан үндэс угтаа нэгтэй, хэл, соёлын хувьд нийтлэг гадаад орны

¹ Судалгааг хийж гүйцэтгэсэн ХЗҮХ-ийн ОУЭЗС-ын эрхлэгч Ж.Соёлмаа, эрдэм шинжилгээний ажилтан Ч.Бат-Уянга, удирдсан ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Б.Гүнбилэг.

² Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын 2008 оны “Харьяатын тухай хуулийн шинэчилсэн найруулга” /харьцуулсан судлагаа/-ны материал

³ Пунцагдаш.О /2002/. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ, 13.

иргэдэд хандан, тэдэнд зориулсан хөнгөлөлттэй бодлого явуулдаг нь тэдэнд зориулж иргэний харьяалал олгох процедураа хөнгөвчилдгөөс харагдана. Жишээлбэл, Казакстан Улс нь тэдгээр иргэдэд хандан, иргэншил олгох процедураа хөнгөвчилдэг бөгөөд иргэншил хүсэгч нь өмнөх улсынхаа харьяаллаас гарсан байхыг шаарддаг.²

Судлагааны удирдамжийн дагуу хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэж буй байдлыг "green card"-ын жишээн дээр судлах учир энэ талаар тодруулъя.

Байнгын оршин суугч буюу "permanent residency" гэдэг нь хэн нэгэн хүн тухайн орны иргэн биш боловч тус оронд оршин суух эрхтэй байхыг ойлгоно. Орон бүр ямар нэг хэмжээгээр байнгын оршин суугчийн статустай байдаг. "Нэн тааламжтай" гэж хэлж болох байнгын оршин суугчийн статустай орон бол Европын холбооны гишүүн орнууд байдаг.

Байнгын оршин суугчийн эрх, үүрэг: Ихэнхи оронд байнгын оршин суугчийн эрх, үүрэг ойролцоо байдаг. Байнгын оршин суугчийн хувьд дараах эрхийг хязгаарладаг. Үүнд:

- Сонгуульд оролцох эрх;
- Төрийн удирдах болон зарим төрлийн өндөр албан тушаалд томилогдон ажиллах;
- Төрийн нууцтай холбоотой аливаа ажилд ажиллах (Сингапур Улсын хувьд байнгын оршин суугч эрэгтэй хүний хувьд энэхүү эрхийг олгодог байна);
- Үл хөдлөх хөрөнгө эзэмших буюу газар өмчлөх эрх;
- Тухайн орны иргэний үнэмлэхтэй байх;
- Консул, элчингийн хамгаалалтанд байх;

Байнгын оршин суугчийн эрхээ алдах: Ихэнхи орны хувьд өөрийн орны хуульд заасан үндэслэлээр байнгын оршин суугчийн эрхийг хасдаг. Тухайлбал:

- Хуульд заасан тодорхой хугацаагаар тухайн оронд оршин суугаагүй бол оршин суугчийн эрхээ алдах;
- Улсын нууцад халдахтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд байнгын оршин суугчийн эрхээ алдаж, албадан гаргуулна.

Байнгын оршин суугч тухайн орны харьяат болох: Байнгын оршин суугч нь тухайн байнга оршин сууж буй улсдаа тодорхой хугацаагаар амьдарсны дараа иргэншил авахаар өргөдөл гаргах эрх үүснэ. Тухайн улсын харьяат болохын тулд Унгарт 3, Алжир,

² http://www.multiplecitizenship.com/wscl/ws_KAZAKHSTAN.html (сүүлд үзсэн 2011.02.18)

Их Британид 7, ХБНГУ-д 8, Шведэд 12, Франц, Чадад 15 жилийн хугацаагаар тус тус байнга оршин суусан⁴ байхыг шаардана. АНУ-ын хувьд 5 жилийн турш байнгын оршин суугч байсан бол, эсхүл АНУ-ын иргэнтэй гэрлэж, 3 жил байнгын оршин суугч байснаар иргэншил хүсэх эрх үүснэ⁵.

Байнгын оршин суугч болсноор, байнгын оршин суугч гэдгийг нотлох “байнгын оршин суугчийн үнэмлэх”-тэй болно. Энэ нь:

- АНУ-ын хувьд цээж зураг бүхий ногоон өнгийн карт байх ба үүнээс үүдэн “green card” хэмээх нэршил бий болсон;
- Австрали, Шинэ Зеландад байнгын оршин суугчийн үнэмлэх байдаг.

Байнгын оршин суугчдад таатай нөхцөл олгодог орнууд: Энд Австрали, АНУ болон Европын холбооны улсуудын жишээг дурдъя.

Австрали Улс: Австрали нь цагаачлалыг дэмждэг орнуудын тэргүүн эгнээнд байдаг орон бөгөөд Австралийн байнгын оршин суугчид нь бусад орны байнгын оршин суугчдаас илүү таатай боломжоор хангагддаг. Австрали Улсад байнгын оршин суугч дараах эрхийг эдэлнэ⁶. Үүнд:

- Байнгын оршин суугч нь тус улсад өөрийн хүссэн хугацаагаар амьдарч болно (Визээ тухай бүрт нь сунгуулаад);
- Байнгын оршин суугчдад ажлын цагийн хязгаар тогтоохгүй бөгөөд хүссэн цагаараа ажиллах эрхтэй;
- Байнгын оршин суугч нь их, дээд сургуульд суралцахдаа бусад гадаад улсын оюутнуудтай харьцуулахад илүү хөнгөлттэй төлбөрөөр суралцана;
- Байнгын оршин суугч нь эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжтой бөгөөд эмчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх эрхтэй;
- Байнгын оршин суугч нь Австралид 2 жил амьдарсны дараагаар нийгмийн хамгааллын тэтгэлэг болон тэтгэмжид хамрагдах эрхтэй;
- Байнгын оршин суугч нь өөрийн эх орон болон бусад улсад чөлөөтэй зорчих эрхтэй;
- Байнгын оршин суугчийн үр хүүхэд нь Австрали улсын иргэн болж болно;
- Байнгын оршин суугч нь Шинэ Зеланд Улс руу визгүйгээр зорчиж, ажиллаж, амьдарч болно.

Америкийн Нэгдсэн Улс: АНУ-ын байнгын оршин суугч хэмээх ойлголтыг “ногоон карт”⁷ хэмээх нэршлээр нь илүүтэй мэднэ.

⁴ Пунцагдаш.О /2002/. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал), Уб. 9.

⁵ US Citizenship and immigration <http://www.uscis.gov/portal/site/uscis> (сглд эсэн 2011.02.28)

⁶ Visas, immigration and refugees <http://www.immi.gov.au/migrants/> (сглд эсэн 2011.02.28)

⁷ Green Card (Permanent Residence) <http://www.uscis.gov/portal/site/uscis> (сглд эсэн 2011.02.28)

АНУ-ын байнгын оршин суугчид олгох “байнгын оршин суугчийн үнэмлэх” нь анх ногоон өнгөтэй байснаас үүдэн энэхүү нэршил үүссэн юм. АНУ-ын байнгын оршин суугч нь сонгуульд оролцохоос бусад эрхийг эдэлдэг. Тухайлбал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж буюу нийгмийн бүхий л халамжуудад хамрагддаг байна. Их, дээд сургуульд суралцахад бусад орны иргэдээс илүү хөнгөлттэй нөхцлөөр суралцах боломжтой. Мөн өөр нэгэн давуу хүчин зүйл бол байнгын оршин суугч нь АНУ-ын иргэн болох боломжтой юм.

Европын Холбооны Улсууд: Европын холбоонд хамаарах улсууд тус тусын орны хуулиар зохицуулагдах “байнгын оршин суугч”-ийн статустай хэдий ч Европын Холбооны зүгээс байнгын оршин суугчийн бас нэгэн шинэлэг зохицуулалтыг бий болгосон нь “*Цэнхэр картын систем*”⁵ юм. Энэ нь мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажлын байранд Европын Холбооноос өөр бусад орны иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор Европын Холбоонд багтдаг орнуудын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох хэлбэр юм.” Европын Холбооны улсуудад нарийн мэргэжлээр ихэвчлэн гадаад орны иргэд суралцдаг бөгөөд ингэж суралцсан мэргэжилтнүүдийг эх оронд нь буцаан алдахаас сэргийлж, нөөц, бололцоог нь өөрийн орондоо ашиглах зорилгоор ийм зохицуулалт бий болгосон юм.

Европын Холбооны гишүүн улс болох Чех Улсын тухайд “цэнхэр карт”-ын дагуу тус улсад байнга оршин суухын тулд доод тал нь 3 сараас 2 жил хүртэлх хугацаагаар тус улсад хөдөлмөр эрхлэх гэрээ байгуулах үүрэг хүлээнэ”⁶ Мөн:

- 5 жил байнга оршин сууж, ажилласны дараа тус улсын иргэн болох эрхтэй;
- Түүний гэр бүл нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр тус улсын байнгын оршин суугчийн эрхийг олж авах эрхтэй;
- Хөдөлмөрийн гэрээний дагуу тус этгээдийн сарын цалин нь тус улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1,5 дахин илүү байхаар тус тус зохицуулжээ.

Хоёр. Хоёрдмол харьяалалтай болсон иргэдийнхээ харьяаллын асуудлыг хөнгөвчилсөн журмаар зохицуулан тэдний эрх ашгийг хамгаалж байгаа орны туршлага

Хоёрдмол харьяалалтай буюу өөр улсын харьяалалтай болсон иргэдэд зориулж, тэднийг төрөлх эх орондоо татах бодлогын үүднээс

⁵ About the Blue Card <http://www.cypcg.qld.gov.au/employment/> (сүүлд үзсэн 2011.02.28)

⁶ Blue Card (European Union) [http://en.wikipedia.org/wiki/Blue_Card_\(European_Union\)](http://en.wikipedia.org/wiki/Blue_Card_(European_Union)) (сүүлд үзсэн 2011.02.28)

⁷ Czech Republic: Legislation Introduces New Visa and Residence Permit Requirements, Blue Card for Highly Skilled Workers http://www.martindale.com/immigration-law/article_Fragomen-Del-Rey-Bernsen-Loewy-LLP_1230198.htm (сүүлд үзсэн 2011.02.28)

болон Хүний эрхийн түгээмэл¹¹ тунхаглалын 13-р зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт¹²-ын 12-р зүйлд заасан "Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй" гэсэн заалтыг хангах үүднээс харьяаллаасаа гарсан иргэдийг эх орондоо буцаж очих үед ямар нэг хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалтыг олон орны хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, Армян, Болгар, Хятад, Хорват, Чех, Франц, Герман, Унгар, Орос зэрэг орныг нэрлэж болно.¹³

Бүгд Найрамдах Унгар Улс: Дэлхийн нэгдүгээр дайны дараа Бүгд Найрамдах Унгар Улс болон Өрнийн холбоотон улсууд "Трианоны гэрээ"-г байгуулсан. Энэ гэрээгээр Унгар Улс нь Австри, Чехословак, Румын, Серби, Хорват зэрэг хөрш улсынхаа шинэ хил хязгаарыг зөвшөөрч, үүний улмаас газар нутгийнхаа гуравны хоёрыг алдаж, 20.9 сая иргэдтэй байснаас 7.6 сая иргэдтэй болсон.¹⁴ 2010 оны 7 дугаар сарын байдлаар Бүгд Найрамдах Унгар Улс нь 9 сая 976 мянган хүн амтай ¹⁵ болсон бөгөөд одоогийн байдлаар хил залгаа Румын, Серби, Словак, Украин зэрэг улсад нийт 2.5 сая мажар үндэстэн амьдардаг.¹⁶

2010 оны 5 дугаар сард Унгар Улс харьяатын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж, мажар үндэстнээ татах бодлогыг хуульдаа тусгасан.¹⁷ Унгар Улс нь хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ тохиолдол нь өөр орны харьяат болох мажар үндэстэндээ зориулж Унгар улсын иргэн болох хөшүүрэг болгон тэдэнд зориулсан зэрэг, таатай зохицуулалтыг хуульдаа оруулжээ. Гадаадын иргэд Унгар улсын иргэн болохын тулд тодорхой шаардлагуудыг хангах ёстой байдаг. Тухайлбал, Үндсэн хууль болон унгар хэлний тодорхой мэдлэгийг эзэмшсэн байх, Унгар улсад тодорхой хугацаанд оршин суусан байх, өөрийн улсын харьяалал нь Унгар улсын эрх ашигтай зөрчилдөхгүй байх, эрүүгийн хэрэгт холбогдоогүй байх зэрэг багтана. Харин энэ хуулиар мажар үндэстэн нь Унгарын иргэн болоход ердөө хоёрхон шаардлага хангахаар заасан. Энэ нь мажар үндэстэн байх, мөн унгар хэлээр ярьдаг байх гэсэн шаардлага юм. Гэхдээ одоогоор эдгээр Унгар улсын иргэн бологсод сонгуулийн эрх олгоогүй байна.

¹¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1946)

¹² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)

¹³ Right of return, http://en.wikipedia.org/wiki/Right_of_return# (сүүлд үзсэн 2011.02.18)

¹⁴ Treaty of Trianon/1920/, http://en.wikipedia.org/wiki/Treaty_of_Trianon#Distribution_of_the_Hungarian_population_in_the_Kingdom_of_Hungary (сүүлд үзсэн 2011.02.18)

¹⁵ <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/geos/hu.html> (сүүлд үзсэн 2011.02.18)

¹⁶ Michael A. Weinstein, (2001) "Hungary's Referendum on Dual Citizenship: A Small Victory for Europeanism" http://www.threemonkeysonline.com/als/hungarian_citizenship_referendum_ethnic_hungarians_dual_citizenship.html (сүүлд үзсэн 2011.02.18)

¹⁷ Changes in the Hungarian Citizenship Law and adopted on 26 May 2010 <http://eudo-citizenship.eu/docs/CountryReports/recentChanges/Hungary.pdf> (сүүлд үзсэн 2011.02.18)

Үүнтэй адил өөрийн орны иргэн биш боловч нэг үндэстэн болох хүмүүсийг бусад орны иргэдээс илүү хөнгөлөлттэй, хялбаршуулсан журмаар өөрийн улсын иргэнээр бүртгэдэг орны тоонд ХБНГУ, Армян Улс орно. Армяны хувьд Унгараас ялгаатай нь иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй юм. Мөн Беларус Улс нь Беларус үндэстэн болон түүний үр удмыг Беларус улсад байнгын оршин суугчаар амьдрахад давуу эрх олгодог. Болгарын хувьд ч мөн адил нэг үндэстнээ иргэнээр бүртгэхдээ тус улсад иргэншил олгодог журмаа хөнгөвчилж өгдөг байна. Энэтхэгийн хувьд хинди үндэстнээ хөнгөлөлттэй журмаар бүртгэдэг.

Ийнхүү хэл, үндэстэн гэсэн хоёр шалгуураар иргэний эрхийн зарим хэсгийг давуу эдлүүлдэг байна. Нэгэнт хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн учир хоёрдмол харьяалалтай иргэн гэдэг нь тухайн улсын иргэний эрхийг эдлэх нь ойлгомжтой тул тэдэнд үзүүлэх тусгайлан хөнгөлөлтийн талаар нарийвчлан судлах шаардлагагүй гэж үзлээ.

Оросын Холбооны Улс: ОХУ-ын хувьд харьяатын асуудлыг зохицуулж буй хэд хэдэн эрх зүйн актууд байдаг бөгөөд хоёрдмол харьяаллыг хуулиараа хүлээн зөвшөөрдөг улс юм. Гэвч ОХУ-ын эрх зүйн зохицуулалтын талаар энэ бүлэгт тухайлан тусгах болсон нь тус улс хилийн чанадад буй иргэдээ ниглэсэн бодлогыг цогцоор явуулдагтай холбоотой. ОХУ-ын Үндсэн хуулийн 52 дугаар зүйл заалт, ОХУ-ын Харьатын тухай Холбооны хуулийн 6 дугаар зүйлд^{1*} хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг байна. Тухайлбал:

“ОХУ-ын иргэн өөр улсын иргэний харьяаллыг олж авах нь түүнийг ОХУ-ын харьяаллаас гаргах үндэслэл болохгүй” хэмээн тусгажээ.

ОХУ-ын хувьд иргэний харьяаллын асуудлыг дараах эрх зүйн актаар зохицуулдаг байна. Үүнд:

- ОХУ-ын Харьатын тухай Холбооны хууль (2002.04.19)^{1*};
- ОХУ-ын Харьатын тухай Холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Холбооны хууль (2003.11.03)^{2*};
- Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хууль (1999.05.24)^{2*};
- Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай ОХУ-ын Холбооны хууль (2002.06.10)^{2*};
- 2015 он хүртэлх хугацааны ОХУ-ын хүн ам зүйн хөгжлийн үзэл баримтлал (2001.09.01);
- ОХУ дахь шилжилт, хөдөлгөөний талаархи төрийн бодлогын тухай үзэл баримтлал (1999);

^{1*} Федеральный закон “О гражданстве Российской Федерации” № 62-ФЗ 2002.03.31.

^{2*} Мөн тэнд.

^{3*} Федеральный закон “О внесении изменений и дополнений в Федеральный закон “О гражданстве Российской Федерации” № 369592-3 2003.11.03.

^{4*} Федеральный закон “О государственной политике Российской Федерации в отношении соотечественников за рубежом” № 99-ФЗ 1999.05.24.

^{5*} Федеральный закон “О правовом положении иностранных граждан в РФ” № 115-ФЗ 2002.06.25.

• ОХУ дахь шилжилт, хөдөлгөөний явцын талаархи төрийн бодлогын тухай үзэл баримтлал (2002).

Монгол Улсын хувьд иргэний харьяалал, хүн ам зүйн бодлогын талаархи зохицуулалт бүхий Монгол Улсын эрх зүйн актуудыг түүвэрлэж үзэхэд иргэний харьяалал, харьяалалгүй иргэний эрх зүйн байдал, түүний эрх, үүрэг, статусын талаар зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг хэдий ч шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн бодлогыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт дутмаг байна²³.

Шилжилт, хөдөлгөөний хурдацтай хөгжлийн өнөөгийн нийгэмд дэлхийн ихэнхи улс орон давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх бодлогыг баримталж байгаа хэдий ч хуулиараа давхар харьяаллыг хүлээн зөвшөөрч буй тохиолдлууд олон байна. ОХУ-ын хувьд хуулиараа хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч шилжилт, хөдөлгөөний хяналтын бодлогыг улсын түвшинд баримталдаг байна. ОХУ-ын хувьд ЗХУ задарч тухайн үеийн ЗХУ-ын гишүүн орнуудын иргэд нэг харьяаллаасаа салан бутарч өөр өөр улсын иргэд болцгоосон. Энэ замаар харьяалал нь тодорхойгүй, харьяалалгүй, давхар харьяалалтай олон тооны иргэд бий болсон. Сүүлийн жилүүдэд энэхүү асуудлыг шийдвэрлэж, хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлж чадсан гэж үзэж болно. Судлагааны ажлын асуудлын хүрээнд Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуулийг судалж үзэх нь ач холбогдолтой хэмээн үзлээ. Хилийн чанадад амьдарч буй "эх орон нэгтнүүд"²⁴-ээ өөрийн улс руу эгүүлэн татах, тэдгээр иргэдийг уугуул соёл, уламжлалаа өвлөн хадгалах, хөгжүүлэх төрийн бодлогыг ОХУ-д баримталдаг байна. Мөн "Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар улсаас баримтлах бодлогын үндсэн чиглэлийн тухай"²⁵ 1994.08.11-ний өдрийн 1681 тоот ОХУ-ын Ерөнхийлөгчийн тушаалыг баталснаар хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар төрөөс баримтлах бодлогын тухай хуулийн төсөл бэлтгэх, хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хороо байгуулахаар болжээ.

Тус хуульд "хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй харицах харицлаа нь ОХУ-ын төрийн гадаад болон дотоод гол бодлогуудын нэг юм" хэмээн тусгажээ.²⁶ "Эх орон нэгтнүүд" хэмээх ойлголтыг задлан авч үзэхэд энэ нь дараах ойлголтуудыг багтаажээ.²⁷ Үүнд:

• "Эх орон нэгтэн" гэж нэг улсад төрсөн, тэрхүү улсад амьдардаг

²³ Судлагааны ажлын хавсралт 1-ээс харна уу.

²⁴ "Федеральный Закон о государственной политике РФ в отношении соотечественников за рубежом" <http://www.antropotok.archipelag.ru/grd/grd.htm> (сүүлд үзсэн 2011.02.18)

²⁵ Указ Президента РФ "Об основных направлениях государственной политики Российской Федерации в отношении соотечественников, проживающих за рубежом" 1994.08.11 № 1681

²⁶ Мөн тэнд.

²⁷ Мөн тэнд.

эсхүл амьдардаг байсан, нэгдмэл хэл, шашин шүтлэг, соёлын өв, зан уламжлалтай хүмүүс болон тэдгээрийн үр удмыг хэлнэ;

• “Хилийн чанадад буй эх орон нэгтнүүд” гэж гадаад улсад урт хугацаагаар, байнгын оршин суудаг ОХУ-ын иргэд; ЗХУ болон ЗХУ-д багтаж байсан орны иргэд, харьяалалгүй иргэн; ОХУ-аас (ЗХУ-аас) цагаачилж өөр улсын иргэн болсон иргэд болон тэдгээрийн үр удмыг хэлнэ.

Энэхүү зохицуулалтын хүрээнд “эх орон нэгтэн” гэх ойлголтыг тайлбарлахаас гадна тус этгээдүүдэд төрөөс хандах хандлага, үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг буюу тэдгээртэй холбоотой харилцаанд төрийн байгууллагуудын үүрэг, оролцооны талаар тус тус дурьджээ. Дараах төрлийн дэмжлэгийг тусгасан байна. Үүнд:

• **Хүний үлдсэн эрх, эрх чөлөөний салбарт эх орон нэгтнүүдэд дэмжих** -

Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчилдсөн тохиолдолд ОХУ-ын Засгийн газраас дэмжлэг үзүүлэх, алагчилах, ялгаварлан гадуурхах буюу бусад хэлбэрээр тус эрхийн зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байх, таслан зогсоох, хамгаалах зэрэг;

• **Эдийн засаг, нийгмийн салбарт дэмжлэг үзүүлэх** - ОХУ-ын Засгийн газар, төрийн байгууллагууд нь ОХУ-ын аж ахуй эрхлэгчид, хуулийн этгээд нь эх орон нэгтний аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, түншлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтарсан үйлдвэр, хоршоолол, нийгэмлэг байгуулахад түлхэц өгөх, эх орон нэгтнүүдийг Оросын эдийн засагт хөрөнгө оруулахыг урамшуулах, олон тооны эх орон нэгтнүүд ажилладаг гадаадын хуулийн этгээдтэй Оросын хуулийн этгээд ажиллахад давуу эрхтэй¹⁷ хүлээн зөвшөөрөх зэрэг бодлогыг баримталдаг; Нийгмийн салбарт хамгаалалт байхгүй эх орон нэгтнүүдэд нийгмийн хамгаалалт үзүүлэх, ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу онцгой байдалд орсон эх орон нэгтнүүдэд тусалцаа үзүүлэх зэрэг.

• **Соёл, хэл болон боловсролын салбарт эх орон нэгтнүүдэд дэмжих** -

ОХУ-ын Засгийн газар, төрийн байгууллагууд эх орон нэгтнүүдийн өвөрмөц соёлын нэгэн хэсэг болох соёлын өв болон хэлийг хамгаалах, хөгжүүлэх, боловсролын бүх шатанд эзэмших боломжоор хангах бодлого баримталж, энэ зорилгын хүрээнд тодорхой бодлогыг хэрэгжүүлдэг байна;

Эх орон нэгтнүүдийн хэл, соёлын төв, боловсролын түвшингээ дээшлүүлэхэд шаардлагатай гэж үзвэл гадаад улсад байрлаж буй оросын эрдэм шинжилгээ, судлагааны төвүүд, эрдмийн байгууллагад хандах эрхийг нээлттэй олгосон;

Гадаад улсад байгаа эх орон нэгтнүүдийн санаачилгаар байгуулагдсан архив, музей, номын сан зэрэг соёлын, эрдмийн,

¹⁷ Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт бүхий хуулиудад “давуу эрхтэй хүлээн зөвшөөрөх” талаархи зохицуулалтыг агуулаагүй байна.

судлагааны байгууллагад ОХУ-ын Засгийн газраас фонд (сан) бүрдүүлэх, шаардлагатай баримт, бичиг олох зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

ОХУ нь эх орон нэгтнүүдийг орос хэл эзэмших, оросын түүх, соёлын талаар судлахад дэмжлэг үзүүлж, энэ зорилгын хүрээнд гадаад улсад багшилж буй багш нарын бэлтгэлийг хангах, эх хэлийг гадаад улсад сургах сурах бичгийг бэлтгэх хөтөлбөр зохион байгуулдаг. Зарим тохиолдолд гадаад улсад буй боловсролын байгууллагатай энэ салбарт хамтран ажилладаг.

• Мэдээллийн салбарт эх орон нэгтнүүдэд дэмжих –

ОХУ-ын Засгийн газар нь тус улсын талаар, улсын өв, соёл, урлагийн талаар гадаад улсад буй эх орон нэгтнүүдэд мэдээлэл хүргэх үүднээс гадаад улсын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, орос хэлээр нэвтрүүлдэг телевизийн суваг нээж, ажиллуулах, гадаад улсад худалдаалагдах орос хэл дээрхи сонин, сэтгүүл хэвлэн гаргах зэрэг ажлуудыг хийж байна. Энэ ажлын хүрээнд ОХУ-ын төрийн бодлогыг сурталчлах, эх орон нэгтнүүдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, соёл, урлагийн сурталчилгааны ажил тус тус зохион байгуулдаг. Мөн гадаад улсад буй эх орон нэгтнүүдийн санаачилгаар байгуулагдсан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шаардлагатай мэдээ, мэдээллийг өгөх ажлыг ОХУ-ын Засгийн газраас дэмждэг байна.

Дээрх зохицуулалтаас харахад ЗХУ-ыг задарсан шалтгаанаас үүдэн өөр өөр улсын харьяалалтай бодсон олон тооны иргэдэд дэмжих, хамгаалах бодлого баримтлахын зэрэгцээ өөрийн орны өв соёл, хэл, уламжлалаа хамгаалж байгаа юм. Дээр хэлсэнчлэн ОХУ нь давхар харьяаллыг хуулиараа хүлээн зөвшөөрдөг хэдий ч улсын хүн амын нягтрал, хөгжлийн бодлогыг баримталдаг. Тухайлбал, шилжилт, хөдөлгөөн, түүний үйл явцын талаархи төрийн үзэл баримтлал, 2015 он хүртэлх ОХУ-ын хүн ам зүйн хөгжлийн үзэл баримтлал зэргийг дурдаж болно.

Дээрх хууль 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эх орон нэгтнүүдийн бүрэн дэмжлэгийг хүлээжээ²⁹. Өөрчлөлтийн үр дүнд «гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд» гэсэн томъёололыг тодруулж, «гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд» гэсэн ойлголтонд соёлын болон оюун ухааны ашиг тусын төлөө түүхэн эх оронтойгоо холбоо тогтоох сонголт хийсэн гадаадад байнга амьдардаг Оросуудыг нэрлэнэ³⁰ хэмээн тусгасан байна.

ОХУ-д Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хороо үйл ажиллагаа эрхэлдэг. 2011 оны

²⁹ "Эх орон нэгтнүүдийн тухай хуулинд оруулсан өөрчлөлтийг Европд амьдардаг оросууд дэмжлээ" нийтлэл <http://mongolian.ru/rf/2010/04/05/9342977.html> (сүүлд үзсэн 2011.03.24)

³⁰ Федеральный закон «О внесении изменений в Федеральный закон «О государственной политике Российской Федерации в отношении соотечественников за рубежом» 2010.07.09

3 дугаар сарын байдлаар тус хороо нь 11 хүний бүрэлдэхүүн бүхий ажлын албатай бөгөөд хороог ОХУ-ын Гадаад хэргийн яамны сайд тэргүүлдэг байна. Тус хороо нь хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй хөлбоотой ОХУ-ын төрийн байгууллагуудын харилцааг зохицуулах, эх орон нэгтнүүдийн талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газарт эх орон нэгтнүүдийн талаар төрийн бодлогын хэрэгжилтийн талаархи мэдээлэх, санал өргөн барих, эх орон нэгтнүүдэд хуулиар олгосон эрхийн хэрэгжилтийг хангах зэрэг үүрэг хүлээсэн байгууллага юм.⁴¹ Тус байгууллагын хувьд хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 жилээр боловсруулж, ОХУ-ын Засгийн газраар батлуулдаг байна. Манай улсын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Хилийн чанадад буй Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах зөвлөл үйл ажиллагаагаа⁴² явуулдаг бөгөөд ОХУ-аас ялгаатай нь тус ажлын алба нь гадаад улсад буй Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулдаг юм. Энэ тохиолдолд тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны эрх үүргээ тэлж, хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй хамтран ажиллах ажлыг мөн зохион байгуулах хэрэгтэй хэмээн үзэж байна.

Гурав. Хоёрдмол харьяаллыг хуулиар шууд хүлээн зөвшөөрдөггүй боловч нэгэнт үүссэн нөхцөлд тэдгээр иргэдээ эх орондоо буцааж татах бодлого явуулж байгаа орнуудын эрх зүйн зохицуулалтын талаар

Бүгд Найрамдах Казахстан Улс: Бүгд Найрамдах Казахстан Улс нь 1991 онд тусгаар тогтносны дараагаар тус улсын Засгийн газраас бусад оронд буй казак үндэстнээ "түүхэн эх орон"-доо эргэн ирэхийг урьж, тусгай хөтөлбөр боловсруулсан. Шинжээчдийн дүгнэснээр дэлхийд 2 сая казак үндэстэн байгаа бөгөөд тэдгээр нь голчлон Хятад, Орос, Монгол, Узбекистан улсуудад байдаг.⁴³ Казахстан Улс нь иргэний давхар харьяаллыг зөвшөөрдөггүй бөгөөд Казахстан Улсын Харьяаллын тухай хуулийн 3-р зүйлд⁴⁴ зааснаар "хэлмэгдүүлэлт болон тухайн үеийн улс төрийн бусад шалтгаанаар Казахстан Улсаас хүчээр гаргасан, одоо өөр улсын иргэн болсон казак үндэстнээ Казахстан улсад эргэн ирэхийг хүлээн зөвшөөрнө" хэмээн тусгажээ. Эргэн ирж буй тус казак үндэстэнд хөнгөлөлттэй нөхцлөөр харьяалал олгодог.

⁴¹ Правительственная комиссия по делам соотечественников за рубежом http://www.mid.ru/bul_news/nta/antafav/03_5.03 (сүүлд үзсэн 2011.03.24)

⁴² www.cooperation.gov.mn (сүүлд үзсэн 2011.03.24)

⁴³ "Astana calling" <http://portal.mfa.kz/portal/page/portal/mfa/resources/Pictures/Astana%20Calling%2009-10-06-ASTANA%20CALLING%20031109.pdf> (сүүлд үзсэн 2011.03.24)

⁴⁴ Law on citizenship <http://www.legislationline.org/documents/action/popup/id/4993> (сүүлд үзсэн 2011.03.24)

Тухайлбал, тус хуулийн дагуу гадаадын иргэн Казакстаны харьяалал хүссэн бол тус улсад 5-аас дээш жил байнга оршин суусан байхыг шаарддаг бол эргэн ирж буй казак үндэстэнд энэхүү шаардлагыг тавьдаггүй байна. Мөн ийнхүү эргэн ирсэн казак үндэстэнд жил бүр тэтгэмж олгохоор улсын төсөвт тодорхой хэмжээний мөнгөн дүн төсөвлөдөг байна. 2009 оны байдлаар 1991 оноос хойш Казакстанд Хятадаас нийт 21133, Монголоос 39359, Узбекистанаас 177822 казак үндэстэн тус тус эргэн ирсэн байна. Мөн эдгээр казак үндэстэнд зориулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Казакстаны баруун өмнө зүгт байрлах Актау хотод тусгай төв барьж байна.¹⁵

Монгол Улсаас Казакстан Улсад шилжин суурьшиж буй дийлэнх хүмүүс хялбаршуулсан журмаар Казакстан Улсын харьяат болдог нь Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүсэх суурийг бүрдүүлж байна¹⁶. “Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүсийг иргэний харьяаллын асуудлыг зохицуулах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсын хоорондын Гэрээ”¹⁷-ний 4 дүгээр зүйлийн дагуу “Хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүс Монгол Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Казакстан Улсын харьяат болох талаар талар бичгээр гаргасан хүсэлтийг Монгол Улсын эрх бүхий байгууллага ёсоор болгосон тухайгаа Казакстан Улсын холбогдох байгууллагад мэдэгдсэн өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Казакстан Улс тэдгээр иргэнийг өөрийн харьяат болгоно” хэмээн зохицуулжээ. Ер нь Монгол Улс, Казакстан Улсын хооронд харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар 40 орчим гэрээ, хэлэлцээр байгуулсан байдаг¹⁸. Үүсээд буй хоёрдмол харьяаллын асуудал нь Монгол Улсын хуульд нийцэхгүй тул энэ асуудлыг зохицуулах үүднээс Казакстан Улсын иргэн болсон хоёрдмол харьяалал бүхий 30 000 иргэдийг өөрсдөө Монгол Улсын харьяатаас сайн дураар татгалзаж буй өргөдлөө Казакстан Улсад гаргасан тул Монгол Улсын харьяаллаас хасах хэрэгтэй хэмээн үзэж байна¹⁹. Мөн тус шилжин суурьшсан иргэдийн нэрсний жагсаалтыг Хил хамгаалах ерөнхий газрын шугамаар Монгол Улс, БНХАУ-ын хилийн шалтан нэвтрүүлэх боомтуудад хүргүүлж, эзэмшиж буй гадаад паспортыг хураан авч.

¹⁵ “Astana calling” [http://portal.mfa.kz/portal/page/portal/mfa/resources/Pictures/Astana%20Calling%20\(PDF\)/2009-10-06/ASTANA%20CALLING%20031109.pdf](http://portal.mfa.kz/portal/page/portal/mfa/resources/Pictures/Astana%20Calling%20(PDF)/2009-10-06/ASTANA%20CALLING%20031109.pdf) (сүүлд үзсэн 2011.03.24)

¹⁶ Пунцагдаш.О (2005-4). Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүссэн шалтгаан, түүнийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулан шийдвэрлэх асуудалд // Хууль дээдлэх ес, 77

¹⁷ “Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүсийг иргэний харьяаллын асуудлыг зохицуулах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсын хоорондын Гэрээ” 1994 он.

¹⁸ Пунцагдаш.О (2005-4). Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүссэн шалтгаан, түүнийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулан шийдвэрлэх асуудалд // Хууль дээдлэх ес, 77

¹⁹ Мөн тэнд, 78.

хүчингүй болгосноор хоёрдмол харьяаллыг таслан зогсоож чадна хэмээн судлаач О.Пунцагдаш өөрийн нийтлэлдээ¹⁰ бичжээ.

Дөрөв. Олон улсын гэрээ, конвенц дахь зохицуулалт

Иргэний харьяаллын асуудал онолын хувьд олон улсын эрх зүйд, практикийн хувьд үндэсний эрх зүйн чухал асуудал юм. Хүн бүр харьяалалтай байх баталгаагаар хангагдах эрхийг 1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар¹¹ тогтоосон. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 24.2-т: "Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй"¹², Хүүхдийн эрхийн тухай тунхаглалын 8.1-д "Оролцогч улсууд хуульд заасан иргэний харьяалалтай байх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах зэргээр хувийн онцлог байдлаа хадгалах, хүүхдийн эрхийг хүндэтгэх, үүнд хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ"¹³ хэмээн иргэний харьяаллын талаар тус тус зохицуулжээ.

Дэлхийн I дайны дараа үед харьяалалгүй, хоёрдмол харьяалалтай хүний тоо огцом өсөж энэ үеэс эхлэн хоёрдмол харьяаллын асуудлыг дэлхий дахинаа зохицуулж ирэн байна¹⁴. Олон улсын түвшинд анх 1930 онд Гаг хотноо болсон олон улсын бага хурлын үр дүнд "Харьяатын тухай хуулийн зөрчилдөөнийг арилгах тухай Конвенц"¹⁵-ийг баталжээ.

Дэлхийн II дайны дараа НҮБ-ын Олон улсын эрх зүйн комисс энэ асуудлыг анхааралдаа авч давхар харьяаллыг багасгах хандлагыг баримтлан 1963 онд "Олон харьяаллыг багасгах ба олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай Конвенц"¹⁶-ийг баталсан байна. Энэ замаар олон улсын түвшинд иргэний харьяалал, хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулсан олон тооны олон улсын гэрээ, хэлэлцээрийг баталсан байдаг. Тухайлбал, "Иргэний харьяаллын тухай Европын

¹⁰ Мөн тэнд.78.

¹¹ Төрийн мэдээлэл (Тусгай дугаар-1) "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946.12.10 батлагдсан. 15 дугаар зүйл.

¹² Төрийн мэдээлэл (Тусгай дугаар-1) "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт" 2200A(XXI) тоот тогтоолоор 1973.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 24 дүгээр зүйл.

¹³ Төрийн мэдээлэл (Тусгай дугаар-1) "Хүүхдийн эрхийн тухай Конвенц" 1990.09.02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 8 дугаар зүйл.

¹⁴ Уильям Старлинг Берджесс "Натурализация" <http://monah.tk/?p=845> (сүүлд үзсэн 2011.03.29)

¹⁵ "Конвенция регулирующая некоторые вопросы, связанные с коллизией законов о гражданстве" 12 апреля 1930 года <http://www.memo.ru/prawo/citiz/300412.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

¹⁶ "Конвенция о сокращении случаев многогражданства и о воинской повинности в случаях многогражданства" 6 мая 1963 года. <http://dallatjan.narod.ru/grazh/nbgrazh.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

Конвенц¹⁷”, “Харьяаллыг багасгах тухай Нью-Йоркын Конвенц¹⁸”, “Нөхөрт гарсан эмэгтэйн харьяаллын тухай Конвенц¹⁹”, “Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай Конвенц²⁰” зэрэг орно.)

Монгол Улсын хувьд дээрх конвенциудад нэгдэн орлоогүй бөгөөд иргэний харьяаллын асуудлын зохицуултыг агуулсан Монгол Улсын олон улсын гэрээг түүвэрлэж үүнд хавсаргав²¹. Хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэх аргын нэг бол тухайн хоёр улсын хооронд хоёрдмол харьяаллын асуудлаар гэрээ байгуулах явдал юм. Хоёрдмол харьяаллын асуудлаархи гэрээг хоёр үндсэн зорилгоор хийдэг байна²². Энэ нь нэгдүгээрт, давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх, таслан зогсоох, хоёрдугаарт, давхар харьяаллыг харилцан зөвшөөрч, үүсэх асуудлуудыг зохицуулах гэсэн хоёр төрлийн зорилготой байдаг. Тухайлбал, улс орнууд хоёрдмол харьяаллаас урьдчилан сэргийлэх бөгөөд устгах тухай хоёр талын хэлэлцээрийг хийдэг байна. Үүнд, АНУ нь Норвеги (1930 он), Швед (1933 он), Швейцар (1937 он), Финлянд (1939 он) зэрэг улстай, Франц нь 1938 онд Швейцар, 1959 онд Израил, 1970 онд Испани, 1963 онд Финлянд Улстай тус тус хийсэн хэлэлцээр зэргээр жишээ татаж болно.

Манай улс хоёрдмол харьяаллын асуудлыг олон улсын түвшинд хоёр талт гэрээгээр зохицуулдаг байна. Монгол Улс 1990 оноос өмнө тухайн үеийн нэршлээр Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Социалист Болгар Улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак Улс, Бүгд Найрамдах Социалист Югослав Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс, Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг тус тус байгуулсан. Харин 1990 оноос хойш Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Украин Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсуудтай иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцах гэрээ байгуулжээ.²³ Тус гэрээгээр иргэний

¹⁷ “Европейская конвенция о гражданстве” 6 ноября 1997 года <http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

¹⁸ Нью-Йоркская конвенция о сокращении безгражданства 30 августа 1960 года. <http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

¹⁹ Конвенция о гражданстве замужней женщины 20 февраля 1957 года. <http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

²⁰ Конвенция о статусе апатридов 28 сентября 1958 года <http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm> (сүүлд үзсэн 2011.03.29)

²¹ Хавсралт 2-ыг харна уу.

²² ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын 2008 оны судлагааны ажлын тайлангаас харна уу.

²³ Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв, (2003). “Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ (эмхэтгэл), УБ.

харьяаллын асуудлыг хэсэгчлэн зохицуулсан байдаг. Тухайлбал, Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний 2 дугаар зүйлд “Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт ба түүнийг цуцлах, хүчингүйд тооцохтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ” хэмээн зохицуулсан байна. Ер нь Монгол Улсын хувьд харьяаллын асуудлыг зохицуулсан олон улсын олон талт гэрээнд нэгдэн ороогүй, харьяаллын асуудлыг хөндсөн хоёр талт гэрээг цөөн тооны улстай байгуулсан зэрэг нь хоёрдмол харьяалалтай иргэд олшрох, эдгээр иргэдийн эрх зүйн байдлыг цогцлон шийдвэрлэж чадахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүргэнэ.

Монгол Улсын хувьд хоёрдмол харьяалдыг хүлээн зөвшөөрсөн улсад иргэний харьяалал олж авсан Монгол улсын иргэд байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь Монгол улсын мэдээллийн сан бүрхэг, нөгөө талаас хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрч байгаа орнууд бусад улсын иргэдэд хоёрдмол харьяаллыг өгөхдөө нөгөө улсын харьяаллаас гарсан байхыг шаарддаггүй байж болно. Үүнийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар нарийвчлан судлах шаардлагатай.

Тав. Гадаад улсад буй иргэдэд үзүүлж болох хөнгөлөлтүүдийн талаар, тус хөнгөлөлтийг хуудийн хүрээнд хэрхэн эдлүүлж болох талаархи санал

Харьяалал нь хувь этгээдийн эрх зүйн байдлын анхдагч ба үндсэн элемент юм. Өөрөөр хэлбэл харьяалал нь тодорхой этгээдийн эрх, эрх чөлөөг ханган хамгаалахын зэрэгцээ тодорхой үүргийг хүлээлгэдэг. Иргэний харьяалал нь төр ба иргэн хүн хоёрыг холбож буй улс төр, эрх зүйн тогтвортой холбоос юм.

Гадаад улсад буй иргэдэд үзүүлж болох хөнгөлөлтийн талаар судлахаас өмнө “хөнгөлөлт”, “дэмжлэг”, “туслалцаа” гэсэн нэр томъёоны талаар дурьдъя. “Дэмжлэг” гэдэг нь тодорхой субьектэд хамааралтай зүйлийг (хөрөнгө, мөнгөн дүн, үүрэг зэрэг) хөгжүүлэх, сайжруулах үйлдлийг хэлнэ.¹⁴ “Хөнгөлөлт” гэдэг нь тодорхой субьектэд хамааралтай зүйлийг (хөрөнгө, мөнгөн дүн, үүрэг зэрэг) хөнгөлөх, хялбаршуулах үйлдлийг хэлнэ.¹⁵ Харин “туслалцаа” хэмээх нэр томъёоны хувьд тодорхой субьектэд ямарваа нэгэн үйлдэл хийхэд түлхэц өгөх, дэмжихийг хэлнэ.¹⁶ Өмнөх бүлэгт дурдагдаж буй Хилийн

¹⁴ <http://dictionary.cambridge.org/dictionary/british/> (сүүлд үзсэн 2011.03.30)

¹⁵ Мөн тэнд

¹⁶ Мөн тэнд

чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуульд ОХУ-ын Засгийн газраас хилийн чанадад буй гадаад улсын иргэд болох эх орон нэгтнүүдийн хувьд *"дэмжлэг үзүүлэх"* гэсэн нэр томъёог өргөнөөр хэрэглэжээ.

ОХУ-ын хуулийн хувьд *"дэмжих"* гэдгийг гадаад улсад буй эх орон нэгтнүүдэд Оросын соёл, уламжлал, хэл, ёс заншлыг авч үлдэхэд нь туслалцаа үзүүлэх, ОХУ-д бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хөнгөлөлттэй нөхцлөөр бүртгэх зэрэг ойлголтыг багтаажээ.

Монгол Улсын хувьд *"жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих"*⁵⁷, *"хөдөлмөр эрхлэлтийг дэмжих"*⁵⁸ гэсэн ойлголтуудыг зохицуулсан боловч *"хүний үндсэн эрх, эрх чөлөө, нийгэм, эдийн засаг, соёл, хэл, боловсролын салбарт эх орон нэгтнүүдээ дэмжих"* гэсэн ойлголтыг хуульчлаагүй байна

Судлагааны ажлын хүрээнд Монгол Улсын харьяаллаас гарсан тохиолдолд хуульд заасан Монгол Улсын иргэний эдлэх эрхээс ямар эрх нь хязгаарлагдах талаар судалсан. Тухайлбал:

- *Монгол Улсад гарах-орохдоо виз авах, баримт бичиг бүрдүүлж, бүртгүүлэх* - Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1-р зүйлд зааснаар Монгол Улсад байнгын оршин суугч, цагаач, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах-орох визийг 120 хүртэл хоногтой тодорхой баримт бичиг бүрдүүлж, бүртгүүлсний үр дүнд олгодог. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2003.03.12-ны өдрийн 62 тоот "Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам"-нд заасан шалгуурыг хангасан тохиолдолд Монгол Улсын иргэн болох асуудал нь шийдвэрлэгдэнэ;

- *Газар өмчлөх, ашиглах эрх хязгаарлах* - Монгол Улсын Газрын тухай хуулийн 5.2-р зүйлд зааснаар "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын түсгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно", мөн хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсад байнга (183 хоногоос дээш хугацаагаар) оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ хэмээн заажээ. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.2-р зүйлд заасны дагуу Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрхгүй;

- *Галт зэвсэг өмчлөх эрхгүй* - Монгол Улсын Галт зэвсэг өмчлөх тухай хуулийн 5-р зүйлд заасны дагуу "...гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно" хэмээн зохицуулжээ;

- *Монгол Улсын иргэний цнэмлэх, цндэсний гадаад паспорт*

⁵⁷ Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль (2007)

⁵⁸ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2001)

элэмших эрхгүй – Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 24-р зүйлд заасны дагуу "...гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-р зүйлд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба олгоно" хэмээн зохицуулжээ;

• *Иргэний эрх зүйн чадварыг хуулиар хязгаарлах* – Монгол Улсын Иргэний хуулийн 543.1-р зүйлд "Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно" хэмээн тусгажээ;

• *Сонгох, сонгогдох эрх* – Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.2-р зүйлд заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхгүй хэмээн заажээ;

• *Улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах эрхгүй* – Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.2-р зүйлд заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн албаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

• *Монгол Улсын иргэнээс газар өмчлөх, эзэмшил, ашиглалтандаа газар шилжүүлэн авах эрхгүй* – Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28.1.1-р зүйлд заасны дагуу газар өмчлөгч Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлгэлэх, барьцаалах зэргээр газраа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх эрхгүй байна;

• *Газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглох* – Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29.9-р зүйлд заасны дагуу иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно;

• *Улсын хилийн бүсэд байнга оршин суух эрхгүй* – Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26.5-р зүйлд заасны дагуу улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно хэмээн тусгажээ;

• *Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах эрхгүй* – Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33.2-р зүйлд заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно хэмээн тусгажээ;

• *Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхгүй* – Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 16.2.5-р зүйлд заасны дагуу

гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно;

• *Хүний хөгжлийн сангаас тэтгэлэг авах эрхгүй* – Монгол Улсын Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 15.1-р зүйлд заасны дагуу “сангаас хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээнэ” хэмээн зохицуулжээ.

ДҮГНЭЛТ

Олон улсын эрх зүй судлаачдын үзэж байгаагаар⁵⁹ орчин үед улс болгон харьяаллын асуудлыг өөрийн зохицуулалтаараа шийдсэн ч олон хүндрэлтэй асуудлууд үүсч байгаа бөгөөд дийлэнх улс орнууд давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх эсхүл тодорхой хэмжээгээр хязгаарлах хандлагыг баримталдаг. Судлаач А.И.Ковлевын үзэж байгаагаар “хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн улс болгон харьяаллын хүндрэлтэй асуудалтай (дипломат хамгаалал, цэргийн алба, хүүхдийн харьяаллыг тогтоох зэрэг) учрах төдийгүй, улс хоорондын харилцаанд тодорхой нөлөөлөл үзүүлэх болно”.⁶⁰

Хоёрдмол харьяаллын эсрэг үзэл баримтлалыг баримтлагч Швейцарын судлаач Р.Шерер “Улс гэдэг нь нэгэн том бие бүрэлдэхүүн бөгөөд өөрийн бүрэлдэхүүнд буй иргэдийн асуудлыг өөрөө бүрэн шийдвэрлэж байх хэрэгтэй. Гэтэл давхар харьяаллын асуудал үүссэнээр хоёр өөр улсын хооронд үл ойлголцох асуудал үүсэх, иргэний хувьд ч эдрээтэй асуудал үүсгэж байдаг. Амьдралд гарах аливаа асуудал бүгдийг гэрээ, конвенц, хуулиар шийдвэрлэх боломжгүй”⁶¹ хэмээн үзжээ.

Судлагаанаас харахад хоёрдмол харьяаллыг хүн ам цөөтэй улс гурнууд хүлээн зөвшөөрдөггүй байна.

Монгол Улсын Харьгааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын хувьд гадаад улсад амьдарч буй монголчуудаа эгүүлэн татах, Монгол Улсын харьяаллаас гарч байгаа иргэдийн урсгалыг зогсоох зорилго агуулж байгаа бөгөөд тус судлагааны ажлаар ийм зохицуулалтыг агуулсан гадаадын орнуудыг судалсан.

Гадаадын орнууд гадаад улсын иргэн болсон үндэстэн нэгтнээ эгүүлэн татахдаа болон гадаадын иргэдийг өөрийн оронд татахдаа дараах зохицуулалтуудыг ашиглаж байна. Энэ нь:

• **Иргэншил олгох процедураа хөнгөвчлөх:** Унгар, Герман.

⁵⁹ А.В. Белов (2002-2) *Двойное гражданство и проблема лояльности: Правоведение*. С. 157-161.

⁶⁰ Ковлер А.И. *Двойное гражданство: панацея или ловушка?!* Актуальные проблемы гражданства: Материалы международной научно-практической конференции по проблемам гражданства. М., 1995. С. 119

⁶¹ Шерер Р. *Практика и опыт стран Западной Европы в решении вопросов двойного гражданства// Материалы семинара по вопросам гражданства, безгражданства и статуса иностранцев в государствах СНГ и Балтии*. Хельсинки, 1994. С. 47

Казахстан зэрэг улсууд нь өөрийн орны иргэн биш боловч хилийн чанадад амьдарч буй нэг үндэстэндээ зориулж иргэншил хүссэн тохиолдолд бусдаас хөнгөлөлттэй нөхцлөөр иргэншил олгож байна;

- **Давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөх:** Энэ нь тухайн иргэнээ иргэний харьяаллаасаа хасахгүйн тулд давхар харьяалалтай байхыг зөвшөөрч байна. Мөн Европын Холбооны Улсууд нь давхар харьяаллыг Европын Холбоонд багтдаг улсуудын хувьд зөвшөөрч байна;

- **Байнгын оршин суугчийн эрх олгох:** Гадаадын орнууд өөрийн орондоо ажиллах хүч, хүн ам зүйн бодлого зэрэг олон шалтгааны улмаас гадаадын иргэдэд байнгын оршин суугчийн эрх олгож, тодорхой эрхүүдийг эдлүүлж байна. Жишээлбэл: "Цэнхэр карт"-ын системээр байнгын оршин суугчийн эрх авсан гадны иргэдэд нийгэм, эдийн засгийн хувьд давуу боломж олгож байна;

- **Гадаадад буй эх орон нэгтнүүддээ зориулсан зохицуулалт бий болгох:** ОХУ нь "эх орон нэгтэн" гэсэн ойлголтыг тодорхойлж, энэ хүрээнд тэдэнд зориулсан бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Судлагаанаас үүдэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар:

Судлагаанд хамрагдсан орнуудын хувьд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх замаар харьяат иргэдээ алдахгүй байх бодлого хэрэгжүүлдэг. Харин Монгол Улсын хувьд Харьяатын тухай хуулиар гадаад улсад буй иргэддээ зориулсан зохицуулалтыг оруулахыг удирдлага болгож байгаа бөгөөд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх асуудал нь иргэдийн "гадагш гарах урсгал"-ыг ихэсгэх сөрөг үр дагаварт хүргэх аюултай. Олон тооны Монгол Улсын иргэд гадаад улс руу явж ажиллах, суралцах, амьдрах хүсэлтэй байдаг хэдий ч тодорхой шалтгаанаар бүгд цагаачилдаггүйн нэг учир бол Монгол Улсын харьяаллаасаа гарахгүй байх хүсэл зоригт оршино. Мөн "гадагш чиглэх урсгал"-аас гадна "дотогш чиглэх урсгал"-ыг бодолцох хэрэгтэй. Тухайлбал, манай улсад БНХАУ, БНСУ, ОХУ-аас ирсэн олон тооны иргэд байдаг төдийгүй Монгол Улсын хүн ам зүйн байдал, хөгжлөөс хамаарч энэхүү иргэдийн тоог огцом нэмэгдүүлэх нь үндэсний аюулгүй байдал, хүн ам зүйн хувьд аюул учруулна. Дээрх шалтгаанаас улбаалан хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн Монгол Улсын хувьд харьяаллын асуудлыг зохицуулсан олон улсын олон талт гэрээнд нэгдэн ороогүй, харьяаллын асуудлыг хөндсөн хоёр талт гэрээг цөөн тооны улстай байгуулсан зэрэг нь хоёрдмол харьяалалтай иргэд олшрох, эдгээр иргэдийн эрх зүйн байдлыг цогцлон шийдвэрлэж чадахгүй байх зэрэг

сөрөг үр дагаварт хүргэнэ. Иймд энэ төрлийн гэрээнд нэгдэн орох, байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

2. Харьяаллын асуудлыг шууд бус хүлээн зөвшөөрөх замаар шийдвэрлэж болох эсэх:

Судлагааны ажлын удирдамжийн дагуу хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэж буйг судлахаас гадна мөн хоёрдмол харьяалалтай болсон иргэдийнхээ харьяаллын асуудлыг хөнгөвчилсөн журмаар зохицуулан, тэдний эрх ашгийг хамгаалж байгаа орны туршлагыг судлах зорилт дэвшүүлсэн. ОХУ-ын эрдэмтэн А.И.Ковлевын энэ асуудал дээр дэвшүүлж буй саналыг авч үзэхэд, гадаад улсад буй өөрийн орны иргэдэд харьяаллын болон бусад салбарт илүү хөнгөдөлттэй нөхцлийг бүрдүүлэх журмыг хуулийн бус хүрээнд зохицуулах хэрэгтэй хэмээн үзжээ⁶². Өөрөөр хэлбэл, энэ хүрээний асуудлыг тухайн улс өөрийн боловсруулсан үзэл баримтлал, хөтөлбөр хэлбэрээр шийдвэрлэж болно. Харьяатын тухай хуулинд “Монгол Улсын харьяатаас гарч гадаад улсын иргэн болсон иргэний хувьд...” гэсэн нэр томъёо оруулах нь Монгол Улсын хувьд олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчиж, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж, алагчилж буйг харуулна хэмээн үзэж байна. Дээр дурьдсан “Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хууль”-ийн 6-р зүйлд “...ОХУ-ын байгуулсан олон улсын гэрээ, конвенцид үл харшлах тохиолдолд...” гэсэн тодорхой заалтыг оруулсан байдаг.

3. Харьяатын тухай хуулиар харьяалаас гарсан иргэдийн асуудлыг шийдэх эсэх:

Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй. Гадаад улсын харьяат нь Монгол Улсын харьяат болохыг хүсвэл тухайн улсынхаа харьяатаас гарсан байх шаардлагатай”⁶³ хэмээн тусгасан. Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “...хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрөх замаар гадаад улсад амьдарч, оршин суудаг иргэдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах баталгааг бий болгох нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санаатай нийцсэн зохицуулалт юм...” гэсэнтэй санал нийлэхгүй байна. Нэгдүгээрт, хуулиараа хоёрдмол харьяалал хүлээн зөвшөөрөөгүй тул гадаад улсын иргэн болсон иргэдийг “гадаад улсын

⁶² Ковлер А.И. *Двойное гражданство: панацея или ловушка?!!* Актуальные проблемы гражданства: Материалы международной научно-практической конференции по проблемам гражданства. М., 1995. С.119

⁶³ Монгол Улсын Харьяатын тухай хууль, 1995 оны 6 дугаар сарын 5-ны д.р

иргэн” хэмээн тооцно. “Амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдэд хамаарах хүний эрхийн тунхаглал”-ын 1 дүгээр зүйлд: “гадаад улсын иргэн” гэдэг нь амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдийг хэлнэ”⁶⁴ хэмээн тодорхойлжээ. Хоёрдугаарт, нэгэнт гадаад улсын иргэн гэсэн ангилалд багтаж байгаа бол “Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль”-нар тус этгээдтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

4. Төсөл, хөтөлбөрөөр зохицуулах:

Дээр хэлсэнчлэн Монгол Улсын харьяаллаас гарсан гадаад улсад амьдарч буй монголчуудаа эгүүлэн татах бодлогыг Харьяатын тухай хуулиар цогцоор шийдвэрлэх боломжгүй юм. Гадаад орнуудын жишээг авч үзэхэд тусгай хөтөлбөр, үзэл баримтлалыг санал болгодог байна. Энэ тохиолдолд Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуулийг жишээг авч болно. Тус хуулийн талаар дээр дурьдсан бөгөөд гол санаа нь өөрийн орны өв, соёл, уламжлалыг хөгжүүлэх, эх хэлээ авч үлдэхэд оршино. Тухайлбал гадаад улсын иргэн болсон, ОХУ-ын иргэн хэдий ч урт хугацаагаар гадаад улсад амьдарч буй иргэд, тэдгээрийн үр хүүхэд орос хэл, соёл, уламжлалаа хөгжүүлэх, хадгалахад ОХУ-ын төрөөс хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх санааг агуулжээ. Энэ нь эдгээр иргэд нь ОХУ-д эргэн ирэх зайлшгүй шаардлагыг үүсгэхгүй байна. Ийм төрлийн үзэл баримтлал баталсан тохиолдолд дараах санааг агуулсан байх шаардлагатай хэмээн үзэж байна. Үүнд:

- Ямар төрлийн субъектэд зориулсан үзэл баримтлал (хөтөлбөр) байх талаар тодорхой зааж өгөх (гадаад улсад амьдарч буй Монгол Улсын иргэд, эсхүл Монгол Улсын харьяаллаас гарсан иргэд, өндөр, дээд боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн гадаад улсад амьдарч буй монголчууд, тэдгээрийн үр хүүхэд зэрэг хөтөлбөрт хамрагдах субъектыг тодорхой болгох);

- Субъектыг тодорхой болгох хүрээнд “эх орон нэгтэн” хэмээх нэр томъёо Монгол Улсын хуулиар тодорхойлсон зохицуулалт байхгүй байгаа тул Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуульд⁶⁵ “эх орон нэгтэн” гэсэн ойлголтыг авч үзэж буйг анхаарч, Монгол Улсын хувьд ийм нэр томъёо агуулсан зохицуулалт шаардлагатай хэмээн үзэж байна. Монгол Улсад “эх орон нэгтэн” хэмээх ойлголтыг тусгахын тулд нэр томъёоны хувьд маш тодорхой тайлбарлах шаардлагатай. Тухайлбал,

– “Эх орон нэгтэн” – монгол хэл, соёл уламжлал, заншил, зан уламжлалтай, эцэг, эх нь Монгол Улсын иргэн (иргэн

⁶⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 40/144 тоот тогтоолоор баталсан. Монгол Улс нэгдэн ороогүй. <http://www1.umn.edu/humanrts/instreet/Rw4dhr.htm> (сүүлд үзсэн 2011.03.09)

⁶⁵ Федеральный закон “О государственной политике Российской Федерации в отношении соотечественников за рубежом” № 99-ФЗ 1999.05.24.

байсан) гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг;

-“Эх орон нэгтэн” – урт хугацаагаар гадаад улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэнтэй гэр бүл болсны улмаас Монгол Улсын харьяаллаа алдсан этгээд гэсэн ойлголтуудыг агуулж болно.

• Мөн ОХУ-ын дээрхи хуульд буй “Нэгдмэл хэл, шашин шүтлэг, соёлын өв, зан уламжлалтай хүмүүс”, “гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд”, “соёлын болон оюун ухааны ашиг тусын төлөө түүхэн эх оронтойгоо холбоо тогтоох сонголт хийсэн гадаадад байнга амьдардаг оросууд” гэсэн ойлголтуудыг Монгол Улсад эрх зүйн зохицуулалтын хүрээнд нэвтрүүлэх хэрэгтэй. Ингэснээр өөрийн орны уугуул соёл, уламжлалаа өвлөн хадгалах, хөгжүүлэх, гадаад улсад буй эх орон нэгтнүүдээ эгүүлэн татах, эх орон нэгтнүүд, тэдгээрийн үр хүүхдэд монгол соёл, уламжлал, хэл, ёс заншлыг нэвтрүүлэх, хадгалах зэрэг ач холбогдолтой зохицуулалт бий болно;

• Тус үзэл баримтлал (хөтөлбөр)-ийн зорилгыг тодорхой болгох. Тухайлбал өндөр, дээд боловсролтой, нарийн мэргэжил эзэмшсэн монголчуудаа эх орны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор эгүүлэн татах бодлого, эсхүл өөрийн орны соёл, хэл, өв, уламжлалаа хамгаалах, хадгалах, хөгжүүлэх, эсхүл Монгол Улсын харьяаллаас татгалзаж гадаад улсуу гарч буй иргэдийн тоог багасгах, эсхүл харьяалал нь тодорхойгүй иргэдийн хувьд гэр бүл бүртгэл, виз, хүүхэд үрчлэлт, дипломат хамгаалал зэрэг асуудлыг хөндөх, эсхүл хоёр улсын иргэний дундаас төрсөн хүүхдийн харьяаллын асуудлыг тодотгох зэрэг тодорхой зорилготой байх хэрэгтэй;

• Тус үзэл баримтлал (хөтөлбөр) нь ямар төрлийн давуу хөнгөлөлтүүдийг эдлүүлэх гэж буйг сайтар судласны үндсэн дээр зохицуулах хэрэгтэй. Аливаа хөнгөлөлт нь иргэдийг татах бүс гадагш гарах байдлыг үүсгэж болохыг харгалзах хэрэгтэй;

• Монгол Улсын хуулиар “Эх орон нэгтэн” хэмээн ойлголтыг хуульчилсан тохиолдолд тэдгээр хүмүүст чиглэсэн дараах төрийн бодлогыг баримталж болох талтай. Тухайлбал,

- Монгол соёл, ёс заншил, хэл, өв уламжлалаа хадгалах, хөгжүүлэх үүднээс гадаад улсад буй эх орон нэгтнүүддээ чиглэсэн боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлж болно. Энэ тохиолдолд олон тооны монголчууд байрших газрыг сонгон авч монголчууд, тэдгээрийн үр хүүхдэд зориулсан монгол хэл, соёл уламжлал, зан заншлын талаар суралцах сургалтын төсөл хэрэгжүүлж болно;

- Энэ хүрээнд Дипломат албаны тухай хуульд заасан Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах, консулын болон нотариатын үйлчилгээ үзүүлэх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх, эд материал, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

үүрэгтэй гэсэн чиг үүргийг¹⁶ өргөжүүлж, уг газраар дамжуулж, Монгол Улсын иргэн, эх орон нэгтнүүдээ хэл соёл, түүх, зан заншил, уламжлалын хичээл зааж болох юм., Өөрөөр хэлбэл хилийн чанадад буй иргэдээ эгүүлэн татах шууд зохицуулалт хийхээс гадна тэдгээр иргэдийг эх орондоо өөрсдөө ирэх сэдэл төрүүлэхүйц бодлогыг явуулах хэрэгтэй байна.

- Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор бизнес эрхлэх, төсөл хэрэгжүүлэх гэж буй эх орон нэгтний санаачилгыг дэмжих, тодорхой түвшинд төрөөс хөнгөлөлт үзүүлэх;

- Эх орон нэгтнүүд олон тоогоор оршин суух гадаад улсад монгол хэлээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлж ажиллуулах.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.8.3, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн 250 дугаартай “Хөтөлбөр батлах тухай”¹⁷ тогтоол баталжээ. Тус тогтоолын дагуу “Зөгийн үүр” хөтөлбөр¹⁸, төлөвлөгөөг баталсны дагуу: “Хилийн чанадад өндөр боловсрол, мэдлэг, ур чадвар эзэмшин ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо урт, богино хугацаагаар эргэн ирж ажиллах, бизнес эрхлэх, гадаадын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, мэдлэг дамжуулах, хөрөнгө оруулалт татах зэрэг олон хэлбэр, чиглэлээр эх орныхоо хөгжилд дэвшилд хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав” хэмээн тусгажээ. Гадаад улсуудын жишээг авч үзэхэд, тус төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн хөшүүргээс гадна тодорхой нийгмийн хөшүүрэг байх хэрэгтэй хэмээн үзэж байна. Монгол Улсын хувьд “эх оронч сэтгэлгээ”, “өөрний орны ирээдүй, хөгжлийн төлөө санаа зовнисон сэтгэл” зэрэг үзүүлэлтийг ашиглан хөшүүрэг үүсгэх боломжтой.

¹⁶ Дипломат албаны тухай хууль-7.

¹⁷ “Зөгийн үүр” хөтөлбөрийн баталсан тогтоол, <http://cooperation.gov.mn/csuuld> үзсэн 2011.03.09/

¹⁸ ЗГ-ын 2010 оны 09 сарын 28-ны өдрийн 250 тоот тушаалын хавсралт “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг улс орны бүтээн байгуулалтад оролцоход дэмжлэг үзүүлэх Зөгийн үүр” хөтөлбөр

Хавсралт 1.

**ИРГЭНИЙ ХАРЬААЛАЛ, ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГЫН
ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ АГУУЛСАН ЭРХ ЗҮЙН АКТУУД**

д/д	Хуулийн нэр	Залт
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:		
1.	А я л а л жуулчлалын тухай хууль (2002)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.5."жуулчин" гэж аядал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

2.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (1993)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух журам, тэдний эрх, үүргийг тогтоож, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамаарах этгээд Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, гус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, байнгын оршин суугч цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид энэ хуульд "гадаадын иргэн" гэх) -д хамаарна. ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монгол Улсын виз, Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх 31 Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах, гарах-орох виз олгох; (Энэ заалтын дугаарыг 2001 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчилсөн) 16 дугаар зүйл. Визийн хугацаа 1.6) Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах-орох визийг 120 хүртэл хоног. (Энэ заалтад 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан) ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ЗОРЧИХ, ОРШИН СУУХ 27 дугаар зүйл. Харьяалалгүй хүн гадаадад зорчих 1. Монгол Улсад оршин суугаа харьяалалгүй хүн гадаадад зорчиж болно. 2. Гадаадад зорчих харьяалалгүй хүнд Албанаас баримт бичиг олгоно. 3. Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадад зорчих харьяалалгүй хүнд виз олгоход Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн холбогдох заалтыг баримтална. 28 дугаар зүйл. Монгол Улсад оршин суугаа цагаач, харьяалалгүй хүнд олгох баримт бичиг 1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Албанаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэгжийн оршин суугч болохыг тодорхойлсон "Монгол Улсад оршин суух үнэмлэх" олгоно. 2. Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаадад зорчихдоо оршин суух үнэмлэхээ нийслэлд Албанд хадгалуулж, бүрмөсөн явах тохиолдолд хураалгана. 3. Гадаадад зорчих харьяалалгүй хүнд олгох баримт бичгийн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
----	---	--

3.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (1993)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо 2. "Гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, хувь хүн (Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн)-ийг хэлнэ. 3. "Монголын хөрөнгө оруулагч" гэж хөрөнгө оруулалт хийж буй монголын хуулийн этгээд, хувь хүн (Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн)-ийг хэлнэ.
4.	Газрын тухай (2002)	ТАВДУГААР БҮЛЭГ Газар эзэмшүүлэх, ашиглуулах 32 дугаар зүйл. Газар эзэмших тухай хүсэлт гаргах 32.2. Иргэн энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана: 32.2.2. эзэмших газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг; 32.3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана: 32.3.1. аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, харьяалал, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 32.3.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг; 44 дүгээр зүйл. Газар ашиглуулах 44.4. Монгол Улсад байнга (183 хоногоос дээш хугацаагаар) оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага ху алдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ. 44.7. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргахын өмнө гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас тодорхойлолт авсан байна.
5.	Газрын төлбөрийн тухай (1997)	3 дугаар зүйл. Газрын төлбөр төлөгч Газрын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээ байгуулан газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна.

6.	Газрын хэвлий тухай (1988)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 9 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглагч 2. Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хувлийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашигдуулж болно.
7.	Галт зэвсгийн тухай (2001)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Галт зэвсэг өмчлөх 5 дугаар зүйл. Галт зэвсэг өмчлөх 5.4. Хуульд өөрөөр заагаагүй бол дипломат болон олон улсын байгууллагад ажиллаж байгаагаас бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хоригдоно.
8.	Галын аюулгүй байдлын тухай (1999)	ГУРАВДУГААР БҮЛЭГ Галын аюулгүй байдлын талаархи нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх, үүрэг 15 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаархи иргэдийн эрх, үүрэг 15.1. Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь эрхтэй байна: 15.1.1. гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтооход биечлэн оролцох; 15.1.2. гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээ авах; 15.1.3. Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах. 15.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь үүрэгтэй байна: 15.2.1. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх; 15.2.2. гал түймэр гарч байгаа тохиолдолд гал түймэртэй тэмцэх байгууллагад нэн даруй мэдэгдэх; 15.2.3. гал түймэр унтраах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх; 15.2.4. гал түймрийн талаархи зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шүүрхай мэдээлэх.

9.	Гэр бүлийн тухай хууль (1999)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим 4.6.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн,харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ. ХОЁРДУГААР БҮЛЭГ Гэрлэлтийн харилцаа үүсэх үйлэслэл, гэрлэх нөхцөл, журам, гэрлэлт дуусгавар болох 6 дугаар зүйл.Гэрлэх нөхцөл 6.1.Энэ хуулийн 9.1-д заасан харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно. 6.3.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, х арьяалалгүй хүний гэрлэх асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтална. 6.4.Монгол Улсын иргэд хоорондоо, эсхүд Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн буюу харьяалалгүй хүнтэй гадаад улсад тухайн улсын хуулийн дагуу гэрлэсэн нь энэ хуулийн 9-д харшлахгүй бол Монгол Улсад хүчинтэйд тооцогдоно. 6.6.Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад гэрлэсэн бол тэдгээрийн эрх, үүргийг гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар, сонгоогүй бол энэ хуулиар тодорхойлно. 12 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах журам 12.3.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтлана. 14 дүгээр зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах 14.10.Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд болон Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол гэрлэлт цуцлуулсныг хүчинтэйд тооцно. ТАВДУГААР БҮЛЭГ Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа 23 дугаар зүйл.Хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох 23.3.Хүүхэд Монгол Улсын иргэн бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяала лгүй хүнтэй холбогдолтой эцэг, эх тогтоох асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу шийдвэрлэнэ. ДОЛДУГААР БҮЛЭГ Хүүхэд үрчлэх 58 дугаар зүйл.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах 58.10.Энэ зүйл нь харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна. НАЙМДУГААР БҮЛЭГ Асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх 67 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих 67.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хү нийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөнө.
----	-------------------------------	--

10.	Даятгалын тухай (2004)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал 5.1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бүс хөрөнгөө Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.
11.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай (1994)	4 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх 2. Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.
12.	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай (2006)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Зохиогч, зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл 4 дүгээр зүйл. Зохиогчийн эрх эдлэх этгээд 4.1. Зохиогчийн эрхийг энэ хуулийн дагуу дараахь этгээд эдэлнэ: 4.1.1. бүтээл нь нийтлэгдсэн эсэхээс үл хамаарч бүтээл туурвисан Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
13.	Иргэдээс төрнийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай (1995)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг зүйл 5 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах эрх 2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ.

14.	Иргэний бүртгэлийн тухай хууль (1999)	ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫН БОЛОН ХҮН АМЫН ӨРХИЙН БҮРТГЭЛ 12 дугаар зүйл. Төрснийг бүртгэх 12.15. Эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат, эсхүл харьяалалгүй хүн бол тэдний дундаас тус улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн энэ зүйлд заасан журмын дагуу бүртгэнэ. 13 дугаар зүйл. Гэрлэлтийн бүртгэл 13.6. Тус улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй, эсхүл гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс хоорондоо гэрлэснийг Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан байгууллага эрхлэн бүртгэнэ. 13.9. Энэ хуулийн 13.2, 13.7-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авмагц иргэний бүртгэлийн ажилтан гэрлэснийг 30 хоногийн дотор бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийн гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 13.9.1. гэрлэгчдийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр; 14 дүгээр зүйл. Гэрлэлт цуцалсны бүртгэл 14.6. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан энэ хуулийн 14.2, 14.3, 14.5-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийг цуцалсан гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 14.6.1. гэрлэлтээ цуцлуулсан нөхөр, эхнэрийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр; 14.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэрлэлтээ цуцлуулах асуудлаа Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ. 16 дугаар зүйл. Үрчлэлтийн бүртгэл 16.3. Гадаадын иргэн Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах тухай нотариатаар гэрчүүлсэн хүсэлтээ нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл мэдээллийн албанд тус тус бичгээр гаргана. 16.5. Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах журам гадаадын иргэнээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хууль зүйн болон эрүүт мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
-----	---------------------------------------	---

	17 дугаар зүйл.Эцэг тогтоосон тухай бүртгэл 17.3.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхдийн эцгийг тогтоосныг эцэг, эхийн хамтран гаргасан өргөдлийг (өргөдөлд хүүхдийн эцэг мөн болохоо хүлээн зөвшөөрч байгаа иргэний овог, эцгийн нэр, нэр төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газрын хаяг, хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, эцэг тогтоосны дараа хүүхдийн овог, эцгийн нэр, өөрчлөгдөх эсэхийг дурдсан байна) үндэслэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэнэ. 17.6.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдсон эцэг тогтоосныг бүртгэхдээ энэ хуулийн 17-д заасныг баримтална. 18 дугаар зүйл.Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 18.4.Иргэн овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөх тухай өргөдлөө (өргөдөлд өргөдөл гаргагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн байдал, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, өргөдөл гаргагчийн сонгож авсан овог, эцгийн нэр, нэр, тэдгээрийг өөрчлөх болсон үндэслэл зэргийг дурдсан байна) гаргаж дараахь баримт бичгийг хавсаргана: 18.4.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг; 19 дүгээр зүйл.Нас барсны бүртгэл 19.5.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар энэ хуулийн 19.3-т заасан баримт бичгийг хүлээн авч иргэний нас барсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 19.5.3.иргэний харьяалал, оршин сууж байсан газрын хаяг; 19.7.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр, эсхүл тус улсын агаарын болон бусад хөлөг осолдсоны улмаас нас барсан гэж үзэх үндэстэй үед алга болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу нас барсан гэж зарласныг бүртгэж болно. ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ, ҮНДЭСНИЙ ГАДААД ПАСПОРТЫН БОЛОН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ 22 дугаар зүйл.Иргэний үнэмлэх 22.4.Монгол Улсын харьяат 16 нас хүрсэн иргэн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэний үнэмлэх авах тухай өргөдлөө гаргаж, дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана: 22.4.2.Монгол Улсын харьяат болгосон болон иргэний харьяаллыг сэргээн тогтоосон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. 24 дүгээр зүйл.Оршин суух үнэмлэх 24.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн дагуу цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д заасан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба олгоно.
--	--

		26 дугаар зүйл. Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх 26.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шилжин суурьших тохиолдолд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг баримтална. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ 29 дүгээр зүйл. Иргэний бүртгэл, мэдээллийн сан 29.1. Иргэний бүртгэл, мэдээллийн сан дараахь мэдээллийг агуулна: 29.1.13. Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний; ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ 39 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 39.1. Иргэний бүртгэлийн ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх хохирсон бол учирсан гэм хорыг хууль тогтоомжид заасны дагуу арилгана. 39.2. Иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчсөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
15.	Иргэний хууль (2002)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 7 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч 7.2. Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно. ЖАРАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид 543 дугаар зүйл. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадвар, чадамж 543.1. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно. 543.3. Харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг түүний байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно. 543.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хэлцэл, гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаархи гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг Монгол Улсын хуулиар тодорхойлно. 546 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах 546.2. Харьяалалгүй хүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн этгээдийн байнга оршин суудаг газрын хуулиар, хэрэв байнгын оршин суух газар байхгүй бол Монгол Улсын хуулиар зохицуулна.

16. Иргэний хэрэгшүүхэд хянан шийдвэрлэх тухай (2002)	АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 189 дүгээр зүйл. Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал 189.1.Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна. 189.2.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна: 189.2.1.нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг; 189.2.2.нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан ба тэдгээрийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг; 189.2.3.гэрээгээр хүлэсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нэхэмжлэл гаргасан ба тухайн үүргийг Монгол Улсад гүйцэтгэх ёстой байсан; 189.2.4.бусад гэм хор учруулсны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн этгээдэд хохирол учруулсан; 189.2.5.хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх салбар буюу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас маргаан үүссэн; 189.2.6.Монгол Улсын иргэн буюу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн эцэг тогтоох ба тэтгэмж төлөхтэй холбогдсон нэхэмжлэл гаргасан; 189.2.7.нэхэмжлэлийн зүйл нь өв залгамжлах эрх, өв залгамжлуулагчаас эд хөрөнгийг хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд өв залгамжлуулагч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл тухайн өв хөрөнгө Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа. 189.2.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна:
---	--

		190 дүгээр зүйл. Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн онцгой харьяалал 190.1.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн онцгой харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна: 190.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой маргаан; 190.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байршилтай хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах буюу тухайн хуулийн этгээдийн болон түүний салбар, төлөөлөгчийн газрын гаргасан шийдвэртэй холбоотой үүссэн маргаан; 190.1.3.Монгол Улсын шүүх буюу бусад эрх бүхий байгууллагын бүртгэл хүчин төгөлдөр эсэх талаархи маргаан; 190.1.4.Монгол Улсын эрх бүхий байгууллага патент, барааны тэмдэг болон бусад оюуны өмчтэй холбоотой эрхийг бүртгэсэн, бүртгэхээр өргөдлийг хүлээн авсантай холбоотой маргаан; 190.1.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга хэмжээ авсан буюу холбогдох этгээд ийм арга хэмжээ авахуулахаар өргөдөл гаргасан бол.
--	--	--

17.	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай (2002)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Эрүүл мэндийн даатгал 6 дугаар зүйл. Даатгалд хамрагдах хүрээ 6.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн эрүүл мэндийн даатгалд сайн дураар даатгуулж болно.
18.	Компанийн тухай (1999)	ГУРАВДУГААР БҮЛЭГ Компани байгуулах 12 дугаар зүйл. Компанийн үүсгэн байгуулагч 12.1.Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд,харьяалалгүй хүн байж болно. 12.2.Компаниас гаргасан хувьцааг иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.
19.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (1993)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 7 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа Төсөвт ба төрийн өмч оролцсон байгууллага (төрийн өмчийн хэсгээс нь), гадаадын байгууллага (хамтарсан байгууллагын гадаадын оролцогч), иргэн, харьяалалгүй хүнээс сонгууль бэлтгэн явуулах хугацаа (сонгууль зарласнаас эхлээд дуусталхи)-нд хандив авч болохгүй.
20.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай (1993)	ХОЁРДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ӨРХ 15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх 4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

21. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Иргэнд газар өмчлүүлэхэд баримтлах зарчим, үндэслэл 5.2. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрх эдлэхгүй. ХОЕРДУГААР БҮЛЭГ Иргэнд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааг зохицуулах талаархи төрийн байгууллага, нутгийн удирдлагын бүрэн эрх 12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 12.1.4. аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газар өмчилж авсан иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах; 14 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 14.1. Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 14.1.5. иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан сумын Засаг дарга газрыг нь хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах саналыг уламжлах; ГУРАВДУГААР БҮЛЭГ Иргэнд газар өмчлүүлэх 20 дугаар зүйл. Газар өмчилж авах тухай өргөдөл гаргах, түүнийг хянах 20.1. Иргэн газар өмчилж авах тухай өргөдөлд дараахь зүйлийг тусгана: 20.1.2. оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, өмчилж авах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал; ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Иргэний газар өмчлөх харилцааны онцлог зохицуулалт 28 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэнд хориглох зүйл 28.1. Газар өмчлөгч иргэнд дараахь зүйлийг хориглоно:
--	---

			28.1.1.өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүйхүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх; 29 дүгээр зүйл. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах 29.9. Иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлсөлх, дамжуулан түрээслэхийг хориглоно.
22.	Монгол Үндсэн (1992)	Улсын хууль	НЭГДҮТЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ Зургадугаар зүйл. 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно. 5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.
23.	Монгол хилийн (1993)	Улсын тухай	ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ХИЛИЙН ДЭГЛЭМ 23 дугаар зүйл. Монгол Улсын хилийн төлөөлөгч 5. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хил зөрчсөн гадаадын иргэн болон харьяалалгүй хүнийг хил залгаа улсын хилийн байгууллагад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд саатуулна. ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ХИЛ ОРЧМЫН ДЭГЛЭМ 26 дугаар зүйл. Улсын хилийн бүс, түүнд мөрдөх журам 5) хуульд өөрөөр заагаагүй бол улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно.

24.	Нийгмийн даатгалын тухай (1994)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ 4. Монгол Улсад байнга оршин суудаг, тус улсын аль нэгэн байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүнчлэн тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг Монгол Улсын иргэн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид хамаарна.
25.	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай (1994)	ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГА, ИРГЭД, БАЙГУУЛЛАГЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА 13 дугаар зүйл. Нийслэл хотын оршин суугч, нийслэлийн өмнө түүний хүлээх үүрэг 3. Нийслэл хотын оршин суугч биш Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийслэл хотод амьдарч байх хугацаандаа энэ хууль, бусад хууль тогтоомж, нийслэлийн удирдлагаас гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.
26.	С э ж и г т э н , я л л а г д а г ч и й г баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай (2002)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал 5.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт албадан саатуулагдсан, цагдан хоригдсон галзад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1 энэ хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний адил эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

27.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай (1994)	ДОЛДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВУУЛАХ 33 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах 2. Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.
28.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай (1999)	3 дугаар зүйл. Нэрийн данс нээх нөхцөл, журам 3.1.Нэрийн дансыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ.
29.	Төрийн албаны тухай (2002)	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам 16 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол 16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байг ууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно. 16.2.3. хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол: 16.2.4. гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

30.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай (1996)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Төрийн өмчийн зүйлс 4 дүгээр зүйл.Төрийн нийтийн зориулалттай өмч 4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн (Монгол улсын иргэн, гадаадын иргэн,харьяалалгүй хүн), бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.
31.	Улс төрийн намын тухай (2005)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Төрийн өмчийн зүйлс 4 дүгээр зүйл.Төрийн нийтийн зориулалттай өмч 4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн (Монгол улсын иргэн, гадаадын иргэн,харьяалалгүй хүн), бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.
32.	Харьяатын тухай хууль (1995)	Бүрэн эхээр нь харах.
33.	Хувь хүний орлогын албан татварын тухай (2006)	ХОЁРДУГААР БҮЛЭГ Албан татвар төлөгч 5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.
34.	Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай (2004)	ГУРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл 9 дүгээр зүйл. Иргэний эрх, үүрэг 9.3. Энэ зүйлийн заалт тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон дамжин өнгөрөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

35.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай (1996)	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 2.Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна. ХОЁРДУГААР БҮЛЭГ Хүүхдийн эрх, журамт үүрэг 5 дугаар зүйл.Хүүхдийн амьдрах эрх 1.Хүүхэд төрмөгцөөнэравах, Монгол Улсын харьяат байх эрхтэй. Хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.
36.	Эрүүгийн хууль (2002)	АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ 80 дугаар зүйл.Тагнуул хийх 80.1.Гадаад улсын иргэн буюу харьяалалгүй хүн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор төрийн нүүц, түүнд хамаарах мэдээ, баримт, бусад зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, тэдгээрийг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 89 дүгээр зүйл.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй.

37.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай (2000)	4 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна: 4.1.4. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн; 8 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх 8.3. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор нэг удаа төлнө.
38.	Өмгөөллийн тухай (2002)	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, түүнийг хүчингүй болгох 16.4. Монгол хэл мэддэг. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан харьяалалгүйхүн, гадаадын иргэн хуульч Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хүсвэл мэргэшлийн шалгалт өгсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл авна.
ХОЁР. УИХ-ЫН ТОГТООЛ		
39.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай (1999.06.10-ны өдрийн дугаар 43 тогтоол)	1) тэтгэврийн даатгалд даатгагдсан 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, эхний үлдэгдэл, шимтгэлийг уг дансанд тооцох, нийт даатгуулагчид мэдээлэх ажлыг 2000 оны эхний хагаст багтаан дуусгах;
40.	Харьяатын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай (1995.06.05-ны өдрийн дугаар 33 тогтоол)	Иргэний харьяаллын асуудлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сайд нарын Зөвлөлийн тогтоол, бусад шийдвэр, журмыг харьяатын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасгай.
ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		

41.	Журам батлах тухай (Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам) (1997.04.30- ны өдрийн дугаар 109 тогтоол)	Хавсралт Долоо.Харьяалалгүй хүний гадаадад зорчих үнэмлэх 30.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харьяалалгүй хүнийг гадаадад зорчиход түүнд зорчих үнэмлэх олгоно. 31.Харьяалалгүй хүнд олгох зорчих үнэмлэхийн загварыг Хууль зүйн сайд батална. 32.Харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих ажлыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв хариуцна. 33.Харьяалалгүй хүний зорчих үнэмлэх болон түүнд хавсаргах хүүхдийн үнэмлэхэд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга, хэлтсийн дарга гарын үсэг зурна.
42.	Журам батлах тухай (Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам) (2002.10.22-ны өдрийн дугаар 124 тогтоол)	Хавсралт 1.6. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхтэй холбоотой харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу зохицуулна
43.	Журам батлах тухай "Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам" (2003.03.12-ны өдрийн дугаар 62 тогтоол)	(Бүрэн эхээр нь харах)
44.	Орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай (1994.03.09- ний өдрийн дугаар 55 тогтоол)	Хавсралт. Гадаадын болон харьяалалгүй иргэдэд орон сууц хувьчлан өмчлүүлэхгүй.

45.	Х у у л и у д ы г хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай (Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам) (2003.02.07-ны өдрийн дугаар 28 тогтоол)	Хавсралт 1. Монгол Улсын иргэнд өмчлүүлэх болон иргэний өмчийн газар, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон тэдний эзэмшиж, ашиглаж байгаа газар, гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль тогтоомжийн дагуу ашиглуулах болон ашиглуулж байгаа газарт, түүнчлэн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн бусад газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (цаашид "хянан баталгаа" гэх) хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө. 27. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газарт хянан баталгаа хийхэд тухайн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн эрх баригч буюу захиалагч биеэр байлцах үүрэгтэй. 31. Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад, дотоодын хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж, өмчилж буй газрын хянан баталгааны паспортыг хянан баталгаа хийх эрх бүхий аж ахуйн нэгж хөтөлнө. Хянан баталгааны паспортыг газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрхийн гэрчилгээ, гэрээнд болон Монгол Улсын иргэний өмчилж авсан газрын үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус тус хавсаргана. 4) гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ашиглуулах газрын хил, заагийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, тодотгох; 9. Газар зохион байгуулалтыг дараахь харьяаллын дагуу эрхлэн гүйцэтгэнэ:
-----	---	---

		3) иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, түүнчлэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын байгууллага, хуулийн этгээдэд ашиглуулах газрын газар зохион байгуулалтыг хийхдээ аль болох нэг дор байрлах боломж зэргэлдээх газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрхийг хохироохгүйгээр зохион байгуулах, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн сервитут, узуфрукт эрх зэргийг харгалзах. 24. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ашиглуулж байгаа газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад энэ журмыг дагаж мөрдөнө. 1. Монгол Улсын иргэн, түүний гэр бүлийн гишүүн-Монгол Улсын иргэнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр хуульд заасан зориулалтаар газар өмчлүүлэх (цаашид "иргэнд газар өмчлүүлэх" гэх), иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, түүнчлэн Газрын тухай хуулийн 44.4-т заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах дуудлага худалдаа (цаашид "дуудлага худалдаа" гэх)-г зохион байгуулахад энэ журмыг дагаж мөрдөнө. 5. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ илэрхийлж, дэнчингээ зохих журмын дагуу тавьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн дуудлага худалдаанд оролцох эрхтэй. 6. Дуудлага худалдаанд оролцогч Монгол Улсын иргэн 5000 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн тус бүр 10000 төгрөг, ажиглагчаар оролцогч иргэн 1000 төгрөгийн хураамж төлнө.
--	--	---

Хавсралт 2.**ИРГЭНИЙ ХАРЬААЛЛЫН АСУУДЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ АГУУЛСАН МОНГОЛ УЛСЫН
НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/ Д	ГЭРЭЭНИЙ НЭР	ЗААЛТ
1.	А п а р т е и д ы н гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц ¹	(С) арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийг тухайн улсын улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд оролцоход саад учруулахад чиглэсэн хууль тогтоох шинжтэй буюу бусад арга хэмжээ авах, мөн хөдөлмөрлөх эрх, хүлээн зөвшөөрсөн үйлдвэрчний эвлэл байгуулах эрх, сүрч боловсрох эрх, эх орноосоо гарч явах, буцаж ирэх эрх, иргэний харьяалалтай байх эрх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрх, өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх, тайвнаар жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг оролцуулан арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг үгүйсгэх замаар тийм нэг буюу хэд хэдэн бүлэгт бүрэн хөгжиж дэвшихэд нь саад учруулах нөхцөл байдлыг санаатайгаар бий болгох;
2.	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц ²	(II) иргэний харьяалалтай байх эрх; Оролцогч улсууд харьяалалдаа байгаа хүн бүрийг энэхүү Конвенцийг зөрчин хүний эрх, үндсэн эрх чөлөөнд халдаж байгаа арьс үндсээр алагчилах аливаа үйлдлээс харьяалах үндэсний шүүх, төрийн бусад байгууллагаар дамжуулан үр нөлөөтэй хамгаалуулах, арга хэмжээ авахуулах, түүнчлэн арьс үндсээр алагчласны уршгаар үүссэн аливаа хохирлыг шударга бөгөөд зохих ёсоор нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээр хангана.

¹ 1973 онд батлагдаж, Монгол Улс 1975 онд нэгдэн орсон² НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1965 онд баталж, Монгол Улс 1969 онд соёрхон баталсан.

3.	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ ¹	г) зохигчид, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны овог нэр, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, эрхэлдэг ажил, боломжтой бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны төрсөн газар, он,сар, өдөр; 2.Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт буюу түүнийг цуцлах, хүчингүйд тооцогтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ. 2.Иргэний өөр өөр харьяалалтай эхнэр, нөхөр хүүхэд үрчлэн авч байгаа бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хэрэглэж болно.
4.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт ¹	1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.2. 2. Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй.
5.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал ²	1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй. 2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

¹ 1988 онд байгуулсан.² НҮБ 1966 онд баталж, 1968 онд Монгол Улс нэгдэн орсон.³ НҮБ 1946 онд баталж, 1961 онд Монгол Улс нэгдэн орсон.

6.	Хүүхдийн эрхийн тухай конвенц ⁶	1. Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана. 1. Хүүхэд төрмөгшөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ. 2. Оролцогч улсууд эдгээр эрхийг, ялангуяа хүүхэд иргэний харьяалалгүй болох тохиолдолд үндэсний хууль тогтоомж, холбогдох олон улсын баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэгтээ нийцүүлэн хэрэгжүүлнэ. 1. Оролцогч улсууд хуульд заасан иргэний харьяалалтай байх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах зэргээр хувийн онцлог байдлаа хадгалах хүүхдийн эрхийг хүндэтгэх, үүнд хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ
7.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц ⁷	1. Оролцогч улсууд иргэний харьяалалтай болох, түүнийг өөрчлөх буюу хэвээр хадгалах асуудлаар эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно. Тухайлбал, оролцогч улс эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй гэрлэх, гэрлэлтийн хугацаанд нөхөр нь иргэний харьяаллаа өөрчлөхөд эхнэрийнх нь иргэний харьяаллыг шууд өөрчлөхгүй байх, мөн түүнийг иргэний харьяалалгүй болгохгүй байх, эсхүл нөхрийнх нь иргэний харьяаллыг авахыг албадахгүй байхыг хангана. 2. Оролцогч улсууд хүүхдийн иргэний харьяаллын тухайд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно.

⁶ НҮБ 1989 онд баталж, 1990 онд Монгол Улс нэгдэн орсон.⁷ НҮБ 1979 онд баталж, 1980 онд Монгол Улс нэгдэн орсон.

СУБЪЕКТИВ ЭРХ БА ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ

Юуны өмнө яагаад энэхүү сэдвийг хөндөн бичих болсон тухайгаа судлаачийн хувьд товч боловч тайлбарлах нь зүйтэй болов уу.

1992 оны Үндсэн хуулийг дагаж мөрдөх болсноор социализмыг төгөлдөр байгуулж цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал бус хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх асуудал нь Монгол төрийн бодлогын төв болсон.

Гэвч хүний эрхийг бүхэлд нь нэг бүрчлэн тоочин хуульчилж хамгаалах боломжгүй юм. Тийм ч учраас хууль зүйн шинжлэх ухаанд объектив болон субъектив эрх гэж

зааглан үзэж эрх зүйн хэм хэмжээнд ялгамжтай байдлаар тусгасан байх нь бий. Эрхийн эдгээр ойлголтын мөн чанар, утга агуулгыг нэг мөр ойлгох нь хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх суурь нөхцөл болох нь дамжиггүй. Энэхүү өгүүллийн хүрээнд объектив, субъектив эрх нь хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголттой ямар холбоотой тухай товч авч үзэн, түүний мөн чанарыг илэрхийлэхийг зорьсон. Мөн аливаа эрх нь зарим талаар зөвхөн хувь хүн төднийгүй хуулийн этгээдэд¹ ч хамааралтай байдаг тул нийтлэг байдлаар авч үзсэн.

Объектив эрх гэдэг нь өргөн утгаараа хууль, эрх зүйн бусад актаар тодорхойлдсон эрхийг хэлдэг. Тодруулбал, газрын харилцаанд газар эзэмших эрх нь Газрын тухай хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээ болон гэрээний үндсэн дээр үүсч байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн газрыг эзэмших эрхтэй болохыг төрийн эрх бүхий байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрч үүнийг нотлосон эрхийн бичгийг газар эзэмшигчид өгснөөр эзэмших эрх үүснэ. Үүнийг объектив эрх гэж үзэх бөгөөд харин газар эзэмших талаар гаргаж буй хүсэлтийг субъектив эрх гэж үзэж болно. Нөгөө талаас, объектив эрхтэй хамт үүрэг үүсч байдаг бол субъектив эрхийг эдлэхдээ заавал үүрэг хүлээдэггүй. Мөн объектив эрхийн тухай ойлголт нь аливаа эрхийн эрх зүйн харилцаа үүссэн үед яригддаг бол субъектив эрхийн тухай асуудал нь эрх зүйн харилцааг үүсгэх шатанд хөндөгдөж болдгоороо ялгаатай.

¹ Энд Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг авч үзсэн болно.



ХЗҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир

Субъектив эрх гэдэг нь хуулиар зөвшөөрсөн буюу тогтоосон хязгаарлалтын хүрээнд субъектын эдлэх хууль зүйн боломж мөн.² Субъектив эрхийг дотор нь нийтийн болон хувийн хэмээн ангилдаг.³ Нийтийн эрх зүйд субъектив эрхийг өргөн утгаар нь авч үзвэл объектив эрх олж авах хууль зүйн боломж гэж үзэж болно. Харин хувийн эрх зүйд субъектив эрх нь хуулиар хориглон хязгаарласнаас бусад харилцаа хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн үндсэн суурь зарчимтай холбоотойгоор тайлбарлагддаг. Тэгвэл хууль ёсны ашиг сонирхол гэх ойлголт нь энд ямар хамааралтай вэ гэсэн асуудал гарч ирэх нь дамжиггүй юм.

Хувийн эрх зүйн хүрээнд субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголт нь нэг утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйд субъектив эрх нь хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголтыг давхар илэрхийлж байдаг. Энэ нь өмнө нь дурдсанчидан хувийн эрх зүйн хүрээнд хуулиар хориглосноос бусад харилцаа хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн зарчимтай холбоотойгоор тайлбарлагдана. Тийм ч учраас хувийн эрх зүйн суурь харилцааг зохицуулдаг Иргэний хуулийн агуулга "хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол" гэж субъектив эрхийг хэрэгжүүлэх нөхцөл буюу хууль зүйн боломжийг тухайн харилцааны оролцогчид чөлөөтэй эдэлж байхаар тусгасан байдаг. Нөгөө талаас, иргэний эрх зүй дэх зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн харилцааны зохицуулалтын хамгаалалтын объектыг бусдын эрх⁴ гэж хуульчилсан. Энэхүү ойлголт нь үндсэн 2 утгыг илэрхийлдэг. Үүнд:

- Бусдын гэдэг нь иргэний эрх зүйн чадвар, чадамжтай хэн ч байж болно гэсэн санаа;
- Эрх гэдэг нь объектив болон субъектив эрхийг хоёуланг нь илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалтад хууль буюу гэрээний үндсэн дээр олж авсан эрхээс гадна хуулиар хязгаарлаагүй эрхийг мөн хамааруулж үзнэ. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол ч хамгаалагдана гэсэн үг.

Хувийн эрх зүйд субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэг ижил утгаар ойлгож, уг эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг эрх зүйн харилцаанд оролцогчид тэгш эрхийн зарчим дээр өөрсдөө бүрдүүлдэг бол нийтийн эрх зүйд эдгээр нь ялгаатай.

Эрх зүйн харилцааны оролцогчид, тэдгээрийн эрх үүргийн байдлаар нь эрх зүйг нийтийн болон хувийн гэж ангилдаг онол байдаг. Эрх

² Баярсайхан Д. (2010) *Эрх зүйн онол* УБ: Эмито пресс, 168.

³ Дам ишлэв. Бэнзрагч.Г (2006-2) *Захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэлийн терлүүд болон тэдгээрт тавигдах тусгай урьдчилсан нөхцлүүд* // МТЗЗ, 61.

⁴ Иргэний хууль-497

зүйн харилцаанд нэг талаас төрийн байгууллага өөрт олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд нөгөө этгээдийг захирах байдлаар оролцож байвал нийтийн эрх зүйн харилцаа болно. Ийнхүү төр нь нийтийн эрх зүйн хүрээнд эрх мэдлээ хэрэгжүүлэх давуу эрхтэйгээр эрх зүйн харилцаанд оролцдог тул хүний эрх, эрх чөлөөг хангах үүднээс хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглоно гэсэн зарчим үйлчилдэг.

Нийтийн эрх зүйд дээрх зарчмыг хэрэгжүүлэх үндсэн 2 хэлбэр байдаг. *Нэгдүгээрт*, төрийн албанд хууль дээдлэх зарчмыг баримтлах⁴, *хоёрдугаарт*, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм.

Хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхийн мөн чанар нь эрх хэмжээний хувьд тэгш бус харилцаанд оролцогчийн эрхийг хамгаалах баталгаа болж байдаг. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага, албан тушаалтны явуулж буй үйл ажиллагаагаа нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих ёсгүй гэсэн үг. Гэвч захиргааны байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа нь уг зарчимтай нийцэхгүй байх нь амьдралд тохиолддог. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар энэхүү алдааны улмаас зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжийг хуульчилсан.

Эндээс нийтийн эрх зүй дэх субьектив эрх, хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголтуудыг авч үзэх шаардлага гарч байдаг. Өмнө дурдсан нийтийн эрх зүй дэх хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглох, хууль дээдлэх зарчмын үүднээс авч үзвэл захиргааны байгууллагын тухайд субьектив эрх гэсэн ойлголт байхгүй. Захиргааны эрх зүй нь үндсэндээ захиргааны байгууллагуудын эрх мэдэл, чиг үүргийг тодорхойлоход чиглэгддэг бөгөөд тэдгээр хэм хэмжээний нийлбэр цогцыг бүхэлд нь объектив эрх хэмээн ойлгож болно.⁵ Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь гагцхүү хуульчлагдсан эрхэд үндэслэгдэнэ.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг. Энд эрх, хууль ёсны ашиг сонирхол гэж зориуд хуульд тусгасан байгааг анхаарах нь зүйтэй юм.

Нийтийн эрх зүйн хүрээнд иргэн, хуулийн этгээд нь холбогдох хуульд заасан процедурыг дамжин эрх олж авдагийг өмнө дурдсан. Өөрөөр хэлбэл, аливаа эрхийг захиргааны байгууллага хүлээн зөвшөөрч, түүнийг илэрхийлсэн баримт бичгийг (гэрчилгээ, тусгай зөвшөөрөл) иргэн, хуулийн этгээдэд олгосноор эрх үүсдэг. Үүнийг нийтийн эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн объектив эрх гэж үзэж болно.

⁴ Төрийн албаны тухай хууль-4

⁵ Банзрагч Г. (2006-2) *Захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд болон тэдгээрт тавигдах тусгай урьдчилсан нөхцөлүүд* // ИТЭЗ, 61.

Тэгвэл нийтийн эрх зүйн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхийг хувийн эрх зүйн адил эрх гэсэн ойлголтод багтаан авч үзэх боломжгүй юм. Учир нь, нийтийн эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх үүргийг шууд тодорхойлсон байдаг бөгөөд үүнийг талууд хувийн эрх зүйн адил харилцан хүсэл зоригоо илэрхийлэн тодорхойлох боломжгүй. Тийм ч учраас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголт нь иргэн, хуулийн этгээдийн нийтийн эрх зүйн субъектив эрхийг илэрхийлж байдаг. Үүнийг нийтийн эрх зүйн хүрээнд үүсдэг дараахь тохиолдолд тулгуурлан тайлбарлавал илүү ойлгомжтой байх болов уу.

Газрын тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэдэг.⁷ Мөн газар эзэмшүүлэх дуудлага худалдааг Монгол Улсын Засгын газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу зохион байгуулна. Уг журмаар дуудлага худалдааны зард тавигдах шаардлагыг тогтоож өгсөн бөгөөд журмын 7-д "Дуудлага худалдааны зар мэдээг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ" гэж заасан нь нийтэд хандсан хэм хэмжээ бөгөөд тухайн газрыг эзэмших хүсэлтэй иргэн аж ахуйн нэгжийн дуудлага худалдаанд оролцох субъектив эрх буюу хууль ёсны ашиг сонирхлыг хангаж байгаа хэлбэр юм. Хэрэв газар эзэмшүүлэх дуудлага худалдааны зарыг дээрх журамд заасан 30 хоногийн хугацааг баримтлалгүйгээр явуулсан тохиолдолд тухайн дуудлага худалдаанд оролцох сонирхолтой этгээдийн эрх гэхээсээ илүүтэйгээр хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөд хүрнэ. Өөрөөр хэлбэл, газар эзэмшүүлэх дуудлага худалдааг журам зөрчин явуулсан тохиолдолд уг дуудлага худалдаанд оролцогчийн объектив эрхийн тухай яригдахгүй боловч тухайн газрыг эзэмших дуудлага худалдаанд оролцох субъектив эрх зөрчигдөнө. Энэ тохиолдлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан иргэн хуулийн этгээдийн хууль ёсны ашиг зөрчигдсөн гэж үзэж болно. Нөгөө талаас, газар эзэмшүүлэх дуудлага худалдаа нь уг эрхийг олж авах эрх зүйн үндэслэл болох тул энд ямар нэгэн объектив эрхийн талаар ярих боломжгүй. Гэхдээ энэ тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөнийг тогтоох урьдчилсан нөхцөл заавал хангагдсан байх ёстой бөгөөд энэ нь тухайн газрыг эзэмших талаарх хүсэлтээ захиргааны байгууллагад бичгээр илэрхийлсэн байх явдал юм. Ингэж байж субъектив эрх буюу хууль ёсны ашиг сонирхлын илэрхийлэл нь эрх зүйн үр дагавар

⁷ Газрын тухай хууль-33.33.1.2

үүсгэнэ.

Тэгвэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан эрхийг ямар тохиолдолд зөрчигдсөн гэж үзэх вэ? гэсэн асуулт гарч ирэх нь ойлгомжтой юм. Энэхүү эрхэд өмнө нь дурдсан нэгэнт үүссэн эрх буюу захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг ойлгоно. Үүнийг мөн л Газрын тухай хуулийн жишээн дээр тайлбарлая.

Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшүүлэхэд “хүсэлт гаргасан газар нь бүсдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна”⁶ гэсэн шаардлага тавигддаг. Хэрэв эзэмшихийг хүссэн газрын кадастрын зураглал болон бусад алдаанаас болж дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар нь өөр этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газартай давхцсан тохиолдолд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан эрх буюу нэгэнт хууль журмын дагуу олж авсан объектив эрх зөрчигдөж байна хэмээн үзэж болно.

Дүгнэлт

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол нь мөн чанартаа ижил боловч нийтийн болон хувийн эрх зүйн хүрээнд ялгамжтай байдлаар зохицуулагджээ. Энэ нь нийтийн болон хувийн эрх зүйн хүрээнд эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх зарчмын ялгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Тодруулбал, хувийн эрх зүй нь зохицуулалтын диспозитив буюу тэгш эрхийн аргыг хэрэглэдэг бол нийтийн эрх зүйд императив буюу захирамжлан зохион байгуулах арга⁷ хэрэглэгддэг. Үүнээс улбаалан хувийн эрх зүйд субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол гэх ойлголтуудыг эрх гэсэн ерөнхий байдлаар авч үздэг бол, нийтийн эрх зүйд субъектив эрхийг хууль ёсны ашиг сонирхол гэж тодорхойлдог байна.

Хувийн эрх зүйн хүрээнд эрх зүйн харилцааны оролцогч нь субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхолоо илэрхийлсэн эсэхээс үл хамааран зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн хамгаалалтын объект болдог бол нийтийн эрх зүйн хүрээнд хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлсэн нөхцөлд хамгаалалтын объект болж байдаг.

⁶ Газрын тухай хууль-31

⁷ Баярсайхан Д. (2010) Эрх зүйн онол УБ. Экимто пресс. 191.

ШҮҮХЭЭС ХЭРГИЙГ НЭМЭЛТ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТАД БУЦААХ НЬ ХЭНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Баян-Өлгий аймгийн прокурор, магистр Т.Батсүх

“Хэрэг задарлаа” гэх холбогдогч (сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг мэргэжлийн бус холбогдогч гэх нь элбэг)-ийн сэтгэл уужирсан аястай үгийг хүмүүс олон удаа сонсон байх. “Хэрэг задарч гэнэ, мэд шийдэгдэхгүй биз, тэгж байгаад замхарна, хахууль өгсөн биз” гэх хохирогч талын харамсах аястай гутрангүй үгийг ч сонсож байцгаасан байх. Зарим хэрэг 3-4 жил үргэлжлэн мөрдөн байцаалтад олон дахин буцаж яллагдагчид таатай нөхцөл бүрдүүлж, хохирогч талыг залхаан чирэгдүүлдэг явдал гарсаар байна.

Тэгэхээр хэрэг буцаах нь яллагдагч талд ашигтай гэсэн сэтгэгдэл олон нийтийн дунд хэвшмэл болсон нь дээрхээс тодорхой харагдана. Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд 2007 онд хүний амийг хүчирхийлж бусниулсан гэмт хэргийн хохирогч 3 жил орчим хуулийн байгууллагын албан тушаалтны хаалга сахиж гүйсээр сүүлдээ цөхрөнгөө барж сэтгэл зүйн болоод эд материалын хувьд хохирон чирэгдэж билээ. Манай аймагт хэд хэдэн он дамнан шалгагдаж удааширсан хэргүүд ч нэлээдгүй байна.

Олон дахин хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаж шийдэгдэх эсэх нь эргэлзээтэй болсон хэргийн холбогдогч, хохирогч аль аль талын ар гэрийнхэн, төрөл садангууд нь хуулийн байгууллагад (цагдаа, прокурор, өмгөөлөл, шүүх) итгэх итгэл алдарч сүүлдээ төрийн захиргааны байгууллагад, тодруубал, сүм, аймгийн Засаг дарга цаашлаад УИХ-ын гишүүд хандаж тусламж хүсэх нь элбэг.

Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дэргэдэх эрх зүйн туслалцааны төвд 2009 онд 1180, 2011 онд 1334 иргэн хууль зүйн зөвөлгөө, лавлагаа авсны дотор эрүүгийн гэмт хэрэгт холбогдож удаан хугацаанд шийдэгдэхгүй байгаагаас чирэгдэж, зүдэрсэн тухай гомдол гаргасан иргэд 10 орчим хувийг эзэлж байна.¹ Энэ асуудлаар гомдол гаргагчид “...зориуд удаашруулж байна, яллагдагчид ашигтай боломжийг бүрдүүлэх гэж байна” гэсэн гомдол, хардалт ямагт цухалзаж байдаг нь ажиглагддаг. Энэ нь хуульч бидний анхаарал татсан сэдэв болоод байна. Хэргийг аль болох шуурхай шалган, хэрэг үйлдсэн гэж үзвэл яллах, эсхүл цагаатгах буюу хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж иргэдийг чирэгдүүлэхгүй байх нөхцөл, боломж бүрдүүлэхэд бага ч гэсэн хэрэгтэй санаа өгч чадвал энэ сэдвийн ач холбогдол оршино.

¹ Аймгийн Эрх зүйн туслалцааны төвийн 2009 оны ажлын тайлан.

Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан асуудлаар шүүх, прокурорын байгууллагаас гаргасан дараах тоон мэдээнүүд байна.

2009 оны эхний хагас жилийн байдлаар Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хуралдаанаар хянан хэлэлцсэн нийт 279 хэргээс 69 (25%) хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосноос 63 (54%) нь хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаасан байна.² Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2129 хэрэг хүлээн авснаас 2016 хэргийг хянан шийдвэрлэж, 503 буюу 25,0 хувьд нь захирамж тогтоолыг хүчингүй болгожээ.³ Баян-Өлгий аймгийн сум дундын шүүхийн 2009 оны эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн мэдээгээр бүгд 28 хэргийг нэг удаа, 8 хэргийг 2-3 удаа нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан байна. 2010 онд бүгд 16 хэргийг нэмэлт ХБМБ-тад буцаажээ.⁴

Хэргийг нэмэлт хэрэг бүтгэлт, мөрдөн байцаалтад (цаашид ХБМБ гэж товчилно) буцаах нь эрүүгийн байцаан шийтгэх ажилгааны (ЭБША) нэг өвөрмөц хэлбэр юм. Нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахын учир холбогдол, уг үндэслэл нь ЭБША-ны үндсэн зорилт, зарчимтай шууд холбоотой.

ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах нь ЭБША-ны зорилт болохыг хуульчлан заасан. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй хэмээн ЭБША-ны нэг үндсэн зарчим болгон заасан.

Энэхүү зорилт, зарчимд нийцүүлэн ЭБША-г хэрэгжүүлэгч⁵ дараах субъект эрүүгийн хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр ХБМБ-д буцаана. Үүнд: прокурор, шүүгч, шүүх орно.

ЭБШХ-ийн 193 дугаар зүйлийн 193.1.18 дахь заалтад прокурор нь нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаах эрхтэй болохыг хуульчилжээ. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокурор дараах асуудлыг заавал хянах үүрэгтэй.⁶ Үүнд:

² (2009-002) // Монгол Улсын дээд шүүхийн мэдээлэл У6, 25.

³ (2011) Монгол Улсын шүүхийн 2010 оны ажлын тайлан У6, 41.

⁴ Баян-Өлгий аймгийн сум дундын шүүхийн мэдээ.

⁵ ЭБШХ-5.1.1.

⁶ ЭБШХ-214.1

1. Гэмт хэргийн бүрэлдхүүн байгаа эсэх;
2. Хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байгаа эсэх;
3. ХБМБ-тыг бүрэн, бодиттой явуулсан эсэх;
4. Сонсгосон ял нь хэрэгт байгаа нотлох баримтад үндэслэгдсэн эсэх, ХБМБ-таар тогтоогдсон бүх гэмт хэргийг хамаарч чадсан эсэх;
5. Гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;
6. Эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг зөв хэрэглэсэн эсэх;
7. Иргэний нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авсан эсэх.

Эдгээрээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг бүрэн, бодиттой явуулаагүй, сонсгосон ял нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар тогтоогдсон бүх гэмт хэргийг хамаарч чадаагүй, гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татаагүй, эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг зөв хэрэглээгүй, иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ аваагүй гэж үзвэл нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тогтоол гаргана.

Шүүх нь ЭБШХ-ийн 225 дугаар зүйлд зааснаар шүүхэд ирсэн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн дүүрэн хийгдсэн байна уу, хэрэв дутуу хагас хийсэн зүйл байвал түүнийг шүүхээс нөхөж гүйцээх боломжтой байна уу гэдгийг шүүгч нягтлан үзэж тодруулсаны үндсэн дээр яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж захирамж гаргана. Хэрэв хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн гүйцэд хийгдээгүй, түүнийг шүүхийн журмаар нөхөн биелүүлэх боломжгүй гэж үзвэл нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаадаг. Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн бөгөөд ингэснээр шүүх хуралдааныг явуулах боломжгүй байдалд хүргэсэн бол хэргийг прокурорт буцаана.

Түүнчлэн прокуророос яллах дүгнэлт үйлдэн (хөнгөн гэмт хэрэгт яллагдагчаар татсан тогтоолыг баталж) шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүгч уншиж, нягтлан үзсэний дараа захирамж гарган нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж болдог.⁷ Үүнд: хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан бол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бол, ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн бол⁸ тус тус буцаана. Эдгээр үндэслэлээр буцаасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш

⁷ УЕП-ийн 2006 оны 309 тоот тушаалаар баталсан журмыг үз.

⁸ Бат-Эрдэнэ Б (2009) *Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй (альбом, схем)* УБ. 116.

ажлын 5 хоногт багтаан прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

Үүнээс гадна давж заалдах (ДЗШШ) болон хяналтын шатны шүүх (ХШШ) хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу анхан шатны шүүхэд буцаах эрхтэй.” Ингэж буцаахдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг явуулахдаа нэг талыг барьсан буюу бүрэн гүйцэд биш хийсэн, ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн, ЭХ-ийг буруу хэрэглэсэн үндэслэлээр хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр шүүх болон прокурот буцаана. Давж заалдах шатны шүүх дараахь үндэслэлийн аль нэг байвал анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож буцаана. Үүнд:

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэг явуулахад нэг талыг барьсан буюу бүрэн гүйцэд биш хийсэн;
2. Шүүхийн тогтоолд дурьдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй;
3. ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн;
4. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бөгөөд шүүгдэгчид хүнд ялтай хууль хэрэглэх шаардлагатай бол.

Эдгээр үндэслэлийн алинаар нь буцааж байгааг магадлалдаа тодорхой зааж, нэмж хийх ажиллагааг нэн ойлгомжтой, хуулийн үндэслэлтэй, тухайн хэрэгт ач холбогдол бүхий байх шаардлагыг хангасан байна. Өөрөөр хэлбэл, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, эсхүл нэмэлт ажиллагаа хийлгэж дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана гэсэн үг юм. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа шүүхийн тогтоол гаргахад ач холбогдолтой байж болох байдлыг тодруулалгүй орхигдуулсан байвал нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн гэж үзнэ. Түүнчлэн хэрэгт ач холбогдол бүхий мэдүүлэг өгч болох хүмүүсийг байцаагаагүй, баримт бичиг, эд мөрийн баримтыг шаардан гаргуулж аваагүй эсвэл зайлшгүй хийвэл зохих шинжилгээг хийлгээгүй, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг бүрэн гүйцэд тогтоогоогүй, урьд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн хэлэлцүүлэгт буцаасан захирамж, тогтоолын заалтыг биелүүлээгүй бол нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн гэж үздэг.¹⁴

Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ ЭБШХ-ийг ноцтойгоор зөрчсөнийг тогтоовол хяналтын шатны шүүх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу шүүхийн шинэчлэсэн хэлэлцүүлэгт буцаана. (ЭБШХ-ийн 352.1)

Хуулийн дээрх заалтуудаас үзэхэд хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах үйл ажиллагаа нь прокурорын болон шүүхийн гэсэн хоёр үе шатанд хэрэгжиж байна. Эдгээрээс шүүхийн шатнаас

¹⁴ ЭБШХ-315, 352.

¹⁵ Мөн тэнд-318.

хэргийг буцаахтай холбогдсон үзэл бодлоо хуваалцаа.

Шүүхээс хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт болон шүүхэд буцаах гэсэн 2 хэлбэр байгаа нь тодорхой харагдаж байна.

Энэхүү сэдвийг сонгохдоо шүүхээс шүүхэд (ДЗШШ-ээс АШШ-д магадлалаар, ХШШ-ээс анхан болон ДЗШШ-д тогтоолоор) дахин шинэчилсэн хэлэлцүүлгээр шийдвэрлүүлэхээр буцаах асуудлаар бус харин прокурорт буюу нэмэлт ХБМБ-тад буцааж буй асуудлыг цэгцлэх талаар санаа, бодлоо нэмэрлэхэд чиглэсэн билээ. Шүүхийн шатнаас хэрэг буцаах нь маш ховор тохиолддог процесс баймаар санагдсанаа юун түрүүнд хэлмээр байна. Учир нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ЭБШХ-ийн хүрээнд олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн шалгаж холбогдогч буюу сэжигтэн, яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн, ялах боломжтой нөхцөл байдлуудыг бүрэн тогтоож (дутуу бол прокурор даалгавраар гүйцээж хийлгэх) улсын ялагч нэгэнтээ яллах бүрэн боломжтой гэж үзэж шүүхэд шилжүүлдэг. Энэ хоёр шат (хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон прокурорын хяналт гэсэн) -ыг бүрэн дамжиж ирсэн хэргийг шүүх буцаах нь нэн ховор үзэгдэл байхаар ойлгогдож байна.

Ялах тал буюу прокурор хэргийг шүүхэд шилжүүлсэн нь тухайн хэргийг таслан шийдвэрлэж шийтгэх тогтоол үйлдэх нөхцөлийг хангахад шаардагдах бүх нотлох баримтыг бүрдүүлсэн гэсэн итгэлтэй байгаагийн илэрхийлэл юм. Учир нь гарцаагүй нотолгоонд тулгуурлан гэмт хэргийг илрүүлж, буруутай этгээдийг илчлэх хэлбэрээр утга агуулга нь илэрхийлэгддэг төрхүү “мөрдөн мөшгих” ажиллагааны шат дамжлага бүрт чухамдаа прокурор, мөрдөн байцаагч хоёр гар нийлэн ажиллаж ямарч эргэлзээгүй бүрдүүлсэн хавтаст хэргээ шүүхэд шилжүүлдэг билээ.¹¹ Ийм хэрэгт Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, ЭБШХ-ийг ноцтой зөрчөөгүй бол зарим зүйлийг тодруулах, эргэлзээг арилгах зэрэг шалтгаанаар хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах нь зохимжгүй мэт ойлгогдож байна. Хэрэв ялх шалихгүй шалтгаанаар хэргийг буцаавал шүүх хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хутгалдахад хүрч шүүгдэгчийг ялах талд чиглэсэн заавар өгч байгаа дүр төрх харагдана.

Улсын хэмжээнд 2010 онд давж заалдах болон хяналтын шатны шүүхэд улсын ялагч болон дээд шатны прокурор 211 эсэргүүцэл бичжээ. Үүнээс давж заалдах шатны шүүхэд 183, 28 эсэргүүцлийг хяналтын шатны шүүхэд бичсэн бөгөөд 141 буюу 67% нь биелж, 70 эсэргүүцлийг шүүх хэрэгсэхгүй болгожээ. Эдгээр 211 эсэргүүцлийн 102 буюу 48 хувь нь шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад

¹¹ (2002-1) // Монголын төр, эрх зүй сэтгүүл, 66.

буцаасан үндэслэлийг эсэргүүцсэн байна.¹² Баян-Өлгий аймгийн шүүхээс 2010 онд 16 удаа 15 хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан бөгөөд 5 хэрэгт прокурорын эсэргүүцэл бичсэн нь биелжээ. Шүүхээс буцаасан үндэслэлүүдээс үзэхэд голдуу хохиролын хэмжээг зөв тогтоогоогүй, иргэний нэхэмжлэлийг зөв гаргуулаагүй зэрэг шалтгаан зонхилжээ. Хохирлын хэмжээ эргэлзээтэй, холбогдогчийн ам бүлийн тоог тогтоох, тухайн машин дотор хэдэн хүн сууж явсныг тогтоох гэх мэт шүүхийн шатанд нөхөж болох шалтгаар буцаасан хэргүүд ч байв. Эдгээрийн цаана ихэнхдээ хэрэгт холбогдогчид ашигтай байдлаар буцаах хандлага ажиглагдаж хохирогчид гомдоллох нь их байна.

Шүүгдэгчийн гэм бурууг тогтооход үнэхээр эргэлзээтэй буюу яллах тал энэ үүргээ хангалттай биелүүлж чадаагүй байвал шүүх шүүгдэгчид ашигтайгаар авч үзэж (ЭБШХ-ийн 13.2) хэргийг хэрэгсэхгүй болгож байх нь мэтгэлцэх зарчимд нийцэх бүс үү?. Хэрэв шүүгдэгчийг гэм буруутайд тооцуулах нөхцөл байдлуудыг шүүхэд нотолж чадахгүй бөгөөд нэмэлт ажиллагаа хийлгэж дахин хэлэлцүүлэх боломжтой гэж прокурор үзвэл өөрөө нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх саналаа шүүхэд тавих эрхийг ЭБШХ-ийн 230.1.4 дэх хэсэгт зааснаар прокурорт олгосон байдаг. Энэ тохиолдолд шүүх хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тухай бус прокурорын хүсэлтийг хангаж түүнд шилжүүлэх тухай захирамж, тогтоол гаргах хэрэгтэй. Харин энд нэг анхаарах асуудал бол прокурор өөрөө нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах шаардлагатай гэж үзсэн бол өөртөө эцэргүүцэл бичих ойлголт байхгүй. Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230.2 дахь хэсэгт хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаасан бол прокурор уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан эсэргүүцэл бичих эрхтэй гэсэн нь мөн хуулийн 230.1.4 дэх заалттай зөрчилдөж байна. Иймд 230.2 дахь хэсгийг "энэ зүйлийн 230.1.1-230.1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр" гэж тодотгон томъёолох шаардлагатай.

Шүүхээс хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж байгаа нэг сонирхолтой шат нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээс буцааж байгаа явдал. Хуулиар давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхэд ийм эрхийг олгосон учраас ийнхүү хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах нь зүйтэй боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг явуулахдаа нэг талыг барьсан, гүйцэт бус хийсэн гэсэн үндэслэлээр буцаах нь сонирхол татаж байна. Жишээ нь, аймгийн шүүх шүүгдэгчийн унаж явсан автомашинд хийсэн үзлэгээр дотроо 5 суудалтай байв гэж үзлэгийн тэмдэглэлд тусгаж бэхжүүлсэн, гэрчүүд 5 суудалтай УАЗ-469 машин гэдгийг мэдүүлсэн, фото зургаар

¹² www.gpo.mn –аас авсан мэдээлэл

бэхжүүлсэн байхад уг тээврийн хэрэгслийн суудлын тоог түүний техникийн тодорхойлолтоор нь тогтоо гэж буцаажээ. Практикаас үзэхэд, давж заалдах шатны шүүхийн магадлалд эсэргүүцэл бичих эрхгүй учраас заримдаа иймэрхүү шалихгүй үндэслэлээр ("бөөс түүх") хэргийг нэмэлт МБ-тад буцаах тохиолдол гарах болжээ. Энэ нь хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр болон нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахтай холбогдуулж давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал нэн даруй заавал биелэгдэх ба энэ магадлалд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болохгүй гэж Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар тогтоол (ЭБШХ-ийн 326 дугаар зүйлийн 326.1, 353 дугаар зүйлийн 353.4 дэх хэсгийг тайлбарлах тухай)-д заасантай холбоотой.¹³

Мөрдөн мөшгих байгууллага ЭБШХ-ийн хүрээнд мөрдөн шалгаж түүнд нь төрийн өмнөөс яллах эрх бүхий прокурор хяналт тавьж улмаар шүүх хуульд нийцүүлэн шийдвэртэсэн хэрэг энэ бүх шатанд гүйцэд биш хийгдсэн, нэг талыг барьсан байх нь тогтоогдож байгаа нь нэн сонирхолтой. Энэ нь өмгөөлөх талын эрх хэмжээ, хүсэл зориг ЭБША-ны дээрх бүх үе шатанд хэрэгжээгүйн хор уршиг илэрч байгаатай холбоотой бус гэж үү. Ингэж ойлгоход буруудахгүй. Жишээ: Ч гэгч нь согтуугаар А-г зодож санаатай алсан гэмт хэрэгт холбогдсон хэргийг Чингэлтэй дүүргийн шүүх Ч-г хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ЭХ-ийн 91.1-д зааснаар 10 жил 6 сарын хорих ялаар шийтгэжээ. Давш ЗИШ шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн байна. Анхан шатны болон ДЗШШ-ийн тогтоол, магадлалыг ХШШ-ээс хүчингүй болгож хэргийг нэмэлт МБ-д буцаажээ. Хүчингүй болгосон үндэслэл нь хохирогчийн биед маш олон тооны хөхрөлт, зулгаралт, гэмтэл үүссэн нь тогтоогдсон бөгөөд энэ гэмтлүүд нь үхэлд хүргэсэн тархины гэмтэлтэйгээ нэг цаг хугацаанд үүссэн шинэ гэмтэл болохыг шинжээч эмч мэдүүлсэн байхад түүнийг хэн, хэрхэн яаж учруулсан болохыг шалгалгүйгээр зөвхөн нэг удаа түлхэж унагааж амь насыг нь хохироосон гэж Ч-д яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлжээ. Эдгээр зүйлийг шалгаж тогтоосны эцэст хэргийг зөв зүйлчлэх шаардлагатай гэж ХШШ үзжээ.¹⁴ Эдгээрээс үзэхэд хэргийн материалыг шүүгдэгч талд ашигтай байдлаар бүрдүүлж хохирогч талын хүсэлт хангагдаагүй нь тодорхой байна.

Хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн шалгаж тогтоох зарчмыг зориуд алдагдуулсан буюу нэг талыг барьсан МБ-т явуулсны улмаас хэрэг олон удаа буцахад хүрч байна. Энэ байдлаас гарахын тулд ЭБША-ны

¹³ (2008) Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл УБ, 42.

¹⁴ (2008-004/89) // Монгол Улсын дээд шүүхийн мэдээлэл УБ, 27.

аль ч шатанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлдэг баймаар байна.

Зарим жишээнээс үзэхэд шүүх ЭХ-ийг илэрхий бүрүү хэрэглэж илт хууль бус тогтоол гаргах явдал байна. Энэ нь голдуу шүүгдэгч, хохирогчийн аль нэгний гомдол, хүсэлтийг хангах гэсэн дүр үзүүлсэн шийдвэр байдаг. Дээд шатны шүүхээс буцвал буцна биз гэсэн байдлаар гаргадаг гэсэн үг. Түүнчлэн үүний эсрэг дээд шатны шүүхээс эмээж хэрэг шийдэхдээ аль нэг талд хэлбийсэн тогтоол гаргах тохиолдол байдаг нь шүүгч нартай хийсэн ярилцлагын үеэр ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн болон удирдлага зохион байгуулалтын хараат байдалд орох явдал их биш ч зохих хэмжээнд байдаг гэж үзэхэд хүргэсэн.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэлт хийж хэргийг олон дахин буцаахаас сэргийлэх арга зам байж болохыг санал болгож байна.

1. Хэргийг “бөөс түүх” байдлаар ХБМБ-д шүүхээс буцаах нь шүүхийн зарим бүрүү үйл ажиллагаа, хандлагатай шууд холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, шүүгч шүүх хуралдааны байцаалтад идэвхитэй оролцож шүүгдэгчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух нь их байдаг. Энэ нь мэтгэлцэгч талуудын аль нэг рүү хэлбийсэн байдлаар өөрийгөө харуулах магадлал ихсэнэ гэсэн үг. Өөрөө асуулт тавьсан шүүгч аль нэг талд чиглэсэн итгэл үнэмшил нь лавширч улмаар түүндээ хөтлөгдөн нэг талыг барьсан шийдвэр (тогтоол) гаргах боломж илүү идэвхижих магадлалтай. Ийм учраас шүүгч төвийг сахисан байр суурь барих шаардлагатай. Төвийг сахина гэдэг бол шүүгч нотлох баримтыг биечлэн шинжлэхээс зайлсхийж талуудын гаргасан нотлох баримтад тулгуурлана гэсэн үг. Хэрэв нотлох баримт эргэлзээтэй, прокурор түүнийгээ баталж чадахгүй бол шууд л цагаатгах, хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах зоригтой байхыг шүүгч нарт хэлмээр байна. Шүүх өөрөө ХБМБ-д оролцож ийм зүйлийг ингэж шалга, тогтоо гэх мэт зааварчилгаа (даавгавар ч гэмээр) өгч байгаа нь зохисгүй юм. Хэрэв шүүх ингэж бусдын хагас дутуу ажилд хутгалдахгүйгээр (ийм үүрэг ч байхгүй) цагаатгаж эсхүл хэрэгсэхгүй болгож чаддаг бол прокурор хэргийг жинхэнэ бүх талаас нь “болгож” байж шүүхэд ирүүлдэг болно. Ингэснээр иргэдийг удаан хугацаагаар чирэгдүүлж хохироох явдал багасна.

2. Энэ сэдвийг бичих явцад ажиллагдсан бас нэг сонирхолтой зүйл бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуроруудын ажлын хариуцлагын асуудал байсан. ЭБШХ-д зааснаар хэргийг бүх талаас нь гарцаагүй нотлох баримтад тулгуурлан шалгаж тогтоох үүргийг эдгээр субъектэд хуулиар олгожээ. Үүний тулд эдлэх эрхийг ч хангалттай өгсөн. Энэ үүргээ биелүүлэлгүй илэрхий алдаа гаргасан бол ЭБШХ-ийн 8.2 дахь хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэдэг баймаар

байна. Хэрэг буцаж байна гэдэг нь прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ЭБШХ-иар хүлээсэн үүргээ зохих ёсоор хийгээгүй гэж үзэхэд хүргэж байна. Мэдлэг ур чадвар дутуу байна уу?, эсхүл зориуд хайнга хандаж дугуу шалгаад байна уу? гэдгийг ялгаж тогтоодог, буруутай бол хариуцлага тооцдог байх хэрэгтэй санагдав.

3. Хэргийг буцаахтай холбогдуулан өмгөөлөгчийн эдлэх эрхийн талаар ЭБШХ-д тодорхой заалт оруулмаар байна. Тухайлбал, хэргийг буцаах нь ашиггүй гэж үзвэл өмгөөлөгч эсэргүүцэл бичдэг байх хэрэгтэй. ЭБШХ-ийн 41 дүгээр зүйлд хэргийг нэмэлт ХБМБ-д буцаах тухай хүсэлт гаргах, эсхүл шүүгч, прокуророос буцаасныг зөвшөөрөхгүй бол эсэргүүцэх эрхийг зааж өгөх хэрэгтэй гэж үзэв.

ЭБША-н дахь мэтгэлцэгч талуудын эрх тэгш байдлыг бүрдүүлэхгүйгээр зөвхөн яллах талын эрхийг хангасан хууль, журам үйлчилж байгаа нь шударга ёсонд харш юм. Шүүхээс хэргийг нэмэлт ХБМБ-тад буцаасан нь буруу гэж үзсэн прокурор эсэргүүцэл бичдэг бол өмгөөлөгч уг шийдвэрт нь давж заалдах эрхтэй байхаар хуульчилж өгөх шаардлагатай юм. Хэрэв хэрэгт авагдсан нотлох баримт хангалттай бус бөгөөд өмгөөлөгч түүнийг нь няцааж чадаж байгаа бол яллах талын нөлөөнд оролгүй хэргийг цагаатгаж байх хэрэгтэй гэж үзэж байна. Учир нь хэргийг нэмэлт ХБМБ-тад буцаах сонирхол голдуу хэрэгт холбогдсон яллагдагч талд байдаг. Хохирогч аль болох хурдан шийдүүлэх сонирхолтой. Нэгэнт хийсэн хэрэг учраас аль болох хойш татаж хэргийг хөнгөрүүлэх арга, заль хайж хохирогчийг мохоон залхаах, мэдүүлгийн нөцтой зөрүү гаргах зэргээр цаг авах гэсэн байдлаар хандаж байгааг анхаарч энэ байдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг шүүгч, прокурор авч байх нь зүйтэй юм.

Хэрэг олон дахин буцвал анхны мэдүүлгийн өнгө нь өөрчлөгддөг, замхардаг, зүйл анги нь солигддог, ял завших нүх, сүв бүрэлдэх ч аюултай юм. Иймд хэргийг бага, сага шалтгаанаар буцаахдаа биш харин шууд шийддэг байх мэргэжлийн эр зориг шүүгч нарт дутах байгааг анхаарах хэрэгтэй.

Хэргийг буцаах нь яллагдагч, хохирогчийн аль алинд ашигтай байх албагүй төрд ашигтай байх буюу ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд заасан зорилтыг хангахад ач холбогдолтой байх ёстой. Учир нь шүүх засаглалын бүх үйл ажиллагаа зөвхөн хуулийн хүрээнд яв цав нийцэж байх учиртай.

ЭЗЭМШИЛ, ӨМЧЛӨЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Ромын эрх зүйн үеэс улбаалан улмаар XVIII зууны эцэс XIX зууны эхэн үеэс Германы иргэний эрх зүйн эрдэмтэдийн үзэл, онолд суурилсан пандектын (грекээр үгчлэн орчуулбал, Pandectae-бүхнийг хамаарах гэсэн утгатай) систем буюу сургаал нь эд юмсын эрх зүйн үндэслэл болох эдийн болон эдийн бус баялгийг өөрийн болгох, олж авах гэсэн өргөн хүрээнд тодорхойлогддог нь эрх зүйн харилцаанд төдийгүй эдийн засгийн харилцаанд ч нөлөө үзүүлдэг юм. Иргэний эрх зүйн харилцаанд эд юмсын эрх зүйн зохицуулалт байх нь тэдгээрийг олж авах үндсэн хэлбэр болох эзэмшлийг зүй ёсоор бий болгоно.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант Ц.Давхарбаяр

Монгол Улс 2002 онд Иргэний хуулиа шинэчлэн баталснаас хойш цөөнгүй хугацаа өнгөрсөн ба уг хуулийн хэрэгжих явцад бидэнд шинэлэг зохицуулалт гарч ирэх, улмаар онолын уламжлалт ойлголтуудыг сэргээх, судлах зүй ёсны шаардлага гарч байгаагийн нэг нь Иргэний хуулийн эзэмшлийн асуудал юм.

Хуулийн бүтцээс авч үзвэл, 1994 онд батлагдан мөрдөгдөж байсан Иргэний хуулийн II хэсэг нь өмчийн эрх зүйн зохицуулалт, үүндээ нийтлэг үндэслэл, өмчлөгчийн эрх, өмчлөлийн зүйлийг тус бүрд нь зохицуулж, улмаар газар өмчлөл, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрх болон өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох үндэслэлийг тусган, эцэст нь өмчлөх эрхийн баталгаа, хамгаалалтыг тусгасан бүтэцтэй байв.

Харин 2002 оны Иргэний хуулийн Y дэд хэсэг нь “Эдийн болон эдийн бус баялаг”-ын зохицуулалтыг тусгаснаараа “эд юмсын эрхийг хүндэтгэн сахин биелүүлэхийг бүх дэлхийгээс шаардаж болох бол үүргийн эрхийг хүндэтгэн хүлээн зөвшөөрөхийг гагцхүү үүрэг бүхий этгээдээс шаардаж болдгоороо”¹ онцлог бүхий эд юмсын эрх зүйн зохицуулалтыг шинэлэг түвшинд гаргах, өмчийн олон төрөл, хэвшил зэрэгцэн орших нөхцөл, боломж бүрэлдсэн гэж үздэг. Түүнчлэн “хувийн эрх зүйн а) диспозитив хэм хэм хэмжээ голлох, б) эрх зүйн харилцааны субъектууд нь тэгш эрхтэй байдаг, в) субъектууд эрхээ хэрэгжүүлэхдээ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлдэг, г) гэрээний зохицуулалтын хэлбэрийг чөлөөтэй ашигладаг, д) шүүхийн хамгаалалтаар баталгаажсан байдаг, е) амины, хувийн, явцуу бүлгийн ашиг сонирхлыг түлхүү хангах баримжаатай байх”² гэсэн шинжийг

¹ Маттее.У. Суханов Е.А (1999) Основные положения права собственности М., С.118.

² Нарангэрэл.С (2001) Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо УБ, 84.

агуулж байдаг иргэний эрх зүйн харилцаанд эд юмсын эрх зүйн харилцаа, түүн дотроо эзэмшлийн зохицуулалтыг тусгаж өгснөөр өмчлөгчийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээхэд шинэлэг хандлага зүй ёсоор бий болжээ.

• Эзэмшил. МУ-ын Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд хцэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүсэхийг зааснаар (Иргэний хуулийн 89-97 дугаар зүйл) эзэмшлийн зохицуулалт тусгагджээ.

Нийгмийн харилцааг зохицуулах Иргэний хуулийн шаардлага зүй ёсоор нэмэгдсэн зах зээлийн харилцаанд, иргэдийн хууль, эрхийн мэдлэг, хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа энэ үед тухайн ойлголтыг хэрхэн авч үзэх, эзэмшил, өмчлөлийн харьцааг зөв тодорхойлох нь зайлшгүй шаардлагатай болсон юм. Ихэнхдээ эзэмшил нь нэг талаар, өмчлөгчийн эрхийг баталгаажуулах, хамгаалах хэлбэр, нөгөө талаар, эд юмс, эрхтэй харьцаж байгаа этгээдийн эрх, түүний хүрээг тогтоож өгсөн уламжлалт ойлголт, зохицуулалт байдаг. Эд юмстай харьцах анхдагч ойлголт болохын хувьд эзэмшил ямар хүрээнд тогтоогдсон, өмчийн эрх зүйн харилцаанаас хамааралтай байх эсэхээс шалтгаалан түүний онцлог шинж тодорхойлогдоно. Тухайлбал, Ром- Германы эрх зүйн тогтолцооны томоохон төлөөлөл Германы Иргэний хуульд “эзэмшил нь бодит байдлаар эрхшээлдээ оруулах замаар үүсэхээр” (Германы Иргэний хуулийн 854 дүгээр зүйл) тусгасан нь түүний бие даасан байдлыг, өмчийн эрх зүйгээс хамааралгүй оршин байгааг харуулдаг.

Эзэмшил гэж нь юу болох, хэрхэн, яаж илэрхийлэг вэ гэдгийг авч үзвэл, Нэгдүгээрт, эрх гэж тодорхойлох боломжгүй, учир нь эзэмшил нь тодорхой орон зай, цаг хугацааны хүрээлэлд хөрөнгөтэй харьцаж байгаа, түүнд нөлөөлж байгаа нөлөөлөл, эрх мэдэл байдаг. Хоёрдугаарт, үйлдэл гэж тодорхойлбол уг үйлдэл ямар хүрээ, орчинд хэрэгжих боломжтой болохыг тодруулах шаардлагатай болдог учраас улс орны хууль тогтоомжид өөр өөрөөр зохицуулагддаг.

Харин энэ байдлыг МУ-ын Иргэний хуульд тусгагдсан эзэмшил хангаж чадсан эсэх, тухайн зохицуулалтын онцлог юу болохыг судлахын тулд эзэмшилд тавигдах шаардлага, шалгуурыг нэг бүрчлэн авч үзэх нь зүйтэй юм.

МУ-ын Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд заасан эзэмшил нь:

Нэгдүгээрт, хууль ёсны байх. Эдийн болон эдийн бус баялгийг олж авч байгаа үйлдэл зайлшгүй хууль ёсны үндэслэлтэй байхаар

зохицуулсан ба үүнийг УДШ-ийн 2009 оны тогтоол (тайлбар)-д "зөвхөн хууль болон гэрээнд заасан үндэслэлээр үүссэн эзэмшил нь эрх зүйн үр дагавар буюу шаардах эрхийг үүсгэнэ" гэж хууль ёсны байхын тулд эрх зүйн үр дагаварыг агуулсан байх шаардлагатайг тодотгон тайлбарласан юм. Үүгээрээ Германы Иргэний хуулийн зохицуулалтаас ялгагдах ба XIX зууны эхэн болон дунд үед үүссэн субъектив (К.Ф. Савиньн) ба объектив (Р.Перинг) эзэмшлын онолд тулгуурлан авч үзвэл субъектив буюу эд юмс, эрхийг мэдэлдээ оруулж байгаа тухайн этгээдийн үйлдэлд өөрийн зүгээс өгч буй дүгнэлт, хандлага болж байгаагаараа МУ-ын Иргэний хуулийн зохицуулалт нь онцлогтой болно. Чухамдаа "эцсийн дүнд хүмүүсийн өөрсдийн үзэл бодол, санааны үр дүнд хэн эзэмшигч вэ?", хэн нь бодитойгоор мэдэлдээ байлгаж байна вэ гэдгийг шийдвэрлэх" боломжтой болно.

Хоёрдугаарт: хүсэл зоригийн дагуу үүсэх эд юмс, эрх олж авч байгаа этгээд хүсэл зоригийнхоо дагуу мэдэлдээ оруулж авах ба иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид тэгш эрхийн үндсэн дээр харилцаанд оролцох ба үүгээр уламжлан, өөрийн хүсэл зоригийн үндсэнд хөрөнгө олж авах нь түүний хууль ёсны байх үндэслэлийг ч баталгаажуулна.

Гэхдээ энэ хүсэл зориг нь хэлцэл байгуулах үеийн хүсэл зориг биш юм. Тодруулбал, хөрөнгөд биеэр нөлөөлөх боломжтой болсон этгээдийн тухайн үйлдлээ хийх, хэрэгжүүлэх жинхэнэ хүсэл зориг байж л эзэмшилдээ оруулах ойлголт үүсч бүрэлдэнэ.

Гуравдугаарт: мэдэлдээ оруулах эд юмс, эрх олж авч байгаа этгээд мэдэлдээ оруулах замаар өөрийн ноёрхлыг бүрэн тогтоосон байхыг ойлгоно. Тэгэхдээ энэ мэдэл олж авч байгаа этгээдийнх л байж сая эзэмшлийн үндсэн утга илэрхийлэгдэнэ. Ийм учраас, өөрийн мэдэл, эрхшээлийг тогтоогоогүй этгээдийг Иргэний хуулийн 89.2-т "өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй" гэж заасан байна. "Мэдэл" гэдэг нь эрх, эд юмсыг ашиглах, арчлах, хамгаалах, зөөвөрлөх зэрэг нөлөөлөл үзүүлэх¹ боломжтой байхыг хэлнэ. Эзэмшил олж авах бодит үйлдэл нь Иргэний хуульд заасан хэлцэл биш бөгөөд бодит үйлдэл нь эд юмсын байнгын, бат бэх харилцаанд үндэслэсэн байхыг шаардана. Энэ нь эд юмст нөлөөлөх нөлөөллийн хүрээнд, эзэмшигч нь биеэр нөлөөлж байх бодит боломжтой байх, нөгөө талаар орон зайн хувьд авч үзвэл ойр байх гэсэн утгыг илэрхийлдэг.

Эдгээр шинжийг агуулж бүрдүүлсэн нөхцөлд эзэмшил үүсэх бөгөөд

¹ (2005) Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар УБ, 357.

² Бат-Өлзий Д (2003) Иргэний эрх зүй УБ, 109.

эзэмшлийн зохицуулалт Иргэний хуульд тусгагдсанаар өмчлөгч эрхээ хамгаалах, хууль ёсоор хөрөнгө эзэмшиж байгаа этгээд эрхээ хамгаалуулах буюу улмаар өмчлөгч эзэмшигчийн байр суурийг тодорхойлох, тэдгээрийн хоорондын холбоог хуулиар зохицуулах зүй ёсны шаардлага гардаг байна. Үүнээс дараах ойлголт урган гарч байна.

• Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д зааснаар "... аливаа этгээд хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн болон эдийн бус баялгийг олж авч болох ба ингэж олж авсанаар баялаг нь тухайн этгээдийн хувьд хөрөнгө болохыг заажээ. Энэ зохицуулалт нь эзэмшлийн гол үндэслэл болох бөгөөд нэгэнт эдийн болон эдийн бус баялгийг хуульд хориглоогүй аргаар олж авах нь зүй ёсонд нийцсэн үйлдэл болохыг хууль тогтоогч тогтоосон нь эзэмшил ч хууль ёсны дагуу байж нэгдсэн нэг ойлголтод хүрэх үндэслэлтэй болно.

• Эзэмшигч нь дээрх шаардлагыг ханган эрх, эд юмсыг мэдэлдээ авснаар хууль ёсны эзэмшигч болж, нэгэнт хууль ёсны эзэмшигч болсон бол эд хөрөнгийг түүнээс шаардаж болохгүй (Иргэний хуулийн 93.1) нь эзэмшлийг баталгаажуулсан зохицуулалт юм. Эндээс эд юмс, эрхийг мэдэлдээ оруулж авсан үйлдэл нь хууль ёсны болохыг маргааны явцад нотолсон, эсвэл гарцаагүй хууль ёсны болох нь тодорхой тохиолдолд дээрх байдлаар хуулиар хамгаална.

Харин үүссэн эзэмшлээ хууль ёсны болохыг нотолж чадаагүй бол өмчлөгч шаардаж байгаа тохиолдолд өмчлөгчид хөрөнгийг буцаан өгөх үүрэг хүлээнэ.

Иргэний эрх зүйн онолын хувьд эд юмстай харьцах анхдагч ойлголт гэж үздэг эзэмшил зайлшгүй, хууль ёсны байх гэсэн тодотголтой болсноор эзэмшил эд юмсын эрх зүй ба өмчийн эрх зүйн хүрээнд асуудал үүсгэх, тухайлбал, эзэмшил, өмчлөлөөс ялгагдахгүй байх, эзэмшил үндсэн ойлголтоороо хэрэгжих боломжгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Нөгөө талаар, Улсын дээд шүүхийн тайлбарт аливаа эзэмшил эд юмст нөлөөлөх нөлөөлөл бус харин хуульд заасан үндэслэлээр болон гэрээний дагуу үүсч, ингэснээрээ шаардах эрхийг бий болгож байгаа нөхцөлд эзэмшил нь уламжлалт онолын агуулгаар буюу Иргэний хуулийн 115, 116 дугаар зүйлд заасан (эзэнгүй эд юмс болон гээгдэл эд хөрөнгө олж авах) үндэслэлээр эзэмших эрхийг, эзэмшлийг бий болгож болох юм. Тухайлбал, "өмчлөгчгүй, өмчлөгч өмчлөх эрхээ дуусгавар болгох зорилгоор эзэмшлээсээ татгалзсан эзэнгүй эд хөрөнгийг хуулиар хориглоогүй аргаар олж авсан, эсхүл тухайн эд юмсыг олж авахдаа эрх бүхий этгээдийн эрхийг зөрчөөгүй бол эзэмшилдээ авч, өмчлөх эрхтэй" байгаа нь хэн нэгэн этгээдээс хамааралгүй эд юмстай

харьцаж, өөрийн мэдлийг тогтоох нөхцөл боломжийг бий болгожээ. Ингэхдээ хөөн хэлэлцэх хугацаанаас хамаарч эзэмшигч нь өмчлөгч болох зохицуулалттай. Ийм байдлаар эзэмшлийг үүсгэсэн бол хууль ёсны эзэмшигчээс эд хөрөнгийг шаардаж болохгүй.

Эзэмшил ийнхүү хууль ёсны байх үндэслэлийг өөртөө агуулснаар эзэмшил, өмчлөл бие даан тусдаа үүсэх, улмаар хоорондоо ялгагдах зааг байхгүй болж, шүүхээр шийдэгдэж байгаа маргаанд ч хуулийг зөв хэрэглэхэд хүндрэл үүсгэх нөхцөл үүсэхээр байна.

• Эзэмшил бие даасан, эд юмстай харилцах үйлдэл, факт болж зохицуулагдаагүйгээс иргэний эрх зүйн судлаачдын дунд ч эргэлзээ бий болж байна. Эзэмшил, өмчлөх эрхийг хооронд адилтгах, "хууль ёсны эзэмшил нь хууль зүйн хувьд эзэмших эрхээр баталгаажин", "... хууль ёсны эзэмшигчийн хувьд тухайн зүйлд нөлөөлөх нөлөөллийг үйлдлийн хувьд бус, харин эрхийн хувьд илүүтэй боломжтой байх" буюу "эзэмшилдээ байгаа зүйлд нөлөөлөх боломж нээлттэй байгаа боловч энэ нь захиран зарцуулах эрхийг бий болгож байгаа зүйл биш" гэж эзэмшлийн өмчлөх эрхийн бүрэлдхүүнд хамаарагдах эзэмших эрхтэй нэгэн ижил үтгээр авч үзэх хандлага гарч байна.

• Эд юмсыг эзэмшиж байгаа этгээд буюу эзэмшигч, өмчийн эрх зүйн харилцааны өмчлөгчийг нэг түвшинд авч үзэх үндэслэл, зохицуулалт нь эд хөрөнгийг эзэмшиж байгаа этгээдийг гуравдагч этгээд өмчлөгч гэж тооцох (Иргэний хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1) зохицуулалт байх ба нэгэнт эзэмшил хууль ёсны үндэслэлээр үүсдэг тул (одоогийн Иргэний хуулийн зохицуулалтаар) ийнхүү эзэмшиж байгаа этгээд нөгөө талаараар өмчлөгч болж тооцогдох үндэслэлтэй байж болно. Эзэмшил хууль ёсных байх, ингэснээр хуулийн дагуу буюу гэрээнд зааснаар үр дагавар, шаардах эрхийг дамжуулан өөртөө өмчлөх эрхийг үүсгэсэн бол үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эрхийг өмчлөх эрхийг үүсгэх зохицуулалтаар өмчлөгч болох, нөгөө талаар шилжүүлж байгаа эзэмшигч-өмчлөгчийг (гуравдагч этгээдийн хувьд өмчлөгч гэж тооцогдох) өмчлөгч биш болохыг мэдээгүй мэдэх боломжгүй байсан бол олж авч байгаа этгээдийг өмчлөх эрхийг шударгаар олж авсан (Иргэний хуулийн 114.1) гэж үзэх үндэслэл бүхий байгаа нь эзэмшлийг хамгаалах зохицуулалт юм. Гэхдээ эд хөрөнгийг шилжүүлж байгаа эзэмшигч нь эзэмшлийг хуульд зааснаар үүсгээгүй, тухайлбал, өмнөх өмчлөгчийн хүсэл зоригоос гадуур гээгдүүлэх, хулгайлах зэрэг байдлаар өөртөө бий (Иргэний хуулийн 91.2.2) болгож, улмаар дараагийн этгээдэд шилжүүлсэн бол тухайн эд хөрөнгийг эзэмшиж байгаа этгээд нь гуравдагч этгээдийн хувьд өмчлөгч гэж тооцогдохгүй ба энэ тохиолдолд хөрөнгийг өмчлөгч нь буцаан шаардах эрхтэй байж болно. Энэхүү зохицуулалтын ялгаа нь эзэмшил хууль ёсны байж шаардлага хангагдах зохицуулалттай шууд

утгаараа холбогдоно.

• Эзэмшлийн ялгаа, онцлог нь өмчлөгч эд хөрөнгөө гаргуулахаар хууль бус эзэмшигчид хандан шаардлага гаргах үед илүүтэй илэрхийлэгдэх ба хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авсан эзэмшигч энэ байдлаа нотолж чадаагүй бол хууль бус буюу бусдынх гэдгийг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан нь шударга эзэмшигч, бусдынх гэдгийг мэдэж байсан, мэдэх боломжтой байсан нь шударга бус эзэмшигч болж, эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэг хүлээнэ. Харин хөрөнгийг шударга болон шударга бус эзэмшигч өөрийн мэдэлд байлгаж, буцаан өгөх хүртэлх хугацаанд үүссэн эзэмшил нь хуульд заасан эзэмшил байж чадаж байгаа эсэхийг нягтлах шаардлагыг зүй ёсоор гаргаж ирдэг нь түүнийг эзэмшиж байсан этгээдийн хөрөнгийг олж авах үеийн субъектив байдалд дүгнэлт хийхтэй уялддаг.

Шударга эзэмшигч нь эд хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь тодорхой байгаа этгээд байдаг ба УДШ-ийн 2009 оны 17 дугаар тогтоолд Иргэний хуулийн 10.11 дүгээр бүлгийн зарим зүйлийг тайлбарлахдаа “шударга эзэмшигч гэдэг нь .. өөрийн эзэмшлийг хууль ёсны гэж ойлгож, эзэмшлээ хууль бус болохыг мэдээгүй буюу мэдэх боломжгүй хууль бус эзэмшигчийг хамааруулж үзэхийг тайлбарласан байгаа нь дээрх хугацаанд үүссэн эзэмшлийг бодит байдлаар бус, харин хөрөнгийг олж авах үедээ тухайн олж авсан этгээд юу гэж үзэж, дүгнэж байсныг, ийнхүү хууль ёсоор олж авсан гэх үндэслэл нь тогтоогдохгүй бол хууль бус эзэмшигч болох үндэслэл гарч байгаа ба нөгөө талаар өөрийгөө хууль ёсоор тодорхой хугацаанд эзэмшиж байсан гэж үздэг тул хөрөнгийг буцаан олгох үед бий болсон үр шимийг өөртөө үлдээх эрхтэй байдаг юм.

Харин шударга бус эзэмшигч өөрийн мэдэлдээ байлгаж байгаа эд хөрөнгө бусдынх болохыг мэдэж байсан, мэдэх боломжтой байдаг учраас тухайн этгээдийн хувьд эзэмшил яригдахгүй.

• Түүнчлэн эдийн болон эдпйн бус баялгийг хууль ёсоор олж авахыг хуульчласан нь хувийн буюу иргэний эрх зүй төдийгүй нийтийн эрх зүйн хүрээнд ч хамааралтай зохицуулалт болсон. Баялгийг олж авах нэг үндэслэл нь нийтийн захиргааны байгууллагын зөвшөөрөл, шийдвэрт үндэслэх, уг үндэслэл нь хөрөнгө олж авах эсэхийг шийдвэрлэх зэрэг байдлаар нийтийн эрх зүйн зохицуулалт шаардагдах, улмаар маргаан нь иргэний маргааны хүрээнээс хальж, захиргааны эрх зүйн маргаан болох нь цөөнгүй байна. Жишээ нь, иргэд орон сууц захиалгаар баруулах, зээлээр орон сууц авах зэрэг нь хэдийгээр иргэний эрх зүйн гэрээний асуудал боловч эрх бүхий байгууллагад үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхээ бүртгүүлснээр

эрх нь баталгаажих зохицуулалтын дагуу эрхээ бүртгүүлэх үед бүртгэлийн байгууллага бүртгэх эрх үүсээгүй (орон сууц барьцааны хөрөнгө болох, өмнөх өмчлөгчийн эрх хүчин төгөлдөр байх г.м олон шалтгааны улмаас) байна гэж татгалзсанаар иргэний шүүхээр үү?, захиргааны шүүхээр үү гэсэн харьяаллын асуудал үүсгэж байгааг анхаарах ёстой.

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

**ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУВЬСГАЛЫН 100 ЖИЛ,
ХУУЛЬ, ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН АЛБАНЫ 100 ЖИЛИЙН ОЙГ
ТОХИОЛДУУЛСАН ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАГА ХУРАЛ БОЛОВ**

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, Хууль зүй, дотоод хэргийн албаны 100 жилийн ойг тохиолдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2011 оны 6 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд “Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг боловсронгуй болгох нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Төрийн ордонд зохион байгуулав.

Хоёр өдөр үргэлжилсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын нээлтэд УИХ-ын гишүүн, Хууль зүйн Байнгын хорооны дарга Д.Одбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд В.Удвал, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд П.Фишер нар мэндчилгээ дэвшүүлж, үг хэлэв.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Ханс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан нар эхний өдрийн хуралдааныг хөтөлж, ХБНГУ-ын Мюнхений их сургуулийн Эрүүгийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, доктор, профессор Б.Шюнеманн “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: хүрсэн амжилт, амжилтыг бататгах алхамууд”, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, Академич С.Нарангэрэл “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага”, МУИС-ын ХЗС-ын Эрүүгийн эрх зүйн тэнхимын эрхлэгч, доктор, профессор Ж.Бямбаа “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн зарим асуудал”, Испани Улсын Мадридын Complutense-ийн их сургуулийн хуулийн сургуулийн багш, профессор Бахмайер Лорена Винтер “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд талууд давамгайлах зарчмыг нэвтрүүлэх нь зохистой юу” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Хоёр дахь өдрийн хуралдааныг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ц.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан нар хөтөлж, ХБНГУ-ын Мюнхений их сургуулийн Эрүүгийн эрх зүйн хүрээлэнгийн

захирал доктор, профессор Б.Шюнеманн “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинэтгэл: хүрсэн амжилт, амжилтыг бататгах алхамууд”, Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимийн шүүгч, доктор Б.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бодит үнэнийг тогтоох болон мэтгэлцэх зарчмыг хуульчлан тусгасан нь”, ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Хууль зүйн факультетын профессор, доктор Л.В.Головко “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны социалист загвараас орчин үеийн загварт шилжих үеийн тулгамдаж буй техникийн асуудлууд: оросын туршлагын эерэг ба сөрөг талууд”, Улсын Ерөнхий Прокурорын туслах МДШБ-ийн газрын дарга Г.Ганзориг “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тулгамдсан асуудал”, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Ж.Ганбаатар “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэтгэх шаардлага, цаашдын чиг хандлага”, Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга Б.Батзориг “Эрүүгийн хэргийн нотлох ажиллагаан дахь хууль ёсны зарчмын хэрэгжилт” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хурлыг дүгнэж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан үг хэлэв.

xxx

“МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, Хууль зүй, дотоод хэргийн албаны 100 жилийн ойг тохиолдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Төрийн ордонд зохион байгуулав.

Төрийн ордны Их танхимд болсон эрдэм шинжилгээний бага хурлын Хүндэтгэлийн

*Хурлын цээр*

хуралдааны нээлтэд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Академич Ж.Амарсанаа, ХБНГУ-ын Бавари муж улсын Ландтагийн гишүүн, Ханнс-Зайделын сангийн дэд тэргүүн, профессор Урсула Мэннле нар үг хэлж, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд В.Удвал хурлыг нээж “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” сэдвээр илтгэл тавив.

Энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь “Монгол Улсын эрх зүйн онол, түүх, сургалт, судалгааны асуудлууд”, “Нийтийн эрх зүйн хөгжлийн асуудлууд”, “Хувийн эрх зүйн хөгжлийн асуудлууд” гэсэн гурван салбар хуралдаанаар үргэлжилж, салбар хуралдаан тус бүрээр үндсэн илтгэлүүд тавьж, хэлэлцүүлэг өрнүүлж, Монгол Улсын эрх зүйн түүхэн хөгжлийг үнэлж дүгнэн, шинэ үеийн эрх зүйн хөгжлийн явц, цаашдын хандлагын талаар хэлэлцэв.

Монгол Улсын үндэсний эрх зүйг хөгжүүлэх, тусгаар тогтнолоо хуульчлан баталгаажуулах, хамгаалахад Хууль зүй, дотоод хэргийн албаны үе үеийн хуульчид, мэргэжилтнүүдийн нөр их хөдөлмөр шингэсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Захиргааны эрх зүйг шинэчилсэн Захиргааны үйл ажиллагааны тухай (шинээр), Захиргааны хариуцлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төслийг боловсруулах, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай зэрэг хуулийг шинэчлэх асуудал ид яригдаж буй үед хууль зүйн шинжлэх ухааны үүднээс эдгээр сэдвийг хэлэлцсэнээрээ ач холбогдолтой юм.

Ийнхүү эрх зүйн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэнээр хууль тогтоомжийг шинэтгэх, хууль хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох, хууль зүйн боловсролын системийг шинэтгэх, иргэдийн эрх зүйн соёлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох талаар санал, зөвлөмж гаргав.

“ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ШИНЭЧЛЭЛ БА ШУДАРГА ЁС” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН БОЛОВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Монгол Улсын Засгийн Газар, Улсын дээд шүүх болон Улсын ерөнхий прокурорын газартай хамтран Ерөнхийлөгчийн Тамгын газраас “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганыг 2011 оны 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулав.

Үндэсний чуулганы зорилго нь шүүх эрх мэдлийн салбарт тулгарч буй асуудал, түүний гарц, шийдэл, шаардлагатай хууль тогтоомж, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хамтдаа тодорхойлох явдал байв.

Үндэсний чуулган агуулгын хувьд өргөн хүрээг хамарч шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага болон хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг сайжруулахад чиглэсэн цаашид авах арга хэмжээг тодорхойлж,

- Шүүхийн тогтолцооны шинэчлэл, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох;

- Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох;

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагын ажиллагааг боловсронгуй болгох;

- Эрхийн хамгаалал, эрх зүйн боловсрол гэсэн 4 үндсэн сэдвээр нийт 15 салбар хуралдаанаар зохион байгуулагдав.

Олон талт дуу хоолой, байр суурь илэрхийлэх үүднээс салбар хуралдаанд тухайн асуудлыг хариуцсан төрийн байгууллагаас гадна, хууль тогтоох байгууллага, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны болон бизнесийн салбарын төлөөллийг үндсэн оролцогчоор оруулж, 15 салбар хуралдаанаар шүүх эрх мэдлийн салбарт тулгарч буй асуудлуудыг хэлэлцэж шаардлагатай хууль тогтоомж, зохион байгуулалтын шинжтэй дэлгэрэнгүй санал, зөвлөмж гаргав.

Үндэсний чуулганд нийт 1600 гаруй оролцогч оролцсоноос 52,9 хувь нь төрийн байгууллага, 19,0 хувь төрийн бус байгууллага, 5,0 хувь нь олон улсын байгууллага, гадаадын дипломат, корпусын төлөөлөл, 4,1 хувь нь хувийн хэвшлийн төлөөлөл байсан ба орон нутгаас 100 төлөөлөгч оролцов. Түүнчлэн Киргизстан улсын Парламентын дэд дарга болон гишүүд, болон АНУ-ын холбооны шүүхийн шүүгч, АНУ-ын мужуудын шүүхийн төвийн төлөөлөгч, мөн Лондон дахь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны шүүхийн шинэчлэлийн хөтөлбөрийн төлөөлөгч, олон улсын хуулийн фирмийн төлөөлөл зэрэг олон улсын өргөн төлөөлөлтэй болов. Үндэсний чуулганыг олон

байгууллагын дэмжлэг, туслалцаатайгаар зохион байгуулсан бөгөөд эдгээрт Нээлттэй Нийгэм Форум, ХААН банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, ELC хуулийн компани, Монголын Хуульчдын Холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Хоган Ловеллс олон улсын хуулийн компани зэрэг дэмжигч байгууллага байв.

“Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал” салбар хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг хүргэж байна.

xxx

Салбар хуралдаан 1

ШҮҮХИЙН БИЕ ДААСАН, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Санал, зөвлөмж

Шүүхийн тогтолцоог шинэчлэх, бие даасан, хараат бус байдлыг хангах, шударгаар хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тогтолцоог бий болгох, холбогдох хууль тогтоомжийг шинээр боловсруулан батлуулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах үндэслэл, шаардлагыг дэмжиж, хуралдаанд оролцогчдын санал, дүгнэлтийг тусгасны үндсэн дээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулж байна:

Нэг. Шүүх, шүүгчийг улс төрийн болон бусад нөлөөллөөс хамгаалах чиглэлээр

- Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Шүүхийн тухай багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, нэн даруй батлуулах;
- Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2-т заасан “шүүгчээс шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй албан тушаалтнууд”-ыг Шүүхийн тухай хуулиар нарийвчлан зохицуулах, ялангуяа “ерөнхий шүүгч” болон “дээд шатны шүүгч”-дээс хараат бус байх асуудлыг нэмж тусгах;
- Төрийн өндөр албан тушаалтан болон бусад эгсгээдээс хэрэг маргааны талаар хуульд зааснаас гадуур шүүхийн удирдлага, шүүгч нартай уулзах, үүрэг даалгавар, чиглэл өгөх, үндэслэлгүйгээр шүүгчдийн зэрэг дэвийг бууруулах, шагнаж, урамшуулах болон тэдний гэр бүлд төрөл бүрийн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар хязгаарлаж, энэ чиглэлд эрүүгийн

болон сахилгын хариуцлагыг чангатгах;

- Шүүгчид нэр дэвшигчид тавигдах шалгуурыг хуульчилж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тусгай журмаар сонгон шалгаруулж, нэр дэвшүүлсэн хүнийг шүүгчээр Ерөнхийлөгч томилохоос татгалзах хууль зүйн үндэслэлүүдийг Шүүхийн тухай хууль тогтоомжид нарийвчлан тусгах.

Хоёр. Шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангах чиглэлээр

- Шүүхийн төсвийн улсын төсөвт эзлэх хувийг (хамгийн багадаа 2 хувиас багагүй байхаар) хуульчлан тогтоож, жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдэж байх аргачлалыг хуульчилсан бусад улс орны сайн туршлагыг судалж хэрэгжүүлэх;

- Тухайн жилийн шүүхийн төсвийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэгтгэн боловсруулж, Засгийн газрын саналыг харгалзан үзсэний үндсэн дээр УИХ-д өргөн мэдүүлдэг байх журмыг хуульчлан тогтоох;

- Шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангах талаарх УИХ, Засгийн газрын хүлээх үүрэг, хариуцлагыг Төсвийн тухай хууль, бусад хуульд нарийвчлан тусгах.

Гурав. Шүүх доторх шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулах чиглэлээр

- Шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагааг зохион байгуулалт, чиг үүргийн хувьд бүрэн тусгаарлах чиглэлээр хууль тогтоомжийг шинэчлэх;

- Дээд шатны болон Ерөнхий шүүгчээс доод шатны шүүхийн шүүгчийн шийдэх гэж буй хэрэг, маргааны талаар үүрэг чиглэл, зөвлөгөө өгөх, шалган туслах ажиллагаа явуулахыг хуулиар хориглох;

- Ерөнхий шүүгч нарын хэрэгжүүлж байгаа захиргааны удирдлагыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх;

- Ерөнхий шүүгч нарыг томилох, ажлыг нь үнэлэх, улираан томилох шалгуурыг нарийсгаж, ялангуяа өөрийн удирдлага дор байгаа шүүгчдийн шийдвэрт нөлөөлөх оролдлогыг гаргуулахгүй байхад чиглэсэн шалгуурыг хуульчлан тогтоох;

- Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг өөрчлөх.

Дөрөв. Шүүхийн бие даасан захиргааг төлөвшүүлэх чиглэлээр

- Шүүхийн ерөнхий зөвлөлийг бусад эрх мэдлийн байгууллагаас төдийгүй шүүхээс тусгаар бие даасан бүтэц, зохион байгуулалт, удирдлагатай орон тооны хараат бус, мэргэжлийн байгууллага болгох;

- Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахуйц чиг үүргийг хэрэгжүүлэх эрх хэмжээтэй, ялангуяа шүүхийн

төсвийн асуудлаар Засгийн газар, Улсын Их Хурлын хуралдаанд өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөөр дамжуулан оролцох механизмыг хуульчлах;

- Шүүхийн төсвийн зарцуулалтын талаар шүүгчдийн зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнаж, шүүхийн өмнө хариуцлага хүлээх асуудлыг хуульчлах;

- Сонгон шалгаруулалт хийгдэж, Ерөнхийлөгч шүүгчээр томилсноос хойш шүүгчийн мэргэжлийн ёс зүй, хуульд заасан шалгуурыг хангаагүй үндэслэл хожим илэрвэл Шүүхийн ерөнхий зөвлөл ямар хэмжээнд хариуцлага хүлээлгэхийг хуулиар тодорхой болгох.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хамтын удирдлагын бүрэлдэхүүн нь улс төрөөс хамгийн бага хамааралтай шүүгчдийг тусгай журмаар сонгон шалгаруулах, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн зүгээс хууль зүйн салбарын нэр хүндтэй эрдэмтдийн дундаас тус тус нэг хүнийг санал болгох журмыг нэвтрүүлэх, албан тушаалаараа ордог субъектэд Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгчийг нэмж оруулах.

xxx

“ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран зохион байгуулсан “Эрдэс баялгийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд болов. Тус хуралд ХЗҮХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Б.Гүнбилэг, МУИС-ын ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор Т.Мэндсайхан, “Эрдэнэт” ХХК-ны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын тэргүүлэх менежер, доктор И.Идэш, ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч, докторант Ж.Соёлмаа, МУИС-ын ХЗС-ийн ахлах багш, докторант С.Энхмэнд, МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант М.Мөнхбат нар илтгэл тавьж, эрдэс баялгийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, түүний хөгжил, уг салбар дахь олон улсын гэрээ, хэлэлцээр, хөрөнгө оруулалтын гэрээ, уул уурхайн нөхөн сэргээлтийн эрх зүйн орчин зэрэг асуудлыг хөндөн хэлэлцүүлж, харилцан санал солилцов.

Хуралд оролцогчид эрдэс баялаг, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны асуудалд хуульчдын дуу хоолой нэн шаардлагатай байгааг дурьдаж, цаг үеэ олсон, чухал хэрэгцээтэй хурал болсоныг дүгнэсэн юм. Түүнчлэн энэ чиглэлээр ажилладаг эрдэм шинжилгээ, сургалтын болон практикийн хуульчид хамтарч ажиллах нь зүйтэй гэдэгт санал нэгтэй байв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**Өндөр хурдны интернет бүхий
компьютерийн лаборатори
иргэдэд үйлчилж байна.
1 цаг интернет ашиглахад 400 төгрөг.**

**Мөн та манай танхимыг түрээслэн
сургалт, уулзалт зохион байгуулах боломжтой.**

**Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
315735 дугаарын утсаар лавлана уу.**

**Хаяг: Улаанбаатар 210646, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн,
205 тоот танхим**